switchasia GRANTS PROGRAMME

Европын Холбоо санхүүжүүлэв

SUSTAINABLE PLASTIC RECYCLING IN MONGOLIA

MIRIM INNOVATION & CONSULTANT

# МОНГОЛ УЛС ДАХЬ ДАХИН БОЛОВСРУУЛСАН ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2022 оны 8 сар

*Энэхүү тайланг МИРИМ Консалтант ХХК Европын Холбооны Switch-Asia хөтөлбөрийн санхүүжилттэй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл”-ийн хүрээнд Каритас Чех Репаблик байгууллагын захиалгаар боловсруулан гаргав. Энэхүү тайланд орсон агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.*

# АГУУЛГА

Талархал....... 3

Товчилсон үгийн жагсаалт ....... 4

Графикийн жагсаалт ....... 5

Хүснэгтийн жагсаалт ....... 7

Судалгааны багийн гишүүд....... 8

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ....... 9

1.1. Судалгааны үндэслэл....... 9

1.2. Судалгааны зорилго, зорилт ....... 10

1.3. Судалгааны хамрах хүрээ, түүвэр ....... 10

ХОЁР. ДАХИН БОЛОВСРУУЛСАН ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА ....... 13

2.1. Олон улсад хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах, хэрэглэх нөхцөл байдлын судалгаа ....... 13

2.2. Хууль, эрх зүйн орчны судалгаа....... 17

ГУРАВ. ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА....... 19

3.1. Хуванцар дахивар авах цэгүүд, зах зээлд эзлэх хувь, өрсөлдөөн ....... 19

3.2. Хуванцар дахин боловсруулдаг үйлдвэр, тэдгээрийн хүчин чадал, зах зээлд эзлэх хувь....... 20

3.3. Шинэ бүтээгдэхүүний хэрэгцээ, төлөвлөгөө ....... 25

3.4. Хуванцар дахин боловсруулж хийсэн бүтээгдэхүүний зах зээлийн орчин ....... 29

3.5. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний талаар хуванцар бүтээгдэхүүн импортлогч, борлуулагчдын мэдлэг, ойлголт ....... 32

3.6. Хуванцар бүтээгдэхүүний импортын нөхцөл байдал....... 35

3.7. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний зураглал ....... 39

ДӨРӨВ. ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТИЙН СУДАЛГАА....... 46

4.1. Өрхийн хэрэглэгчийн хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ, зан төлөв....... 46

4.2. Байгууллагын хэрэглэгчийн хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ, зан төлөв ... 57

НЭГДСЭН ДҮГНЭЛТ....... 67

САНАЛ ЗӨВЛӨМЖ....... 72

АШИГЛАСАН МАТЕРИАЛ....... 76

ХАВСРАЛТ....... 77

# Талархал

МИРИМ Консалтант ХХК-ийн судалгааны баг Каритас Чех Репаблик ТББ-ийн захиалгаар “Монгол улс дахь дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа” сэдэвт зөвлөх үйлчилгээг 2022 оны 6 дугаар сарын 8-аас 2022 оны 9 дүгээр сарын 16 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны зорилго нь дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн холбогдох үзүүлэлтүүдийг тодорхойлох замаар дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний дотоодын зах зээл дэх боломжийг үнэлэхэд чиглэсэн.

Судалгааны дизайн, арга зүй боловсруулалт, мэдээлэл бүрдүүлэлт, дүн шинжилгээ, тайлан боловсруулах хэсэгт мэргэжлийн өндөр ур чадвар бүхий зөвлөх, судлаачдын баг нягт хамтран ажиллалаа.

Зөвлөх үйлчилгээнд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан төслийн менежер Ч.Мижидсүрэн, төслийн зохицуулагч Б.Санчиргарав, зөвлөх Т.Энхдөл танд талархал илэрхийлж байна. Түүнчлэн зөвлөх үйлчилгээний мэдээлэл цуглуулах үе шатад идэвхтэй дэмжиж, хамтран ажилласан холбогдох байгууллагууд, мэргэжилтнүүд, мэдээлэл цуглуулсан талбарын судлаач, судалгаанд оролцсон оролцогч нартаа онцгойлон талархал илэрхийлье.

Судалгааны үр дүн сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд бүрэн нийцнэ гэдэгт итгэж байна.

Судалгааны баг

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| ЗГ | Засгийн газар |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| УБ | Улаанбаатар |
| УИХ | Улсын их хурал |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| БЖДҮ | Бичил, жижиг, дунд үйлдвэр |
| ЖДҮ | Жижиг, дунд үйлдвэр |
| ХХААХҮЯ | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам |
| КЧР | Каритас Чех Репаблик |
| МХХДБҮХ | Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо |
| ЭЗХАХБ | Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (Organization for Economic Cooperation and Development) |

## Графикийн жагсаалт


*График 1. Дэлхийн нийт хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ, сая тонноор ............... 13*

*График 2. Дэлхийн нийт хуванцар бүтээгдэхүүний хэрэглээн дэх түүхий эдийн орц 13*

*График 3. Дэлхий нийтийн хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн талаарх прогноз, сая тонноор ............................................................................................... 14*

*График 4. Нэг хүн ноогдох хуванцар хог хаягдал хамгийн их үүсгэдэг ТОП 10 улс (нэг хүнд ноогдох килограмаар, 2016 он) ........................................................................ 15*

*График 5. Дахин боловсруулах зорилгоор цуглуулсан хуванцар хог хаягдлын нийт хэмжээнд эзлэх хувь, байршлаар, 2019 он ............................................................. 15*

*График 6. Хуванцар түүхий эд авдаг цэгийн тоо, байршлаар, 2021 он...................... 19*

*График 7. Хуванцар түүхий эд авдаг цэгийн эзлэх хувь, n=67, 2021 он ...................... 19*

*График 8. Хуванцар дахиварт зарцуулж буй зардлын хистограм, n=67, 2021 он....... 20*

*График 9. Үйл ажиллагаа явуулсан жилийн хистограм, n=18.................................... 22*

*График 10. Ажилчдын тооны хистограм, n=18 .......................................................... 22*

*График 11. Хүчин чадлын ашиглалтын түвшин, n=18................................................ 23*

*График 12. Анхдагч түүхий эд авдаг улс, n=18 .......................................................... 24*

*График 13. Өрсөлдөгч байгууллагын бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмж, үнийн талаар үнэлгээ, n=18....................................................................................................... 25*

*График 14. Өөрийн нийлүүлж буй бүтээгдэхүүний талаар сэтгэл ханамж, n=18....... 25*

*График 15. Шинэ бүтээгдэхүүн гаргах болсон шалтгаан .......................................... 26*

*График 16. Дахин боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, нөөц боломжийн талаар хуванцар импортлогч, борлуулагчдын ойлголт, n=18................................................ 32*

*График 17. Дахин боловсруулсан бүтээгдэхүүн импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадварын талаар борлуулагчдын үнэлгээ, n=18......................................................... 33*

*График 18. Хүйс, хувиар .............................................................................................. 46*

*График 19. Нас, хувиар................................................................................................ 46*

*График 20. Боловсролын түвшин, хувиар .................................................................. 46*

*График 21. Өрхийн сарын дундаж орлого, хувиар ...................................................... 47*

*График 22. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг хэр сайн мэдэх, хувиар 47*

*График 23. Хуванцар хог хаягдлыг дахин ашигладаг болон ангилан, ялгадаг эсэх, хувиар ........................................................................................................................ 48*

*График 24. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний талаарх мэдээлэл авдаг суваг, хувиар ............................................................................................................... 49*

*График 25. Дотоодын дахин боловсруулсан бүтээгдэхүүний талаарх мэдээлэл хангалттай эсэх, хувиар .............................................................................................. 50*

*График 26. Цаашид хуванцар бүтээгдэхүүний хэрэглээгээ өөрчлөх эсэх, хувиар....... 52*

*График 27. Хаана үйлдвэрлэсэн хуванцар бүтээгдэхүүнийг ихэвчлэн худалдан авдаг болох, хувиар...................................................................................................52*

*График 28. Хуванцар бүтээгдэхүүнийг ямар хэрэгцээндээ ихэвчлэн хэрэглэдэг болох, хувиар .......................................................................................................52*

*График 29. Хуванцар бүтээгдэхүүнийг ихэвчлэн хаана хэрэглэдэг эсэх, хувиар ........53*

*График 30. Хуванцар бүтээгдэхүүн худалдан авахдаа чухалчилдаг зүйлс, хувиар.....53*

*График 31. Хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авах шийдвэр гаргахад нөлөөлдөг хүчин зүйлс, хувиар.......................................................................................54*

*График 32. Нэмүү үнээр худалдан авах боломжтой эсэх, хувиар ...............................54*

*График 33. Хуванцар бүтээгдэхүүнийг хэрэглэх тохиолдолд ямар түүхий эдээр үйлдвэрлэснийг илүүд үзэх вэ?, хувиар ...........................................................54*

*График 34. Хуванцар бүтээгдэхүүн болон сав баглаа боодлыг хэрэглэж дуусаад ямар арга хэмжээ авдаг эсэх, хувиар .......................................................................55*

*График 35. Хуванцар бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаадаа хэр сэтгэл хангалуун болох, хувиар...................................................................................................55*

*График 36. Дотоодын дахин боловсруулах үйлдвэрүүд хуванцар бүтээгдэхүүний сайжруулах шаардлагууд, хувиар.........................................................................56*

*График 37. Монголд үйлдвэрлэсэн хуванцар бүтээгдэхүүнийг хэрэглэх сонирхол, % 56*

*График 38. Хуванцар бүтээгдэхүүнийг хаанаас ихэвчлэн худалдан авдаг болох, хувиар .......................................................................................................57*

*График 39. Дотоод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний үнэлгээ, Дундаж (1 бага, муу; 5 их, сайн) ...........................................................62*

*График 40. Дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авахдаа гол анхаардаг зүйлс, хувиар..................................................62*

*График 41. Дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний хэрэглээний сэтгэл ханамжийн түвшин, хувиар ..................................................63*

*График 42. Цаашид дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн худалдан авч хэрэглэх хүсэл сонирхол байгаа эсэх, хувиар .................63*

*График 43. Дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний сайжруулах шаардлагатай зүйлс, хувиар..........................................................63*

*График 44. Дотоодын хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нартай дараах чиглэлд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх сонирхол байгаа эсэх, хувиар .............................64*

*График 45. Хог хаягдлаа ангилж, боловсруулж буй байдал болон журам, төсөвт тусгагдсан эсэх, хувиар.................................................................................65*

## Хүснэгтийн жагсаалт


*Хүснэгт 1. Судалгааны түүврийн хэмжээ ........ 11*

*Хүснэгт 2. Боловсруулж буй дахиврын төрөл, n=18 ........ 21*

*Хүснэгт 3. Боловсруулсан бүтээгдэхүүний нэр, төрөл, n=18 ........ 21*

*Хүснэгт 4. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний нийлүүлэлтийн суваг, n=18 ........ 28*

*Хүснэгт 5. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын байршил, n=18 ..... 29*

*Хүснэгт 6. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын суваг, n=18 ........ 29*

*Хүснэгт 7. Бүтээгдэхүүнээ борлуулах гэрээтэй харилцагчдын тоо, n=17 ........ 30*

*Хүснэгт 8. Бүтээгдэхүүний үнэ тогтоох зарчим, n=18 ........ 30*

*Хүснэгт 9. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын нэмэгдүүлэхийн тулд хийх үйл ажиллагаа, n=18 ........ 31*

*Хүснэгт 10. Импортын хуванцар бүтээгдэхүүний гарал үүсэл, суурь үнэлгээ ........ 35*

*Хүснэгт 11. Импортоор хуванцар бараа, материал оруулдаг ТОП компаниуд, 2019 он ........ 36*

*Хүснэгт 12. АПУ ХХК-ын импортолсон гол бараа, материалын нэр төрөл, хэмжээ, 2019 он ........ 37*

*Хүснэгт 13. Витафит-Инвест ХХК-ын импортолсон гол бараа, материалын нэр төрөл, хэмжээ, 2019 он ........ 37*

*Хүснэгт 14. Импортын бараа, материалын нэр төрөл, хэмжээ, 2019 он ........ 38*

*Хүснэгт 15. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг хэр сайн мэдэх, үндсэн үзүүлэлтээр харьцуулсан, хувиар ........ 48*

*Хүснэгт 16. Хуванцар хог хаягдлыг дахин ашигладаг болон ангилан, ялгадаг эсэх, үндсэн үзүүлэлтээр харьцуулсан, хувиар ........ 49*

*Хүснэгт 17. Хуванцар бүтээгдэхүүний өрхийн хэрэглээ, хувиар ........ 50*

*Хүснэгт 18. Хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн боломж, тоогоор ........ 51*

*Хүснэгт 19. Хуванцар бүтээгдэхүүн татан авалтын мэдээлэл, хувиар ........ 59*

*Хүснэгт 20. Байгууллагын хэрэглэгчдийн хэрэглэж буй бүтээгдэхүүний давуу болон сул талууд ........ 59*

*Хүснэгт 21. Байгууллагын хэрэглэгчдэд шаардлагатай дотоодын үйлдвэрүүдийн үйлдвэрлэх боломжит импортыг орлох бүтээгдэхүүний жагсаалт ........ 60*

# Судалгааны багийн гишүүд

Уг зөвлөх үйлчилгээг МИРИМ Консалтант ХХК-ийн судалгааны баг хийж гүйцэтгэв. Энэхүү тайлан нь зөвхөн судалгаанд үндэслэсэн дүгнэлтээр баталгаажсан, судалгааны багийн байр суурийг илэрхийлнэ.

Судалгааны үндсэн багт дараах мэргэжилтнүүд ажилласан.

**Үндсэн баг**

| | |
|---|---|
| Багийн ахлагч | Б.Баясгалан /Төрийн удирдлагын доктор, дэд профессор/ |
| Багийн гишүүн | Д.Мөнхцэцэг /Эдийн засгийн ухааны магистр/ |
| Багийн гишүүн | Д.Батжаргал /Гидро инженер, бакалавр/ |
| Багийн гишүүн | Н.Янжинпагма /Социологийн ухааны магистр/ |
| Багийн гишүүн | Л.Мөнхбат /Социологийн ухааны магистр/ |
| Багийн гишүүн | Б.Баасанхүү /Олон улсын харилцаа, Англи хэлний орчуулагч бакалавр/ |

# НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

## 1.1. Судалгааны үндэслэл

Сүүлийн жилүүдэд Монгол улсын хүн ам өсөж, эдийн засаг тэлж, үйлдвэрлэл, үйлчилгээний шинэ салбарууд хөгжихийн зэрэгцээ иргэдийн хэрэглээ өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор хог хаягдлын тоо хэмжээ, нэр төрөл жилээс жилд нэмэгдэж байна.

2021 оны байдлаар Улаанбаатар хотын нийт хог хаягдлын хэмжээ 1.4 сая тонн байгаагаас нийт дахивар түүхий эдийн хэмжээ нэг жилд 124,028 тонн байна. Нийт хог хаягдлын 8.9%-ийг дахин боловсруулж байна (Д.Батжаргал, 2021).

Монгол улсад 2.2 сая тонн хоёрдогч түүхий эд гардаг бол, үүнээс 1.4 сая тонн Улаанбаатарт ялгарч байна. Нийт хог хаягдлын 3-5%-ийг Монгол улсын хэмжээнд дахин боловсруулж байгаа бол, харин Улаанбаатар хотын хэмжээнд 8.9%-ийг дахин боловсруулж байна. 2021 оны байдлаар хог хаягдал дахин боловсруулдаг 40 үйлдвэр, ялган бэлтгэдэг 160 гаруй цэг, түүнд 1500 гаруй ажилтан ажиллаж байна. Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг статистикийн ангиллаар резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл гэсэн салбарт ангилж тоон мэдээллийг нэгтгэдэг. 2020 оны байдлаар салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 14.1 тэрбум төгрөг, борлуулалтын хэмжээ 15.5 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос хоёр дахин буурсан үзүүлэлт юм (ХХААХҮЯ, 2022).

Нийт хог хаягдлын 50 орчим хувь нь дахин боловсруулах боломжтой боловч Улаанбаатар хотын хувьд дахин боловсруулж, экспортолж байгаа хог хаягдлын хэмжээ нийт хог хаягдлын 8 орчим хувь байна. Харин ангилан ялгасан хуванцар бүтээгдэхүүний хаягдлын 6%-ийг дахин боловсруулсан байна (Байгаль орчны мэдээллийн төв, 2017).

МУ-ын Засгийн Газрын зүгээс хог хаягдлын цогц менежментийг бий болгох, түүнийг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх, хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах, түүнээс төрөл бүрийн түүхий эд, нөөц үйлдвэрлэх замаар хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, эцсийн устгах хог хаягдлын хэмжээг бууруулах талаар бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд хийгдсэн нэг томоохон ажил нь тогтвортой хөгжлийн бодлоготой уялдуулж, олон улсад тавигддаг шаардлагад нийцүүлэн Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталсан юм.

2017 оны 12-р сарын 31-ээс БНХАУ байгаль орчны бохирдлыг бууруулах, сөрөг нөлөөг арилгах, нийтийн эрүүл мэндийг сахин хамгаалах зорилгоор түүхий эд, материалаар ашиглагддаг хог хаягдлыг импортоор авахыг хориглосон мэдэгдэл гаргасан. Энэ хүрээнд 8 төрлийн хуванцар хог хаягдал, ялгаж ангилаагүй 1 төрлийн цаасны хог, 11 төрлийн нэхмэлийн материалын хог хаягдал, 4 төрлийн төмрийн хог зэрэг нийт 24 төрлийн хог хаягдлыг импортоор оруулахыг хориглосон байна. Үүнд PET хуванцрын хаягдал савыг импортоор оруулахыг хориглоогүй, гэхдээ импортоор оруулах хэмжээнд хязгаарлалт тавьсан байна.

БНХАУ-ын энэхүү шийдвэрээс үүдэн дэлхийн олон орны төдийгүй Монгол улсын хувьд хуванцар бүтээгдэхүүний хаягдлыг хэрхэн зайлуулах талаар томоохон сорилттой

тулгарч байна. Тодруулбал, бид хуванцрын хаягдлаа булшлах[1], эсвэл дахин боловсруулах гэсэн сонголтын өмнө тулж ирээд байна.

Иймд хуванцрын хаягдлыг олон улсын стандартын дагуу дотооддоо дахин боловсруулж, хуванцрын хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах нь хамгийн оновчтой гарц юм. Монгол улсад хуванцар дахин боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй БЖДҮ-ийн өрсөлдөх чадвар, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн боломжуудыг тодорхойлохын тулд "Монгол улс дахь дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа"-г хийх зайлшгүй шаардлага тулгарч байгаа бөгөөд энэхүү ажлыг уг зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгэлээ.

### 1.2. Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь Монголын дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл байдал, өрсөлдөөний нөхцөл байдал, зах зээлийн өсөлтөд тулгарч буй бэрхшээл, зах зээлийн хэмжээ, багтаамж, боломж, эрсдэлд дүн шинжилгээ хийж дүгнэх, уг салбарт үйл ажиллагаа эрхэлж буй болон эрхлэх БЖДҮ-үүдэд бүтээгдэхүүн хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд дэмжлэг болохуйц санал боловсруулахад оршино.

Дээрх зорилгод үндэслэн дараах **зорилтуудыг** дэвшүүлсэн. Үүнд:

1. **Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний НИЙЛҮҮЛЭЛТИЙН судалгааг хийх**: Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хүчин чадал, нөөц боломж, зах зээлийн эзэмшил, өрсөлдөөн, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ зэргийг нарийвчлан судлав.
2. **Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний ЭРЭЛТИЙН судалгааг хийх:** Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн багтаамж, хэмжээ, өсөлтийн хувийг тодорхойлж, цаашдын эрэлт хэрэгцээ, худалдан авагчийн зан төлөвийг тодорхойлов.
3. **Нөхцөл байдлын судалгааг хийх:** Энэ хүрээнд дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний хууль, эрх зүйн орчин, одоогийн хэрэгжиж буй хөтөлбөр, олон улсын судалгаанд дүн шинжилгээ хийж, экспорт, импортын хэмжээг тооцох, гол бүтээгдэхүүн дээр чанар, үнийг харьцуулахад чиглэв.
4. **Мэргэжлийн зөвлөгөө, санал зөвлөмжийг санал болгоно.** Судалгааны үр дүнд тулгуурлан одоогийн байгаа бүтээгдэхүүнийг сайжруулах, борлуулалтыг нэмэгдүүлэх болон шинээр гаргах бүтээгдэхүүний нэр төрөл, тэдгээрийн зах зээлийн боломж, хязгаарлалтыг тодорхойлж, шаардлагатай санал зөвлөмжийг боловсруулав.

### 1.3. Судалгааны хамрах хүрээ, түүвэр

Булган аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийг хамруулан судалгааг гүйцэтгэсэн. Судалгааны мэдээллийг 2022 оны 6 сарын 25-аас 7 сарын 8-ны хооронд цуглуулсан.

[1] Хуванцар савны бүрэн задрах хугацаа хамгийн багадаа 450 жил байдаг.

*Зураг 1. Түүврийн хамрах хүрээ*




## Судалгааны түүврийн хэмжээ

Судалгааны зорилтот бүлэг нь хуванцар дахин боловсруулах БЖДҮ-үүд, түүнтэй ижил төстэй хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон импортлогчид, хуванцар бүтээгдэхүүн хэрэглэгчид, холбогдох төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоо, бусад оролцогч талуудыг хамруулав. Нийт 445 респондентоос мэдээллийг цуглууллаа. Түүврийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 1. Судалгааны түүврийн хэмжээ*

| № | Судалгааны оролцогч талууд | Байршил | | Нийт авсан тоо |
|---|---|---|---|---|
| | | УБ хот | Булган аймаг | |
| 1 | Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн хэрэглэгчдийн асуулга судалгаа – Эцсийн хэрэглэгч | 335 | 50 | 385 |
| 2 | Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн хэрэглэгчдийн асуулга судалгаа – Байгууллагын хэрэглэгч | 20 | - | 20 |
| 3 | Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч БЖДҮ-үүд | 19 | - | 19 |
| 4 | Хуванцар бүтээгдэхүүн импортлогчид, борлуулагчдын ярилцлага судалгаа | 18 | - | 18 |
| 5 | Холбогдох төрийн байгууллагуудын мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан ярилцлага судалгаа хийх | 2 | - | 2 |
| 6 | Мэргэжлийн холбоо, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, зөвлөхүүд | 1 | - | 1 |
| | **Нийт** | | | **445** |

Тоон судалгаанд эцсийн хэрэглэгчид буюу 385 өрх тус бүрээс нэг хүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгож судалгаанд хамруулав. Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан өрхийн мэдээллийн дагуу 2021 оны байдлаар Булган аймаг, Улаанбаатар

хотын хэмжээнд 431,596 өрх бүртгэлтэй байна[2]. Түүврийн хэмжээг тогтоохдоо эх олонлогоос 95 хувийн итгэх түвшинтэй, ±5 хувийн алдааны хязгаартайгаар тооцоход түүврийн хэмжээ **385** байна.

Чанарын судалгааны хүрээнд холбогдох яам, агентлаг, мэргэжлийн холбоо, БЖДҮ-үүд, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, ижил төрлийн бүтээгдэхүүн импортлогчид, холбогдох төсөл хөтөлбөрийн нийт **60** удирдлага болон мэргэжилтэнтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн. Ганцаарчилсан ярилцлага судалгаанд оролцох удирдлага болон мэргэжилтнүүдийг захиалагч талтай тохиролцсоны үндсэн дээр сонгож, ярилцлагыг цахим болон биечилсэн хэлбэрээр зохион байгуулав. Мөн хоёрдогч мэдээллийн шинжилгээний хүрээнд 2015-2019 оны гаалийн мэдээ, мэргэжлийн холбоод, холбогдох төрийн байгууллагуудаас гаргасан статистик мэдээллийг ашиглан шинжилгээ хийлээ.

[2] ҮСХ, Мэдээллийн сан, Хүн ам (1212.mn)

# ХОЁР. ДАХИН БОЛОВСРУУЛСАН ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

## 2.1. Олон улсад хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах, хэрэглэх нөхцөл байдлын судалгаа

Хуванцар нь дэлхийн аж үйлдвэрийн хамгийн том инновацын нэг боловч үйлдвэрлэлийн өсөлт болон хуванцар хог хаягдлын буруу устгалтаас улбаалан хүний эрүүл мэнд, байгаль орчин, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлт, далайн бохирдол, биологийн олон янз байдал, химийн бохирдол зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

Сүүлийн 30 жилийн хугацаанд хуванцрын хэрэглээ дөрөв дахин өссөн нь хөгжиж буй зах зээлийн өсөлтөөс шалтгаалжээ. Дэлхийн хуванцрын үйлдвэрлэл, хэрэглээ 2000-2019 оны хооронд хоёр дахин нэмэгдэж, 460 сая тоннд хүрсэн байна[3]. 2011 оноос хойш дэлхийн нийт хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ тасралтгүй нэмэгдэх (График 1)-ийн хэрээр хуванцар бүтээгдэхүүний хэрэглээнд дахин боловсруулсан, хоёрдагч түүхий эдийн ашиглалт нэмэгдсэн (График 2) байна. Тодруулбал, 2011 онд дэлхий нийтээрээ 363 сая тонн хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба үүний 95.6%-ыг анхдагч түүхий эд, 4.4%-ыг дахин боловсруулсан хуванцар ашиглаж үйлдвэрлэж байжээ. Найман жилийн дараа 2019 онд 460 сая тонн буюу 2011 онтой харьцуулахад 26.6%-аар их хэмжээтэй хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Үүний 6.3%-ыг дахин боловсруулсан, хоёрдагч түүхий эдээр үйлдвэрлэсэн нь 2011 онтой харьцуулахад хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дахин боловсруулсан түүхий эд ашиглах хандлага нэмэгдсэнийг илтгэнэ.

*График 1. Дэлхийн нийт хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ, сая тонноор*




*График 2. Дэлхийн нийт хуванцар бүтээгдэхүүний хэрэглээн дэх түүхий эдийн орц*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *ЭЗХАХБ-ын өгөгдлийн сан*

[https://stats.oecd.org/ViewHTML.aspx?QueryId=111202&vh=0000&vf=0&il=blank&lang=en&vcq=00&HideMetadataLink=1&HideMemberSelectionLink=1&CustomExtractionMessage=1](https://stats.oecd.org/ViewHTML.aspx?QueryId=111202&vh=0000&vf=0&il=blank&lang=en&vcq=00&HideMetadataLink=1&HideMemberSelectionLink=1&CustomExtractionMessage=1)

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас гаргасан таамаглалаар дэлхий нийтийн хуванцрын үйлдвэрлэл, хэрэглээ цаашид жилд дунджаар 2.58%-аар тасралтгүй өсөж, одоогийн түвшинтэй (2022 онтой) харьцуулахад 2040 онд

[3] (Organization for Economic Cooperation and Development, 2022)

1.6 дахин, 2050 онд 2.1 дахин, 2060 онд 2.6 дахин өсөх төлөвтэй байна. (График 3) Хуванцрыг сав баглаа, боодол, барилга, автомашины үйлдвэрлэл, тавилга, тоглоом, гутал, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, цахилгаан болон электрон барааны үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зэрэг олон салбарт ашигладаг. Энэ байдал нь хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон хэрэглээ дэлхий даяар хурдтай нэмэгдэх шалтгаан болж байна.

*График 3. Дэлхий нийтийн хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн талаарх прогноз, сая тонноор*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *Database of Organisation for Economic Co-Operation and Development (OECD)* *https://stats.oecd.org/viewhtml.aspx?datasetcode=PLASTIC_USE_V2_1&lang=en*

Хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ нэмэгдэхийн зэрэгцээ хуванцар хог хаягдлын хэмжээ өсөж байна. 2000-2019 оны хооронд дэлхийн хуванцар хог хаягдлын хэмжээ хоёр дахин нэмэгдэж, 353 сая тоннд хүрчээ. Хуванцар хог хаягдлын бараг гуравны хоёр нь таваас доош жилийн ашиглалтын хугацаатай хуванцраас гардаг бөгөөд 40% нь сав баглаа боодол, 12% нь өргөн хэрэглээний бараа, 11% нь хувцас, нэхмэл эдлэлээс бүрддэг байна. Хуванцар хог хаягдлын ердөө 9% нь дахин боловсруулагддаг (дахин боловсруулахын тулд 15%-ийг цуглуулдаг хэдий ч түүний 40% нь боловсруулалтын явцад хаягдал болдог). Хуванцар хог хаягдлын 19%-ийг шатааж, 50%-ыг хогийн цэгт хаяж, үлдсэн 22% нь хог хаягдлын менежментийн системээс зайлсхийж, хяналтгүй хогийн цэгт хаягдах, ил уурхайд шатааж эсвэл хуурай газрын болон усан орчинд хаягддаг байна[4].

2016 оны байдлаар АНУ, Энэтхэг, Хятад, Бразил, Индонези, ОХУ, Герман, Нэгдсэн Вант Улс, Мексик, Япон улсууд хамгийн их хэмжээний хуванцар хог хаягдал үүсгэсэн байна. Гэхдээ эдгээр улсын хувьд нэг хүнд ноогдох хаягдлын хэмжээ зарим оронтой харьцуулахад их биш[5]. Дэлхийн хог хаягдлын тайланд нэг хүнд ноогдох хуванцар хог хаягдал хамгийн ихээр үүсгэдэг улсууд, нэг хүнд ноогдох хог хаягдлын хэмжээг килограммаар илэрхийлэн График 4-д үзүүлэв. Жагсаалтыг Микронези, Бермуд, Палау улсууд тэргүүлж байгаа бол Монгол Улс 9-р байрт эрэмбэлэгдсэн байна. **Манай улс хуванцар бүтээгдэхүүний хэрэглээг бууруулж, хуванцар хог хаягдлыг дахин**

[4] (Organization for Economic Cooperation and Development, 22 Feb 2022)

[5] (Plastic Pollution by Country 2022, 2022)

**боловсруулж, ногоон эдийн засгийн бүтцийг бий болгох чиглэлд дорвитой арга хэмжээ авах шаардлагатай нь энэ жагсаалтаас харагдаж байна.** (World Population Review, 2022)

*График 4. Нэг хүн ноогдох хуванцар хог хаягдал хамгийн их үүсгэдэг ТОП 10 улс (нэг хүнд ноогдох килограммаар, 2016 он)*




***Эх сурвалж:*** *World Population Review, Plastic Pollution by Country 2022*
*https://worldpopulationreview.com/country-rankings/plastic-pollution-by-country*

Сүүлийн жилүүдэд хуванцар хог хаягдлыг дахин боловсруулахад Европын Холбооны улсууд том ахиц дэвшил гаргаж байна.

*График 5. Дахин боловсруулах зорилгоор цуглуулсан хуванцар хог хаягдлын нийт хэмжээнд эзлэх хувь, байршлаар, 2019 он*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *Database of OECD*

*https://stats.oecd.org/ViewHTML.aspx?QueryId=111223&vh=0000&vf=0&il=blank&lang=en&vcq=00&HideMetadataLink=1&HideMemberSelectionLink=1&CustomExtractionMessage=1*

График 5-аас харахад 2019 оны байдлаар дахин боловсруулах зорилгоор дэлхий нийтээр цуглуулсан хуванцар хог хаягдлын 50%-ыг Европын Холбооны улсууд, 26%-ыг Ази, Евро Ази, Номхон далайн бүс нутгийн улсууд, 15%-ыг АНУ, Канад, Мексик, Латин Америкийн орнууд, үлдсэн 9%-ыг Африкийн орнууд цуглуулсан байна.

Европын Холбооны улсууд дотроос Швейцарь, Швед, Австри, Герман, Бельги, Нидерланд улсууд жилийн нийт хог хаягдлынхаа 50%-аас давсан хэсгийг дахин боловсруулж, бусад улсад сайн туршлага болж байна[6].

Дахин боловсруулах чиглэлээр Европын орнууд тэргүүлж байгаа бөгөөд хог хаягдлыг ялгах, дахин боловсруулахыг дэмжих урамшууллын бодлого, гялгар уут, сүрэл зэрэг нэг удаагийн бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах арга хэмжээг анхлан хэрэгжүүлжээ. Эдгээр оронд хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах стандартыг мөрдүүлэх эхний үе

[6] (Global Recycle, 2022)

шатанд төрийн зохицуулалт чухал ач холбогдолтой байв. Тодруулбал, стандартыг дагаагүй бол өндөр торгууль, шийтгэл ноогдуулж байжээ. Хамгийн хүнд тохиолдолдоо торгууль нь 11,000 ам.доллароос ч давж байсныг Global Recycle веб хуудсанд тэмдэглэсэн байна. Бодлогын үр дүнг Швейцарь улсын статистикаар илэрхийлбэл, тэд шилний хаягдлын 93%, лаазны хаягдлын 91%, хуванцар савны хаягдлын 83%-ыг тус тус дахин боловсруулдгаас гадна дахин боловсруулах боломжгүй материалыг шатаах зуух ажиллуулж, айл өрхийг эрчим хүчээр хангаж байна[7].

Латин Америкийн орнуудаас хог хаягдлын боловсруулалтаар тэргүүлэгч Швед улс, Их Британи, Итали, Норвеги, Ирланд зэрэг улсаас хог импортолж, хог хаягдлыг эрчим хүч болгох 32 станцаар дамжуулан 950’000 байшинг халааж, 260’000 өрхийг бүхэлд нь эрчим хүчээр хангадаг байна. Хог хаягдлыг эрчим хүч болгон хувиргах үйлдвэрүүдийг Норвеги улс мөн нэвтрүүлж, цаашид бусад улсаас хог импортлох түвшинд хүрчээ[8].

БНХАУ нь дэлхийн хуванцар хог хаягдлын 56 хүртэлх хувийг дахин боловсруулдаг байсан бөгөөд ингэхдээ АНУ-ын хог хаягдлын 60%, Европын хог хаягдлын 70%, Ази болон бусад улсуудаас хог хаягдал импортолдог байжээ. Азийн төдийгүй дэлхийн хог хаягдлын үйлдвэрлэл, дахин боловсруулалтын бизнесийн гол төвд тоглогч байсан БНХАУ 2017 оны 7-р сард Женевт болсон Дэлхийн худалдааны байгууллагын хурал дээр Бээжин дэлхийн улс орнуудаас авдаг хуванцар болон цаасан хог хаягдлын импортоо бууруулахаа зарласан бөгөөд хориг 2018 оны эхээс хэрэгжиж эхэлсэн. Энэ шийдвэр нь дэлхий дахинд хог хаягдал дахин боловсруулалтын системд бүрэн өөрчлөлт оруулж, хог хаягдлын менежментийн шинэ эрин үеийг эхлүүлсэн байна. АНУ, Канад, Европ, Япон, Өмнөд Солонгос зэрэг дэлхийн улсуудын тал хувь нь шинэ хогийн цэг хайхаас өөр аргагүй байдалд хүрчээ. БНХАУ-ын байрыг орлож, Турк, Малайз зэрэг улс бусад улсаас хог импортлох хэмжээгээ эрс нэмэгдүүлсэн байна. БНХАУ хог хаягдлын импортдоо хориг тавьсан хэдий ч хог хаягдлыг дахин боловсруулж, үрлэн бэлдцийг импортлохыг хараахан хориглоогүй. Зарим мэдээллийн эх сурвалж БНХАУ-ын үрлэн бэлдцийн импорт эрс өссөн ба үрлэн бэлдцийг хилээр нэвтрүүлэхдээ стандарт мөрдсөн эсэхийг хатуу хянаж байгаа талаар мэдээлжээ. Түүнчлэн БНХАУ-ын эрх баригчид импортын үрлэн бэлдцэд тавих стандарт, дүрэм, журмыг боловсруулж байгаа юм байна[9].

### Хэсгийн дүгнэлт:

- ✓ Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ тасралтгүй нэмэгдсэн ба цаашид ч нэмэгдсээр байх төлөвтэй байна. Улс орнууд байгаль орчны бохирдол, хүний эрүүл мэндийн асуудлаас үүдэж, хуванцар хог хаягдлыг дахин боловсруулж, ашиглан, хог хаягдалгүй ногоон эдийн засгийн бүтцийг бий болгохын төлөө хичээж байна.
- ✓ Дэлхийн нийтийн хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл хэрэглээ жилээс жилд өсөхийн зэрэгцээ хуванцар бүтээгдэхүүний орцод анхдагч түүхий эдийн эзлэх хувь буурч, хоёрдогч түүхий эдийн эзлэх хувь нэмэгджээ.
- ✓ Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах бизнесийн гол тоглогч БНХАУ 2018 оны

---

[7] (Global Recycle, 2022)

[8] (Global Recycle, 2022)

[9] (Construction and Demolition Recycling, 2018)

эхнээс хог хаягдлын импортоо зогсоосноос үүдэж, дэлхийн ихэнх улс орон хуванцрын хог хаягдлаа хэрхэх талаар сорилттой тулгарсан байна. Турк, Малайз улсууд БНХАУ-ын байр суурийг орлож, бусад улсаас хог импортлон дахин боловсруулах ажлыг эрчимтэй хийж байна.

- ✓ Швейцар, Швед, Австри, Герман, Бельги, Нидерланд зэрэг Европын Холбооны улсууд хуванцар хог хаягдлынхаа 50-аас илүү хувийг дахин боловсруулж, дэлхий нийтэд сайн туршлага болж байна. Эдгээр улсууд хог хаягдал үүсгэхгүй байхад анхаарч, нэгэнт үүссэн хаягдлыг дахин боловсруулж, дахин боловсруулах боломжгүй хэсгийг шатаан эрчим хүч гаргаж, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийг эрчим хүчээр ханган, хог хаягдалгүй ногоон эдийн засгийн бүтцийг бүрдүүлжээ.
- ✓ Монгол улс нэг хүнд ноогдох хуванцар хог хаягдлын хэмжээгээр 2016 онд дэлхийн ТОП 10 улсаас 9-д жагссан байна. Бид боломжит хамгийн бага хэмжээгээр хог хаягдал үүсгэх, үүссэн хог хаягдлыг дахин боловсруулж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд хөнөөл багатайгаар нөөцийг үр ашигтай ашигладаг ногоон эдийн засгийн бүтцийг бүрдүүлэх шаардлагатай байна.

## 2.2. Хууль, эрх зүйн орчны судалгаа

Судалгааны энэ хэсгийн мэдээллийг Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Монголын хог хаягдлын дахин боловсруулах үндэсний холбоо болон бусад оролцогч талуудаас тодруулсан. Монгол улсад “Хог хаягдлын тухай хууль”-ийг 2017 оноос баталж, мөрдөж эхэлсэн ба энэхүү хууль, түүнийг даган гарсан 16 журам, заавар, аргачлал боловсруулагдан хэрэгжиж байна. Каритас Чех Репаблик болон хамтрагч байгууллагуудын хэрэгжүүлж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл”-ийн хүрээнд 2022 онд “Хуванцар хаягдлын зохицуулалтыг сайжруулах өнөөгийн эрхзүйн орчны судалгаа”-г хийж гүйцэтгэсэн.

Энэхүү судалгаагаар зөвхөн оролцогч талуудаас БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН А-429/257 дугаар тушаалын хэрэгжилт хангагдаж байгаа эсэхийг тодруулахыг зорьсон. Судалгаанд оролцогчид А-429/259 тоот тушаалын хавсралтаар баталсан “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах” заалтын талаар оролцогчдын дийлэнх мэдэхгүй, огт сонсоогүй байна. Энэ удаагийн судалгааны үр дүн 2022 оны “Хуванцар хаягдлын зохицуулалтыг сайжруулах өнөөгийн эрхзүйн орчны судалгаа”-ны үр дүнтэй адил байна.

*Шигтгээ 1. 2022 оны “Хуванцар хаягдлын зохицуулалтыг сайжруулах өнөөгийн эрхзүйн орчны судалгааны үр дүн*

**Хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах**: Хуванцар сав суулга, түүхий эд болон нийлэг уут түүний түүхий эд үйлдвэрлэх, импортлох үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна гэж оруулсан. ***Энэ заалт нь төдийлөн хэрэгжиж эхлээгүй, эхлэл, санаачилга төдий байгаа бөгөөд*** хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг үр дүнтэй хийснээр хог хаягдлыг багасгах, дахин боловсруулах ажил эрчимтэй явагдах болно.

Эх сурвалж: *Хуванцар хаягдлын зохицуулалтыг сайжруулах өнөөгийн эрхзүйн орчны судалгаа*

Мөн энэ судалгаанд оролцогч талуудын хувьд хуванцар хог, хаягдлын талаарх хууль, эрх зүйн орчин тодорхой түвшинд бүрдсэн хэмээн үзэж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй байгааг онцолж байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй адил байна.

*Шигтгээ 2. 2022 оны "Хуванцар хаягдлын зохицуулалтыг сайжруулах өнөөгийн эрхзүйн орчны судалгааны үр дүн*

**Хог хаягдлын эрхзүйн орчин үндсэндээ бүрдсэн байна.** Эдгээр хууль эрхзүйн орчны ихэнх заалтууд өнөөгийн шаардлагыг хангаж, зах зээлийн зарчимд нийцсэн гэж үзэж байна.

Эх сурвалж: *Хуванцар хаягдлын зохицуулалтыг сайжруулах өнөөгийн эрхзүйн орчны судалгаа*

Төрийн байгууллагуудын хувьд дахивар болон хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг хариуцсан бүтэц зохион байгуулалт, тогтолцоо бүрдээгүй байна гэдгийг онцолж байлаа. Хууль, эрхзүйн орчны тухайд дараах асуудлууд тулгарч байна. Үүнд:

- **Хууль эрх зүй орчныг сайжруулах:** Судалгаанд хамрагдсан мэргэжлийн холбооны зүгээс 2017 онд батлагдсан "Хог хаягдлын тухай хууль"-д хэрэгжилтийн мониторинг хийж хэрэгжилтийг сайжруулах шаардлага байгааг онцолж байна. Хуулийн хэрэгжилтийг сайжруулахын тулд бохирдуулагчийн төлбөр тогтоож нэхэмжлэх, бохирдол үүсгэж буй хэмжээнээс хамааруулан төлбөрийг ноогдуулах шаардлага байгааг онцолсон. Мөн "Эко хаягдлын тухай хуулийг" баталж хуванцар хог хаягдал дахин боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудыг дэмжих шаардлагатай байна.
- **Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт:** Дотоодын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дотоодын хэрэгцээгээ хангах боломжтой, үйлдвэрлэл сайн хөгжсөн цахилгааны хоолой, бохирын хоолой зэрэг бүтээгдэхүүн дээр импортын татварыг нэмэгдүүлэх боломжийг судлах шаардлагатай. Дотоодын хэрэгцээг хангаж байгаа бүтээгдэхүүнийг нарийвчилсан байдлаар тогтоож Сангийн яамны дэргэдэх тарифын зөвлөлөөр хэлэлцүүлж хуванцар хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн бүтээгдэхүүнтэй ижил төрлийн импортын бүтээгдэхүүнд өндөр татвар тогтоох шаардлага байна. Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага байна.
- **Стандарт боловсруулах**: Үйлдвэрүүдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнд стандарт байхгүйгээс хамааран чанар харилцан адилгүй байгааг тэмдэглэж байсан. Тиймээс үйлдвэрүүдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгох, гарал үүслийн гэрчилгээ олгох шаардлага байна.
- **Хууль эрх зүй орчны хэрэглээг нэмэгдүүлэх:** ААНБ-уудын хувьд хуулийн талаар мэдлэг дутмаг байдлаас аюултай хог хаягдлаа ангилан ялгахгүй байна.

# ГУРАВ. ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА

Энэ дэд хэсэгт манай улсын дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний нийлүүлэлтийн талын нөхцөл байдлыг шинжилж, хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хүчин чадал, нөөц боломж, түүхий эд, зах зээлийн эзэмшил, өрсөлдөөн, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ зэргийг нарийвчлан судална.

## 3.1. Хуванцар дахивар авах цэгүүд, зах зээлд эзлэх хувь, өрсөлдөөн

2021 онд “Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо (МХХДБҮХ)”-ноос цуглуулсан мэдээллийн сангаас шүүхэд улсын хэмжээнд дахивар хүлээн авдаг бүртгэлтэй 150 цэг, бүртгэлгүй 14 цэг, нийт 164 цэг байна.

МХХДБҮХ-д бүртгэлтэй нийт 150 дахивар хүлээн авах цэгийн 67 цэг буюу 44.7% нь хуванцар түүхий эд худалдаж авдаг. Хуванцар түүхий эд худалдаж авдаг цэгүүдийн 43 нь буюу **64.2% нь Сонгинохайрхан болон Баянзүрх дүүргүүдэд байрладаг байна.** Хан-Уул дүүрэгт 11, Баянгол дүүрэгт 5, Чингэлтэй дүүрэгт 4 цэг байрласан бол Налайх, Сүхбаатар, Багануур дүүргүүдэд 1-2 цэг л үйл ажиллагаа явуулж байна. (График 6)

*График 6. Хуванцар түүхий эд авдаг цэгийн тоо, байршлаар, 2021 он*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *МХХДБҮХ*

*График 7. Хуванцар түүхий эд авдаг цэгийн эзлэх хувь, n=67, 2021 он*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *МХХДБҮХ*

Хуванцар түүхий эд авдаг цэгүүд PET, HDPE, PE гэсэн 3 төрлийн хуванцар дахиврыг түгээмэл худалдаж авдаг байна. 67 цэгийн 98.5% нь PET буюу хатуу хуванцрыг, 83.6% нь PE гялгар уутыг, 73.1% нь HDPE буюу зөөлөн хуванцар авч, дахин боловсруулах үйлдвэрт өгдөг байна. (График 7)

2021 оны байдлаар цэгүүд **PET хатуу хуванцрын килограмм тутмыг дунджаар 191 төгрөгөөр, HDPE зөөлөн хуванцрын килограмм тутмыг дунджаар 457 төгрөгөөр, PE гялгар уутны килограмм тутмыг дунджаар 578 төгрөгөөр тус тус худалдаж авсан байна.**

Хуванцар авдаг 67 цэгийн 3 цэг буюу 4.5% нь зөвхөн тодорхой тогтсон үйлдвэрт нийлүүлдэг гэсэн бол 22 цэг буюу 32.8% нь тогтсон үйлдвэрт өгдөггүй, зөвхөн өөрсдийн сонголтоор дахиврыг борлуулдаг гэсэн байна. Үлдсэн 42 цэг буюу 62.7% нь тогтсон үйлдвэрт нийлүүлэх болон өөрсдийн сонголтоор тухайн цаг үед нь өөр үйлдвэрт нийлүүлэх аль аль арга замыг уян хатан сонгодог байна.

МХХДБҮХ-д бүртгэлтэй хуванцар дахивар авдаг цэгүүдийн дахиварт зарцуулсан 2021 оны жилийн нийт зардлын хистограмыг График 8-д үзүүлэв. Хуванцар дахивар хүлээн авдаг 67 цэгийн 67.3% нь хуванцар дахивар худалдан авахад жилд 30-аас бага сая төгрөг зарцуулдаг, 25.9% нь 30-50 сая төгрөг зарцуулдаг бол 7.5% буюу 5 цэг 60-аас их сая төгрөг зарцуулдаг байна. **Энэ нь хуванцар дахивар хүлээн авах зах зээлд олон жижиг, цөөн том аж ахуйн нэгжүүд зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байгааг илтгэнэ.**

*График 8. Хуванцар дахиварт зарцуулж буй зардлын хистограм, n=67, 2021 он*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *МХХДБҮХ*

## 3.2. Хуванцар дахин боловсруулдаг үйлдвэр, тэдгээрийн хүчин чадал, зах зээлд эзлэх хувь

2021 оны байдлаар МХХДБҮХ-д хуванцар хог хаягдал дахин боловсруулдаг 24 үйлдвэр бүртгэлтэй байна[10]. Тэдгээрээс 19 үйлдвэрийг түүвэрлэн асуумж авч, хуванцар дахин боловсруулах үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдал, үйлдвэрүүдийн хүчин чадал, зах зээлд эзлэх хувь зэргийг шинжиллээ. Энэ 19 үйлдвэрээс нэг үйлдвэр нь үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй ба цаашид ямар бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх төлөвлөгөөтэй байгааг судлах зорилгоор уг үйлдвэрлэлийн мэдээллийг судалгааны үр дүнг нэгтгэхэд ашиглана. Харин судалгааны гол үр дүнг тооцохдоо үйл ажиллагаа явуулж буй 18 үйлдвэрийн мэдээлэлд тулгуурлана. Үлдсэн 5 үйлдвэр нь одоогоор үйл ажиллагаа явуулахгүй, түр болон бүр зогссон тул хассан.

Судалгаанд хамрагдсан 18 үйлдвэр ойролцоогоор 9.3 жил үйл ажиллагаа явуулсан, дунджаар 18 ажилтантай, 1.07 тэрбум төгрөгийн жилийн дундаж орлого олдог ажээ. Эдгээр үйлдвэрүүд 2021 оны байдлаар **нийт 19.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон ба үүний 31.3%-ыг нэг үйлдвэр дангаараа эзэлсэн байна.** Дараагийн том долоон үйлдвэр нийлээд зах зээлийн нийт борлуулалтын 47.4%-ыг эзэлсэн бол үлдсэн буюу хамгийн жижиг 10 үйлдвэрлэгчид зах зээлийн нийт борлуулалтын 21.3% нь хуваарилагдсан байна.

**Эдгээр 18 үйлдвэр нийлээд жилд ойролцоогоор 18500 тонн хуванцар дахин боловсруулах чадалтайгаас 2021 оны байдлаар дунджаар 52.4%-ыг ашиглажээ.** Тодруулбал, зах зээлийн борлуулалтын орлогоор тэргүүлэгч ганц үйлдвэрлэгч өөрийн хүчин чадлыг 85%-тай ашигласан бол үлдсэн үйлдвэрлэгчид хүчин чадлынхаа 50.3%-ыг дунджаар ашиглажээ. Эндээс үзэхэд 2021 онд үйлдвэрлэгчид нийтдээ ойролцоогоор 10000 тонн хуванцар бүтээгдэхүүн дахин боловсруулжээ.

Жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүний хүчин чадлын хувьд судалгаанд хамрагдсан 18 үйлдвэрийн 5 нь 500 тонноос багыг, мөн 5 нь 501-999 тонныг, 3 нь 1000-1500 тонныг, үлдсэн 5 нь 1501 тонноос ихийг үйлдвэрлэх боломжтой байна. Эндээс үзэхэд **уг зах**

[10] (Дагмар Волошинова, Томаш Фойтик, 2021 оны XI сар)

**зээлд янз бүрийн хүчин чадалтай, том, жижиг ялгаатай үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байгаа нь харагдана.**

Хүснэгт 2-д дахин боловсруулж буй дахиврын төрөл бүрээр үйлдвэрлэгчийн тоо, нийт түүвэрт эзлэх хувийг харуулав. **Үйлдвэрлэгчид HDPE, LDPE, PE төрлийн хуванцар дахин боловсруулах нь элбэг байна.** Тодруулбал, судалгаанд хамрагдсан 18 үйлдвэрийн 66.7% нь HDPE, мөн хувь нь LDPE, 55.6% нь PE төрлийн дахивар боловсруулдаг. Харин 33.3% нь PP төрлийн хуванцар дахин боловсруулдаг бол PVC, PET, PPR төрлийн хуванцар боловсруулдаг үйлдвэрийн тоо цөөн байна.

*Хүснэгт 2. Боловсруулж буй дахиврын төрөл, n=18*

| № | Дахиврын төрөл | Үйлдвэрлэгчийн тоо | Эзлэх хувь, n=18 |
|---|---|---|---|
| 1 | HDPE | 12 | 66.7% |
| 2 | LDPE | 12 | 66.7% |
| 3 | PE | 10 | 55.6% |
| 4 | PP | 6 | 33.3% |
| 5 | PVC | 2 | 11.1% |
| 6 | PET | 1 | 5.6% |

***Өгөгдлийн эх сурвалж: Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022***

Судалгаанд хамрагдсан 18 үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр, төрлийг Хүснэгт 3-д нэгтгэн үзүүлэв. **Хамгийн түгээмэл үрлэн бүтээгдэхүүн нь HDPE, LDPE байна.** Тодруулбал, 18 үйлдвэрлэгчийн 7 нь буюу 38.9% нь HDPE, LDPE үрэл, 3 нь буюу 16.7% нь PP, PE үрэл үйлдвэрлэдэг бол PET, хуруу шилэн бэлдэц, PVC үрлийг тус бүр нэг нэг үйлдвэрлэгч үйлдвэрлэдэг ажээ. Гаалийн ерөнхий газрын 2019 оны статистикаас харахад манай улсад 4422.2 тонн HDPE үрэл импортоор орсон байна. Харин хуванцар дахин боловсруулагч үйлдвэрлэгчдээс авсан судалгаагаар тэд жилд нийтдээ 1000 орчим тонн HDPE үрэл боловсруулан гаргадаг гэжээ. Эндээс үзэхэд **манай улсын хуванцар дахин боловсруулагчид үйлдвэрлэлийн хэмжээгээ одоогийнхоос 3 дахин нэмэгдүүлж, импортыг орлох үрлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж, зах зээлийн багтаамж байгаа нь харагдана.**

*Хүснэгт 3. Боловсруулсан бүтээгдэхүүний нэр, төрөл, n=18*

| № | Бүтээгдэхүүний төрөл | Бүтээгдэхүүний нэр | Үйлдвэрлэгчийн тоо | Эзлэх хувь, n=18 |
|---|---|---|---|---|
| 1 | Үрэл, бэлдэц | HDPE, LDPE үрэл | 7 | 38.9% |
| 2 | | PP, PE үрэл | 3 | 16.7% |
| 3 | | PET, хуруу шилэн бэлдэц | 1 | 5.6% |
| 4 | | PVC үрэл | 1 | 5.6% |
| 5 | Эцсийн бүтээгдэхүүн | Хогны уут | 6 | 33.3% |
| 6 | | Цахилгааны хамгаалалтын хоолой | 3 | 16.7% |
| 7 | | Цэвэр, бохир усны хоолой | 3 | 16.7% |
| 8 | | Хуванцар сандал | 2 | 11.1% |
| 9 | | Траншейний таг | 2 | 11.1% |
| 10 | | Багцлагч уут /пакет/ | 2 | 11.1% |
| 11 | | Барилгын хэв хашмал | 1 | 5.6% |
| 12 | | Гэр ахуйн бараа, сувенир | 1 | 5.6% |
| 13 | | Вакум цонх | 1 | 5.6% |
| 14 | | Поддон (тавиур) | 1 | 5.6% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **15** | | Хайс, шон | 1 | 5.6% |
| **16** | | Нүхэн жорлонгийн битүүмжтэй сав | 1 | 5.6% |
| **17** | | Худаг | 1 | 5.6% |
| **18** | | Шилжүүлэгч таг | 1 | 5.6% |
| **19** | | Хуванцар шал | 1 | 5.6% |
| **20** | | Канистр /1,5,10 литр/ | 1 | 5.6% |

***Өгөгдлийн эх сурвалж:*** *Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

**Үйлдвэрлэгчид хамгийн түгээмэл үйлдвэрлэдэг эцсийн бүтээгдэхүүн нь хогны уут байна.** Тодруулбал, судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн 33.3% буюу гурван үйлдвэр тутмын нэг нь хогны уут үйлдвэрлэдэг гэжээ. Гаалийн ерөнхий газрын мэдээллээр 2019 онд манай улсад тухайн оны үнээр тооцоход 899.6 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний хогны уут импортоор орж ирсэн ба үүний 0.5%-д хүрэхгүй мөнгөн дүнтэй хогны уутыг дотооддоо үйлдвэрлэж байна.

Цахилгааны хамгаалалтын хоолой, цэвэр, бохир усны хоолой үйлдвэрлэдэг тус бүр гурван үйлдвэр байна. **2019 оны статистикаар манай улсын хилээр 29.54 тэрбум төгрөгний цахилгааны хамгаалалтын хоолой, цэвэр, бохир усны хоолой зэрэг төрөл бүрийн хоолой импортлогдсон байна. Үүнийг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж хуванцар дахин боловсруулдаг үйлдвэрүүдэд бий.**

Мөн хуванцар сандал, траншейний таг, багцлагч уутыг тус бүр хоёр үйлдвэр үйлдвэрлэдэг бол барилгын хэв хашмал, гэр ахуйн бараа, сувенир, вакум цонх, хуванцар подон, хайс, шон, нүхэн жорлонгийн битүүмжтэй сав, худаг, шилжүүлэгч таг, хуванцар шал, канистр зэргийг үйлдвэрлэдэг гэж тус бүр нэг нэг үйлдвэр мэдээлсэн байна. 2019 онд сандал гэсэн ангиллаар 8.6 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний, төрөл бүрийн багцлагч гэсэн ангиллаар 1.026 гаруй тэр бум төгрөгтэй тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн импортлогдсон байна. Эдгээр жишээнээс харахад **манай улсад импортоор орж буй бүтээгдэхүүнийг дотооддоо дахин боловсруулж, үйлдвэрлэвэл импортыг орлох боломж бүрэн байгааг илтгэнэ.**

График 9-д дүрсэлсэн судалгаанд хамрагдсан 18 үйлдвэрийн үйл ажиллагаа явуулсан жилийн хистограмаас харахад нийт үйлдвэрийн 27.8% нь таваас цөөн жил, нийт үйлдвэрийн 66.7% нь арваас цөөн жил үйл ажиллагаа явуулсан байна. **Энэ нь сүүлийн 10 жилд хуванцар бүтээгдэхүүн дахин боловсруулах салбарт компаниуд түрэн орж, энэ зах зээл өргөжиж байгааг илтгэнэ.**

*График 9. Үйл ажиллагаа явуулсан жилийн хистограм, n=18*




*График 10. Ажилчдын тооны хистограм, n=18*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

**Харьцангуй шинэ үйлдвэрүүд учраас ажилчдын тоо мөн харьцангуй цөөн** байгаа нь График 10-аас харагдана. 18 үйлдвэрийн 11 нь буюу 61.1% нь 19-өөс цөөн ажилчинтай, 6 нь буюу 33.3% нь 20-34 ажилчинтай байхад үлдсэн нэг үйлдвэр 35-аас олон ажилчинтай байна.

*График 11. Хүчин чадлын ашиглалтын түвшин, n=18*




***Өгөгдлийн эх сурвалж:** Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

Судалгаанд хамрагдсан үйл ажиллагаа явуулж байгаа 18 үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтын түвшинг График 11-д дүрсэллээ. 2021 онд 18 үйлдвэр хүчин чадлынхаа дунжаар 52.4%-ыг ашиглажээ. Харин тэдний 2 нь буюу 11.1% нь хүчин чадлынхаа 90%-ээс дээш хувийг ашиглаж байна. 16.7% нь 70%-89%-ыг, мөн 16.7% нь 50%-69%-ын хүчин чадлаа ашиглаж байгаа бол үлдсэн хэсэг нь 49%-аас бага ашиглалтын түвшинтэй байна.

Дээрх статистикаас харахад **хуванцар дахин боловсруулах үйлдвэрүүд хүчин чадлаа бүрэн дүүрэн ашигладаггүй, ашиглалтын түвшин хангалтгүй байна. Цаашид эдгээр үйлдвэр тоног төхөөрөмж, хүчин чадлаа бүрэн ашиглавал хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэх бүрэн боломжтой байна.**

Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүд хуванцар дахивар ашиглан дараах төрлийн хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

Материал, тоног төхөөрөмж:



Арматур хөндийрүүлэгч, сэнс, BarL (босоо арматурын зай баригч), том болон жижиг гэр, цахилгааны хамгаалалтын хоолой, цэцэрлэгт хүрээлэнгийн сандал, суулгалтын профиль, булан холбогч, хуванцар хоолой, канистр, бохирын ус зайлуулах хоолой, PVC МП70 хүрээ, HDPE МП70 дарагч, PVC МП70 салхивч, PVC МП70 хөндлөвч, шон, холбогч, ивүүр, хиймэл дөрвөлж, бетон зуурмагийн химийн нэмэлт, барьцлагч хальс, кольцо, бохирын худгийн иж бүрдэл, өндөрсгөгч, ороогч хальс, вакум цонхны бэлдэц, ундаа, усны гадна талыг багцлагч, замын хашлага бордюр/ гэх мэт.




Хоол, хүнсний хэрэгсэл:

Хогны уут, сандал, ахуйн тосол, био хогны уут гэх мэт.



Эрүүл ахуйн бүтээгдэхүүн:



Шээсний шинжилгээний сав,

нүхэн жорлонгийн доторлогоо гэх мэт.

Хагас боловсруулсан үрэл, түүхий эд:

PP, HDPE, LDPE гэх мэт.



Судалгаанд оролцсон үйл ажиллагаа явуулж байгаа 18 үйлдвэрлэгчийн 6 нь буюу 33.3% нь зөвхөн гэрээт үйлдвэрлэгч буюу байгууллагаас хоёрдогч түүхий эдээ авдаг байхад 2 нь буюу 11.1% нь зөвхөн дахивар нөөц цуглуулах цэгээс түүхий эдээ татдаг байна. Бусад 12 үйлдвэрлэгч дахивар нөөц цуглуулах цэгээс болон гэрээт үйлдвэрлэгч, байгууллагаас эсвэл өөр дэлгүүрээс өөрсдөө цуглуулж авах, хувиараа хог ялгаж өгдөг хүмүүсээс авах зэрэг арга замаар үйлдвэрлэлийн түүхий эдээ цуглуулдаг байна. 18 үйлдвэрлэгч жилд нийтдээ 8737.2 тонн, нэг үйлдвэр дунджаар 485.4 тонн хоёрдогч түүхий эд худалдаж авдаг ба 13 нь буюу 72.2% нь дунджаас доогуур хэмжээгээр, үлдсэн 5 үйлдвэр буюу 18.2% нь дунджаас дээгүүр хэмжээгээр худалдан авалт хийдэг байна.

*График 12. Анхдагч түүхий эд авдаг улс, n=18*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

18 үйлдвэрийн 8 нь буюу 45% нь химийн нэмэлт бодис, цэвэр хуванцар үрэл зэрэг анхдагч түүхий эдийг гадаад улсаас импортолдоггүй. Харин тэдний 6 нь буюу 33% нь зөвхөн БНХАУ-аас, 2 нь буюу 11% зөвхөн БНСУ-аас, мөн тооны үйлдвэрлэгчид БНХАУ болон БНСУ-аас анхдагч түүхий эдийг импортолдог байна. Эдгээр үйлдвэрлэгчдийн өгсөн мэдээлэлд тулгуурлаж, импортоор орж ирсэн анхдагч нийт түүхий эдийн хэмжээг тооцвол жилд 1541.5 тонн болох ба үүний 48.4%-ыг БНХАУ-аас, 51.6%-ыг БНСУ-аас импортолдог аж.

Эндээс үзэхэд **БНХАУ-тай харьцуулахад БНСУ-аас цөөн үйлдвэрлэгч илүү их хэмжээгээр анхдагч түүхий эд импортолсон байна.**

Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн өрсөлдөгч байгууллагын болон өөрийн нийлүүлсэн бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмж, үнийн талаар сэтгэл ханамжтай байдлыг График 15 болон График 16-д харьцуулан дүрслэв. Тэдний 39% нь өрсөлдөгчийн бүтээгдэхүүнийг сайн гэж үнэлсэн бол 90% нь өөрийн нийлүүлсэн бүтээгдэхүүнийг маш сайн, сайн гэж үнэлсэн байна. Тэд өрсөлдөгчийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад өөрийн бүтээгдэхүүнд илүү сэтгэл ханамжтай байна.

*График 13. Өрсөлдөгч байгууллагын бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмж, үнийн талаар үнэлгээ, n=18*




*График 14. Өөрийн нийлүүлж буй бүтээгдэхүүний талаар сэтгэл ханамж, n=18*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

### 3.3. Шинэ бүтээгдэхүүний хэрэгцээ, төлөвлөгөө

Судалгаанд оролцогчдын 50% нь одоогийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанарыг сайжруулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бол үлдсэн хэсэг нь ямар нэгэн бодож, төлөвлөсөн зүйлгүй, эсвэл байгууллагын нууц учраас бүтээгдэхүүний нэр төрөл олшруулах эсэх талаар хариулах боломжгүй гэжээ. Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх сонирхлоо илэрхийлсэн үйлдвэрлэгчид **цахилгааны хамгаалалтын хоолой, бортого, логотой тор, бохирын хуванцар хоолой, ус зайлуулах шугамын хоолой, хүрз, түмпэн сав, хэв, малын усалгааны ванн** зэрэг бүтээгдэхүүнийг шинээр нэмж үйлдвэрлэх хүсэлтэй байна. Харин тэдний 15 нь буюу 83.3% нь одоогийн үйлдвэрлэлийн шугам, шат дамжлагыг нэмэгдүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөтгөх сонирхолтой байна. Үйлдвэрлэлийн шугам, шат дамжлагыг нэмэгдүүлэхэд санхүүжилтийн асуудлыг шийдэх шаардлагатайгаас гадна хуванцар боловсруулж, цутгах хэвтэй болбол бүх төрлийн хуванцар бүтээгдэхүүн хийх боломжтой гэж үйлдвэрлэгчид үзжээ. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, хүчин чадлаа сайжруулж чадвал хуванцар болон модны дахиврын үртэс хоёрыг онцгой технологиор хольж, гадна **террасны шалнууд, гадна сеткан зөөлөвч хийх, цахилгаан хоолой холбогч, дотроо төмөртэй хоолой, унтраалгын разетканы хроп, өвсний уяа, цэвэр, бохир усны хоолой, өргөн хэрэглээний уут, шуудай, өөр олон төрлийн кабел, хуванцар хоолойн дагалдах хэрэгслүүд, агааржуулалтын хоолой, гүний худаг, барилгын хавтан, шат, байшингийн хуванцар дээвэр, хөдөө аж ахуйд хашааны шон** зэрэг олон бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж үүсэх юм байна.

Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн ойрын таван жилд дараах бүтээгдэхүүнийг шинээр үйлдвэрлэж, зах зээлд нэвтрүүлэхээр бизнес төлөвлөгөөндөө тусгасан байна. Үүнд:

- ✓ Бохирын дотоод шугам, бохирын худгийн өргөн хоолой хийхээр үйлдвэр ашиглалтад оруулахаар ажиллаж байна.
- ✓ Байшингийн хуванцар дээвэр, одоогийн ашиглаж буй хар паниарыг орлохуйц барилгын хуванцар хавтан хийнэ.
- ✓ Өөрийн дахин боловсруулах үйлдвэртэй болохоор ажиллаж байна.

- ✓ Цахилгааны хоолой холбогч муфт, дотроо төмөртэй хоолой, унтраалгын разетканы хроп, өвсний уяа үйлдвэрлэнэ.
- ✓ Хөдөө аж ахуйн хашааны шон, хүрз, өргөн хэрэглээний шуудай хийнэ.
- ✓ Өөрсдийн үйлдвэрлэж буй хоолойны холбох хэрэгслүүдийг үйлдвэрлэх, элдэв хуванцраар хоолой үйлдвэрлэнэ.
- ✓ Одоогийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний өнгө, үзэмж, чанарыг сайжруулахад анхаарч ажиллаж байна.
- ✓ Хуванцрыг резинтэй холих замаар шинэ технологи ашиглан зам болон хөдөө аж ахуйд хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, энэ чиглэлд стандартыг Монголд нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэ тохиолдолд бодлого хэрэгжүүлэгчид, донор байгууллагууд, бусад оролцогч талуудаас дэмжлэг хэрэгтэй гэж судалгаанд оролцогчид үзэж байна.

Ойрын таван жилийн хугацаанд дээр дурдсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх болсон шалтгааныг тодруулж, График 17-д эмхэтгэн үзүүлэв. Үйлдвэрлэгчид зах зээлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлаж, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа нь давамгайлжээ. Мөн түүхий эд элбэг, импортыг орлох, байгаль орчинд ээлтэй, дэлхий нийтийн чиг хандлагыг дагаж дээрх бүтээгдэхүүнүүдийг ойрын таван жилд хийхээр төлөвлөсөн байна.

*График 15. Шинэ бүтээгдэхүүн гаргах болсон шалтгаан*




***Өгөгдлийн эх сурвалж:*** *Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

Хуванцрыг дахин боловсруулж, зах зээлд нэвтрүүлэхэд үйлдвэрлэгчдэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж техник, технологи, түүхий эдийн нийлүүлэлт, борлуулалт, хэрэглэгчдийн хүлээж авах хандлага гэсэн хэсгүүдэд ангилав. Үүнд:

**Хууль, эрхзүйн орчны хувьд тулгарч буй асуудал**:

- ✓ Хог хаягдлыг ангилах хууль, журмыг бодит байдалд хэрэгжүүлж, хог хаягдлыг ялгадаг болох нь чухал байна. Хэрвээ хог хаягдлыг журмын дагуу ялгавал дахин боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн олдоц нэмэгдэж, түүхий эдээ авахад хялбар болно.
- ✓ Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжилтнүүдийн хог хаягдал, түүнийг зохицуулах хууль, дүрэм, журмын талаар мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хуулиа мэдэхгүйгээс хог хаягдлыг үүсгэгч нь аюултай хог хаягдлыг хог хаягдлын цэгт хүлээлгэж өгөхгүй байна.
- ✓ Хоёрдогч түүхий эд ашиглаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд тавих стандарт, шаардлагыг тодорхой болгож, хянах, мөрдүүлэх шаардлагатай байна. Ялангуяа хоёрдогч түүхий эдээр хүнс, эрүүл ахуйн бүтээгдэхүүн хийхийг хориглох хэрэгтэй. Зарим үйлдвэрүүд хоёрдогч түүхий эдийг анхдагч түүхий эдтэй холиод хүнсний сав хийж байгааг анхаарч хянах, зохицуулах байгууллага, мэргэжилтэн алга.
- ✓ Засгийн газраас хэрэгжүүлж буй зарим бодлогууд зорилтот бүлэгтээ хүрч чаддаггүй. Жишээ нь, ЖДҮ-дийг дэмжих зорилгоор 3 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй

зээлд дахин боловсруулах үйлдвэрүүд хамрагдаж чадахгүй, шалгуур шаардлагыг хангахгүй байна.

- ✓ Гадаад худалдааны бодлого, экспорт, импортын талаар төрөөс баримталж буй бодлого, зохицуулалтууд бодит байдалд хэрэгжихгүй тохиолдол байна. Тодруулбал, зарим бараа, тоног төхөөрөмжийг импортын тарифгүй оруулна гэж заасан ч дахин боловсруулах үйлдвэр дээр зарим зүйл заалт нь тусгагдаагүй үлдсэн байдаг.
- ✓ Тусгай зөвшөөрөл, бичиг баримтыг сунгуулахад маш их чирэгдэл учирч байна. Тиймээс тогтмол хугацаанд сунгах шаардлагатай тусгай зөвшөөрөл, бичиг баримтын сунгах хугацааг холдуулах, давтан сунгах тохиолдолд тавих шаардлагыг бууруулах хэрэгтэй.
- ✓ Хог хаягдлыг дахин боловсруулснаар төрөөс ямар нэгэн урамшуулал, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. 1 кг энгийн хогийг булахад 2700 төгрөг зарцуулдаг гэсэн тооцоо бий. Энэ зардлыг хэмнээд хог хаягдлыг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эдийн засгийн эргэлтэд оруулж байхад урамшууллын ямар ч тогтолцоо байдаггүй.
- ✓ Тээврийн зардал, цахилгааны зардал, гаалийн татвар, НӨАТ өндөр. Татвар, эрчим хүчний хөнгөлөлт зэрэг огт байхгүй байхад гадаадын орнуудад иймэрхүү төрлийн үйлдвэрлэлээ дэмжсэн олон төрлийн хөшүүргүүд байдаг. Тэдний туршлагыг судалж, нэвтрүүлэх хэрэгтэй.
- ✓ Дахин боловсруулах үйлдвэрт хортой нөхцөлд ажиллаж буй ажилчдын ажлын орчинд тавигдах стандарт, шаардлагыг мөрдүүлэхэд төрөөс илүү анхаарч, ЖДҮ-чидтэй хамтарч ажиллах хэрэгтэй. Жишээ нь, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр нь бусад үйлдвэртэй харьцуулахад илүү том талбай шаарддаг. Хэрвээ ЖДҮ-чид өөрийн үйлдвэрийн байргүй бол үйл ажиллагаа явуулахад бэрх. Мэргэжлийн хяналт гэх мэт бусад хяналтын байгууллагууд үйлдвэрүүдэд маш өндөр шаардлага тавьдаг, хоёрдогч түүхий эдийн үйлдвэрүүд тэдний тавьж буй орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хүндрэлтэй. Мөн хууль эрх тэгш үйлчилдэггүй. Ижил төстэй гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдэд мэргэжлийн хяналтын тавих шаардлага сул байх нь ажиглагддаг.

**Техник, технологийн хувьд тулгарч буй асуудал**:

- ✓ Хүнсний сав баглаа, боодолд тавих нарийвчилсан стандартгүй, хүнсний үйлдвэрлэлд ямар орц найрлагатай, ямар түвшинд дахин боловсруулсан хуванцар ашиглаж болох нь тодорхойгүйгээс зарим үйлдвэрлэгчид хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.
- ✓ Уурын технологиор PET-ийг ашиглаад нийлэг утас гаргаж авна гэхэд заавал станцын хажууд уур авах шаардлагатай болно. Гэвч уур авах тусгай зөвшөөрөлгүй тохиолдолд ууραас гарч байгаа утсаа нийлэгжүүлж авч чадахгүй. Энэ тохиолдолд технологийн ч, тусгай зөвшөөрлийн ч асуудалтай тулгарч байна.
- ✓ Чадвартай, туршлагатай инженерүүд эрэлттэй байна. Ажилчдаа чадавхжуулж, хөрөнгө оруулалт татах хэрэгцээтэй байна.
- ✓ Гар ажиллагаа ихтэй үе шат дамжлагыг техник, технологи ашиглаж хийх сорилт, шаардлага тулгарч байна.
- ✓ Өөрийн үйлдвэрийн байртай болох, тоног төхөөрөмжөө өргөтгөх шаардлагатай тулгарч байна.

**Түүхий эдийн нийлүүлэлтийн хувьд тулгарч буй асуудал:**

- ✓ Одоогийн байдлаар түүхий эдийн ихэнхийг ченжүүдээр дамжуулж авдаг ба

ангилан ялгалт муу. Хог хаягдлыг ангилан ялгах талаар янз бүрийн аян өрнөдөг хэдий ч төрөөс нэгдсэн зохицуулалт хийдэггүй. Төр, хувийн хэвшил, иргэдийн гурван талын оролцоотой шийдэл олох шаардлагатай байна.

- ✓ Төрийн нэгдсэн бодлого, зохицуулалтгүй тул зах зээлээс түүхий эдээ олж авахад хэцүү. Заримдаа түүхий эдийн олдоц багасдаг, үнэ өсдөг.
- ✓ Түүхий эдийн нийлүүлэлтээр 2-3 давамгай компани байдаг ба тэд үнээ дураараа нэмдэг. Тэд үнэ өсгөхтэй зэрэгцэн ангилан ялгалтаа сайн хийж, үйлдвэрлэлд шууд ашиглах боломжтой, стандартын дагуу түүхий эд нийлүүлдэггүй.
- ✓ Тээвэр ложистик маш төвөгтэй. Тээврийн зардал өссөн.
- ✓ Гаалийн татвар өндөр. Гаалиар бүтээгдэхүүн оруулахад хүндрэлтэй бөгөөд цаг их алддаг.

**Борлуулалтын хувьд тулгарч буй асуудал:**

- ✓ Борлуулалтыг бүгдийг бэлэн мөнгөөр хийж чаддаггүй, бартераар хийх тохиолдол элбэг. Ялангуяа барилгын салбарт энэ байдал элбэг тохиолддог. Энэ тохиолдолд эргэлтийн хөрөнгийн хомсдолд ордог.
- ✓ Маркетинг маш их ач холбогдолтой. Ялангуяа маркетингийн зөв суваг олох нь чухал. ЖДҮ-чид ихэнхдээ фейсбүүк ашиглаж зар сурталчилгаа явуулдаг хэдий ч энэ нь зорилтот бүлэгтээ хүрэхгүй байх магадлалтай. Төрөөс нэгдсэн бодлогоор дотоодын ЖДҮ-дийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг таниулдаг үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.
- ✓ Инфляцын хурдтай өсөлтөөс улбаалж, бүтээгдэхүүний үнэ тогтооход бэрхшээл тулгардаг.
- ✓ Борлуулалтын тал дээр төрийн ямар ч дэмжлэг байдаггүй.

**Хэрэглэгчийн хүлээж авах хандлагын хувьд тулгарч буй асуудал:**

- ✓ Дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг хэрэглэх хэрэглэгчдийн хандлага сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн. Ялангуяа дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг мэддэг болж, авах сонирхол өссөн учраас хэрэглэгчийн хүлээж авах хандлагын хувьд асуудал тулгарах нь бага.
- ✓ Дотоодын бүтээгдэхүүнээ хэрэглэж үзээгүй хэрэглэгчийн хувьд “манайхан сайн юм хийхгүй дээ” гэсэн хардлага байдаг. Гэхдээ хэрэглээд үзсэний дараа бол байнгын хэрэглэгч болох тохиолдол элбэг.

Судалгаанд хамрагдсан нийт 18 үйлдвэрлэгчийн 16 нь буюу дийлэнх олонх нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчид худалдаалдаг юм байна. Ингэхдээ тэд нийт эцсийн бүтээгдэхүүнийхээ ойролцоогоор 72%-ийг үйлдвэрлэлийн хэрэглэгчид рүү нийлүүлдэг байна. Тэдний 5 нь ахуйн буюу өрхийн хэрэглэгчид бүтээгдэхүүнээ нийлүүлдэг ба нэг үйлдвэр бүх бүтээгдэхүүнээ зөвхөн өрхийн хэрэглэгчид худалдаалдаг ажээ. 8 үйлдвэр боловсруулсан бүтээгдэхүүнээ бөөний борлуулагчид худалдаалдаг бол зөвхөн 1 үйлдвэр бүтээгдэхүүнийхээ 50%-ыг экспортоор нийлүүлдэг, мөн 1 үйлдвэрлэгч бүтээгдэхүүнийхээ 10%-ыг төрийн байгууллагад нийлүүлдэг гэсэн байна. (Хүснэгт 4)

*Хүснэгт 4. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний нийлүүлэлтийн суваг, n=18*

| № | Бүтээгдэхүүнээ нийлүүлдэг субъект | Үйлдвэрлэгчийн тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Үйлдвэрлэлийн хэрэглэгч | 16 | 88.9% |
| 2 | Ахуйн буюу өрхийн хэрэглэгч | 5 | 27.8% |
| 3 | Бөөний борлуулагч | 8 | 44.4% |
| 4 | Экспорт | 1 | 5.6% |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Төрийн байгууллага | 1 | 5.6% |

***Өгөгдлийн эх сурвалж:** Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

**Үрэл үйлдвэрлэгчдийн дийлэнх нь бүтээгдэхүүнээ гэрээгээр үйлдвэрлэлийн хэрэглэгчдэд борлуулдаг байна.** Тодруулбал, үрэл үйлдвэрлэдэг 7 үйлдвэрлэгчийн 5 нь буюу 71.4% нь үйлдвэрлэлийн хэрэглэгчдэд гэрээгээр бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Үлдсэн 1 нь ахуйн буюу өрхийн хэрэглэгчдэд, нөгөө нь бөөний борлуулагчдад бүтээгдэхүүнээ нийлүүлдэг гэсэн байна. Үрэл үйлдвэрлэгчдээс нэг компани нь экспортоор хуванцар үрлэн түүхий эд гаргадаг юм байна.

18 үйлдвэрийн 13 нь буюу 72.2% нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ хэрэглэгчийн саналыг тусгадаг ба голчлон хэрэглэгчийн захиалгаар үйлдвэрлэх, бүтээгдэхүүний чанарын судалгаа, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, эсвэл хэрэглэгчээс санал ирвэл үйл ажиллагаандаа тусгаж сайжруулах аргуудыг баримталдаг байна.

## 3.4. Хуванцар дахин боловсруулж хийсэн бүтээгдэхүүний зах зээлийн орчин

Судалгаанд хамрагдсан 18 үйлдвэр бүгд Улаанбаатар хотод байршилтай байв. Тэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Улаанбаатар хотод борлуулдаг. Цор ганц нь экспортоор гаргадаг бол тэдний 14 нь буюу 77.8% нь хөдөө, орон нутагт борлуулалт хийдэг байна. (Хүснэгт 3)

*Хүснэгт 5. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын байршил, n=**18***

| № | Борлуулалтын байршил | Үйлдвэрлэгчийн тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Экспортод | 1 | 5.6% |
| 2 | Монголд, Улаанбаатарт | 18 | 100.0% |
| 3 | Монголд, Орон нутагт | 14 | 77.8% |

***Өгөгдлийн эх сурвалж:** Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

Хүснэгт 4-д дахин боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын сувгийн мэдээллийг нэгтгэв. Үйлдвэрлэгчдийн дийлэнх (88.9%) нь өөрийн үйлдвэрийн газраас борлуулалтаа хийдэг бол тал (50%) нь гэрээт борлуулагчаар борлуулдаг гэсэн байна. Зах дээр гарч борлуулалт хийдэг үйлдвэр 6 буюу нийт үйлдвэрийн 33.3%. Харин 1 үйлдвэр фейсбүүк ашиглаж борлуулалт хийдэг байна. Дахин боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид супермаркет, сүлжээ супермаркет, 8 нэрийн дэлгүүр, мини маркет, онлайн дэлгүүр ашигладаггүй болох нь уг судалгааны үр дүнгээр нотлогдлоо.

*Хүснэгт 6. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын суваг, n=18*

| № | Борлуулалтын суваг | Үйлдвэрлэгчийн тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Үйлдвэрээс | 16 | 88.9% |
| 2 | Гэрээт борлуулагч | 9 | 50.0% |
| 3 | Зах | 6 | 33.3% |
| 4 | Фэйсбүүк | 1 | 5.6% |
| 5 | Сүлжээ супермаркет | 0 | 0.0% |
| 6 | Супермаркет | 0 | 0.0% |
| 7 | 8 нэрийн дэлгүүр | 0 | 0.0% |
| 8 | Мини маркет | 0 | 0.0% |
| 9 | Онлайн дэлгүүр | 0 | 0.0% |

***Өгөгдлийн эх сурвалж:** Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

Судалгаанд хамрагдсан 18 үйлдвэрлэгчийн 17 нь буюу бараг бүгд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ бөөнөөр, шууд худалдан авах харилцагчтай хамтын ажиллагааны гэрээтэй юм байна. Үлдсэн 1 үйлдвэрлэгч бүтээгдэхүүнээ шууд бэлэн мөнгөөр борлуулдаг тул ийм төрлийн гэрээ хийх шаардлага үүсдэггүй гэж хариулжээ.

Бүтээгдэхүүнээ борлуулах хамтын ажиллагааны гэрээтэй үйлдвэрлэгчдийн 52.9% нь 1-10 харилцагчтай, 17.6% нь 11-50 харилцагчтай, 23.5% нь 50-100 харилцагчтай, 5.9% нь 100-аас дээш тооны харилцагчтай гэрээтэй байна. (Хүснэгт 5)

*Хүснэгт 7. Бүтээгдэхүүнээ борлуулах гэрээтэй харилцагчдын тоо, n=17*

| № | Гэрээтэй харилцагчдын тоо | Үйлдвэрлэгчийн тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | 1-10 харилцагч | 9 | 52.9% |
| 2 | 11-50 харилцагч | 3 | 17.6% |
| 3 | 50-100 харилцагч | 4 | 23.5% |
| 4 | 100-аас дээш тооны харилцагч | 1 | 5.9% |

**Өгөгдлийн эх сурвалж:** *Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

Дээрх байдлаас харахад **дахин боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид бараг бүх борлуулалтаа хамтын ажиллагааны гэрээ хэлцлийн доор үйлдвэрийн газраас болон гэрээт борлуулагчаар дамжуулан борлуулдаг байна.**

Хуванцар дахин боловсруулах зах зээлд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчид тухайн бүтээгдэхүүний өртөг, ижил төрлийн дотоодын үйлдвэрлэгчийн тогтоосон үнэ, ижил төрлийн импортын үйлдвэрлэгчийн тогтоосон үнэ болон бүтээгдэхүүний захиалагчийн санал зэргийг харгалзан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнээ тогтоодог. Эдгээрээс бүтээгдэхүүний өртгийг харгалзаж, үнээ тогтоодог үйлдвэрлэгчийн тоо дийлэнх хувь (77.8%)-ийг эзэлж байна. (Хүснэгт 6)

*Хүснэгт 8. Бүтээгдэхүүний үнэ тогтоох зарчим, n=18*

| № | Үнэ тогтоох зарчим | Үйлдвэрлэгчийн тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Бүтээгдэхүүний өртөгт тулгуурлан | 14 | 77.8% |
| 2 | Ижил төрлийн дотоодын үйлдвэрлэгч харьцуулах байдлаар | 4 | 22.2% |
| 3 | Ижил төрлийн импортын үйлдвэрлэгч харьцуулах байдлаар | 3 | 16.7% |
| 4 | Захиалагчидтай тохиролцох замаар | 2 | 11.1% |

**Өгөгдлийн эх сурвалж:** *Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

Гурван үйлдвэрлэгч тутмын хоёр нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахдаа ямар нэгэн урамшууллын арга, аргачлал ашигладаггүй гэсэн бол бүтээгдэхүүнээ дараа төлбөрт нөхцөлөөр өгдөг, ихээр авбал нэмэлт бүтээгдэхүүнээр урамшуулах, урамшууллын талаар гэрээнд тусгайлан заалт оруулах, хүргэлт хийх, орон нутгийн унаанд тавьж өгөх, авсан бүтээгдэхүүнийг үнэгүй савлаж, боолт хийж өгөх зэрэг аргаар урамшуулдаг цөөн тооны үйлдвэрлэгч байна.

Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний чанар, эрүүл, аюулгүй байдал, хүртээмжтэй, тасралтгүй нийлүүлэлт, бүтээгдэхүүний төрөл, боломжит хямд үнэ санал болгох зэрэг хүчин зүйлсийг чухалчилж, зах зээлд нийлүүлэлт хийхийг эрмэлздэг гэжээ.

Өөрийн бүтээгдэхүүний бусдаас ялгарах онцлогийг үйлдвэрлэгчдийн 76.5% нь чанар гэж хариулсан байна. Мөн Монгол улсад өөр байхгүй онцлог бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, технологиороо ялгаатай, байгаль ээлтэй, химийн хортой хог хаягдлыг саармагжуулдаг,

лабораторийн шинжилгээнд өгч, тохирлын гэрчилгээ авдаг зэрэг олон давуу талыг нэрлэсэн байна. Түүнчлэн үйлдвэрлэгчид цаашид борлуулалтын хэмжээгээ нэмэгдүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, түүхий эдийн ангилан ялгалтыг сайжруулж, чанарыг өсгөхийн сацуу тогтвортой нийлүүлэлтийг бий болгох, өнгө, үзэмжийг нэмэгдүүлж, загвар хийцийг сайжруулах, төрөөс дэмжлэг хүсэх, дэлгүүрийн тоог нэмэх, хүмүүст танилцуулах зэрэг олон үйл ажиллагаа явуулах шаардлагатай байгаагаа илэрхийлсэн. Эдгээрийн дотроос тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн хүчин чадлаа сайжруулах, түүхий эдийн чанар, тогтвортой нийлүүлэлтийг хангах нь харьцангуй олон үйлдвэрлэгчийн өмнө тулгамдаж буй асуудал болжээ. (Хүснэгт 6)

*Хүснэгт 9. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын нэмэгдүүлэхийн тулд хийх үйл ажиллагаа, n=18*

| № | Үйл ажиллагаа | Үйлдвэрлэгчийн тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тоног төхөөрөмж, хүчин чадлаа сайжруулах | 7 | 38.9% |
| 2 | Түүхий эдийн чанар, түүний тогтвортой нийлүүлэлт | 4 | 22.2% |
| 3 | Бүтээгдэхүүний загварыг сайжруулах | 3 | 16.7% |
| 4 | Төрийн дэмжлэг | 3 | 16.7% |
| 5 | Чанарыг сайжруулах | 2 | 11.1% |
| 6 | Дэлгүүрийн тоог олшруулах | 2 | 11.1% |
| 7 | Хүмүүст таниулах | 2 | 11.1% |
| 8 | Бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах | 1 | 5.6% |
| 9 | Хольцыг өөрчлөх | 1 | 5.6% |
| 10 | Урамшууллыг тогтмол зарлах | 1 | 5.6% |
| 11 | Бүтээгдэхүүнийг үнийн сонголтыг нэмэх | 1 | 5.6% |
| 12 | Брэндийн төрлийг нэмэх | 1 | 5.6% |

***Өгөгдлийн эх сурвалж:*** *Хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авсан асуумж, 2022*

Судалгаанд оролцсон 18 үйлдвэрлэгчийн 16 нь буюу 88.9% нь дахин боловсруулсан бүтээгдэхүүнүүд импортын бүтээгдэхүүнийг орлох, импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх бүрэн боломжтой гэж үзэж байна. Тодруулбал, дотооддоо үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний өртөг бага, үнэ хямд, чанар сайтай учраас хэрэглэгчид дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сонгох хандлага нэмэгдсэн гэж тайлбарлаж байна. Харин үлдсэн 2 үйлдвэрлэгчийн хувьд гадаадаас ижил төрлийн бүтээгдэхүүн татваргүй шахуу орж ирж байна, түүхий эдийн асуудал их учраас түүнийг ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд хэрэглэгчдээс гомдол ирэх тохиолдол үүсэж байгаа учраас шууд импортын бүтээгдэхүүнийг орлоно гэж хэлэх болоогүй гэжээ.

**Үйлдвэрлэгчид цаашид зах зээл дэх борлуулалтаа нэмэгдүүлэхийн тулд маркетинг, сурталчилгаа хийх, сошиалаар контент хөгжүүлэх мэдлэг, чадвар эзэмших, хууль эрх зүйн талаасаа аюултай хог хаягдлын чиглэлээр суралцах шаардлагатай болжээ. Мөн ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн жишиг үйлдвэрүүдтэй бодитоор танилцаж, туршлага судлах шаардлагатай байгаагаа тэд илэрхийлэв.**

### 3.5. Дахин боловсруулсан бүтээгдэхүүний талаар хуванцар бүтээгдэхүүн импортлогч, борлуулагчдын мэдлэг, ойлголт

Хуванцар бүтээгдэхүүн импортлогч, зах зээлд борлуулагч аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, худалдагчдаас түүвэр судалгаа авч, дахин боловсруулсан бүтээгдэхүүний талаарх мэдлэг, хандлагыг үнэллээ.

*График 16. Дахин боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, нөөц боломжийн талаар хуванцар импортлогч, борлуулагчдын ойлголт, n=18*




***Өгөгдлийн эх сурвалж:** Хуванцар бүтээгдэхүүн импортлогч, борлуулагчдаас авсан асуумж, 2022*

**Дахивар боловсруулж, хуванцар бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлдэг үйлдвэрүүдийн хүчин чадал, нөөц боломжийн талаар хуванцар бүтээгдэхүүн импортлогч, борлуулагчдын ойлголт, мэдлэг тааруу байна.** Учир нь, судалгаанд хамрагдсан 18 оролцогчийн 17% нь өнөөдөр манай улсад дахивар боловсруулж, хуванцар бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлдэг үйлдвэрүүд харьцангуй сайн үүсэж, бүрэлдсэн гэж үзсэн бол 50% нь хангалтгүй, харьцангуй муу байна гэж үнэлсэн. Тэдний 33% нь буюу гурван хүн тутмын нэг нь дахин боловсруулах үйлдвэрийн нөөц, боломж, хүчин чадлын талаар мэдэхгүй, мэдээлэл байхгүй гэж хариулсан байна. (График 18)

Дахивар боловсруулах үйлдвэр харьцангуй сайн бүрдсэн гэж үзсэн борлуулагчид сангийн саарал хоолой, сав, хогны уут зэрэг бүтээгдэхүүнийг илүү сайн мэдэж байв.

*Шигтгээ 1. Дахивар боловсруулж, хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал, нөөц, боломжийн талаар импортлогч, борлуулагчдын хандлага*

Манай улсад дахивар боловсруулах нөөц, боломж бүрдээгүй байна. Хуванцар хоолойгоор газрын бохирын ус зайлуулах хоолой л хийдэг байх. Яг хаана яаж зарагдаад байдгийг мэдэхгүй байна. Таниулсан бүтээгдэхүүн ч байхгүй.

*- Хуванцар импортлогч, борлуулагчтай хийсэн ярилцлагаас*

Дахивар боловсруулах үйлдвэр дутмаг, нөөц боломж хүрэлцэхгүй байна. Үндсэндээ үйлдвэрлэгч хоёр л компани байна. Тэд хуванцар таг, дэр, машины дугуйны эвүүр, кольцоо, хүзүү, шон хийдэг. Захиалга өгөхөд хүчин чадал нь дийлэхгүй, хүрэлцдэггүй. Тэгэхээр нэмээд үйлдвэр байх ёстой л гэж бодож байна.

*- Хуванцар импортлогч, борлуулагчтай хийсэн ярилцлагаас*

Хэрэгтэй үедээ хүрэлцдэггүй. Шугамын саарал хоолой гэхэд л зун шугам засварын ажил эхлэхээр олдоц муутай болчихдог. Тэгэхээр хүчин чадал нөөц боломж тааруу л гэж бодож байна.

*- Хуванцар импортлогч, борлуулагчтай хийсэн ярилцлагаас*

Манай улсад хуванцар дахин боловсруулах нөөц, боломж бүрдээгүй. Зуны саруудад нийлүүлэлт нь тасарчихдаг. Шалтгааныг нь мэдэхгүй. Худалдан авагч нэмэгдэж, түүхий эд олдохгүй болдог юм болов уу, эсвэл ачааллаа даадаггүй юм уу. Худалдан авагч ихтэй үед гялгар уут нь олддоггүй... Хийц, загвар муутай ирдэг. Заримдаа зарагдахгүй. Ганц л өнгөөр хийдэг. Орос зэрэг гадаадын улсууд шиг өнгөний сонголттой, загвар сайтай байвал бүгд л дотоодын үйлдвэрээ дэмжинэ шүү дээ. Дандаа депектэй юм хийж авчирч өгдөг.

*- Хуванцар импортлогч, борлуулагчтай хийсэн ярилцлагаас*

*График 17. Дахин боловсруулсан бүтээгдэхүүн импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадварын талаар борлуулагчдын үнэлгээ, n=18*




***Өгөгдлийн эх сурвалж:** Хуванцар бүтээгдэхүүн импортлогч, борлуулагчдаас авсан асуумж, 2022*

**Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадвар сул байна** гэж импортлогч, борлуулагчдын дийлэнх нь үзжээ. График 19-өөс харахад судалгаанд хамрагдсан 18 импортлогч, борлуулагчийн 55% нь дахин боловсруулсан бүтээгдэхүүн импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад чанар муу, өнгө, үзэмж тааруу хэр нь ялгаагүй эсвэл арай илүү үнэтэй байдаг тул импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадваргүй гэж тайлбарласан байна. Харин өрсөлдөх чадвартай гэж үнэлсэн оролцогчдын 28% нь дотоодод дахин боловсруулсан бүтээгдэхүүн импортынхоос хямд үнэтэй, чанар сайтай байдаг гэжээ.

Үйлдвэрлэлийн хүчин чадал, тоног төхөөрөмжөө өргөтгөн бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, нэр төрлийг нэмэгдүүлбэл дотоодын үйлдвэрлэлээ дэмжихэд бэлэн байгаагаа судалгаанд хамрагдсан борлуулагчид илэрхийлж байв.

*Шигтгээ 2. Борлуулалтын үнийн талаар*

> Манайхан нэг гаргасан бүтээгдэхүүнийхээ үнийг яг үйлдвэрийн үнээрээ заруулах гээд байдаг. Мэдээж борлуулагч байгууллага тодорхой хэмжээний ашиг гаргах хэрэгтэй. Үүнийг тооцож, үйлдвэрээс гарах үнээ хямд байлгахад анхаарах шаардлагатай. Үнэтэй бол хүмүүс худалдаж авдаггүй.
>
> *- Хуванцар импортлогч, борлуулагчтай хийсэн ярилцлагаас*

Өдөр бүр хэрэглэгчидтэй уулзаж, тэдний шаардлага, хэрэгцээг мэдэрч байдаг импортлогч, борлуулагчдаас цаашид дахин боловсруулах, шинээр хөгжүүлэх шаардлагатай бүтээгдэхүүний санал асуухад дараах бүтээгдэхүүнүүдийг нэрлэсэн байна. Үүнд:

- ✓ Усны нөөцийн сав, хүнсний зориулалттай том жижиг сав, суулга
- ✓ Том, жижиг, нимгэн, зузаан төрөл бүрийн уут, тор
- ✓ Ахуйн болон нийтийн талбайн сандал, ширээ
- ✓ Гадна талбайд шон, хашаа хайс, замын усны хаялга, шүүр
- ✓ Сангийн PPR хоолой, агааржуулалтын хоолой зэрэг төрөл бүрийн хоолой, агааржуулалтын хавхлаг, агааржуулалтын малгай, толгой, хатуу турба, усны шланк, усны хаялга, шаврын өнгөлөгч, шифатал, шавар татагч, тэлэгчтэй боолтын хаалт, гипсний тэлэгч, салхивчийн хаалт, өнхрүүшийн иш, бариул, залгуур, хүрз, хүрзний иш, гэрлийн унтраалга, разетка, хуванцар хроп, утас далдлагч, автоматын хуванцар хайрцаг, хуванцар цонхны тавцан, таазны болон ханын лампер, сипон, нойлын суултуурын дарагч, гармушик, гоожуур зэрэг барилгын багаж, материал.

Хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтэд тулгамдаж буй асуудал, хязгаарлалт, түүнийг шийдэх арга замын талаар импортлогч, борлуулагчдын саналыг доор нэгтгэв. Үүнд:

- ✓ Импортын урсгал чөлөөтэй биш, хил, гааль хаалттай үед нийлүүлэлт тасалдах асуудал үүсэж байгаа учраас боломжит бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болох сорилт тулгарч байна. Үүний тулд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.
- ✓ Дотооддоо үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ стандартын дагуу үйлдвэрлэдэг байх шаардлагатай.
- ✓ Үйлдвэрлэлийн хүчин чадал муу, захиалсан бүтээгдэхүүнийг цаг тухайд нь үйлдвэрлэж, нийлүүлж чадахгүй байна. Үүний цаана хүнд, хортой нөхцөлд ажиллуулах ажилчны дутагдал, инженер, техникийн ажилтны мэдлэг, чадвар дутмаг зэрэг хүний нөөцийн асуудал байхаас гадна анхдагч болон хоёрдогч түүхий эдийн олдоц нөлөөлж байна.
- ✓ Үйлдвэрлэгчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ талаар танилцуулж, сурталчилдаггүйгээс шалтгаалж, хэрэглэгчид мэддэггүй. Ямар бүтээгдэхүүнийг Монголд хийж байгаа талаар мэдээлэл байдаггүй.
- ✓ Их хэмжээгээр үйлдвэрлэх хүчин чадал муу. Ялангуяа 8 болон 9 дүгээр сард бүтээгдэхүүн захиалбал үйлдвэрлэх газар олддоггүй.

Дотоодод үйлдвэрлэсэн хуванцар бүтээгдэхүүнийг зарж, борлуулахад ихэнх тохиолдолд ямар нэгэн урамшуулал, хөшүүрэг байдаггүй. Зарим гэрээт борлуулагчдын үйлдвэрээс барааг зээлээр авах боломж байдаг хэдий ч нийтлэг биш. Мөн гэрээт борлуулагчид олныг борлуулбал үнийн дүнгээс тодорхой урамшуулал авах гэрээний

заалттай хэдий ч хэрэгжүүлэхэд бэрх. БНХАУ-ын үйлдвэрлэгчид борлуулагчдад үнийн болон үнийн бус хөнгөлөлт, урамшуулал ихээр олгодог. Үүнтэй харьцуулахад дотоодын үйлдвэрлэгчид үнээ бууруулдаггүй, хөнгөлөлт, урамшуулал олгодоггүй учраас борлуулагчид дотоодын бүтээгдэхүүнийг зарж, борлуулах хөшүүрэггүй байдаг аж. Иймд хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгж байгууллагууд дараах урамшуулал, хөшүүргийг борлуулагчдад олгодог байвал борлуулалтын хэмжээгээ нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд:

- ✓ Байнга хамтран ажилладаг борлуулагчдад бүтээгдэхүүнээ зээлээр өгөх, боломжит хамгийн бага үнийг санал болгох.
- ✓ Үйлдвэрээс гарах үнийг зах зээлийн үнээс доогуур тогтоох эсвэл ихээр авахад үнийн дүнгийн хөнгөлөлт олгох.
- ✓ Борлуулалтын орлогоос хамааруулан урамшууллын хувь тогтоох.
- ✓ Хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх.

### 3.6. Хуванцар бүтээгдэхүүний импортын нөхцөл байдал

Монгол улс дэлхийн 80 гаруй улсаас хуванцар бүтээгдэхүүн, түүхий эд материал импортолдог бөгөөд импортын хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. Хүснэгт 8-д Гаалийн ерөнхий газрын мэдээлэлд үндэслэн хуванцар бүтээгдэхүүний импортын 2018, 2019 оны нийт суурь үнэлгээг гарал үүслээр ялгаж, хамгийн өндөр хувийн жин эзэлдэг ТОП 10 улсын мэдээллийг харуулав. Манай улсын нийт хуванцар бүтээгдэхүүний импортын 2/3 хэсгийг БНХАУ-ны бараа, материал эзэлдэг байна. БНСУ, ОХУ, АНУ, Австрали зэрэг улсаас оруулдаг хуванцар бараа, материал дараагийн байрыг эзэлж байна.

*Хүснэгт 10. Импортын хуванцар бүтээгдэхүүний гарал үүсэл, суурь үнэлгээ*

| № | Гарал үүсэл | 2018 он | | 2019 он | |
|---|---|---|---|---|---|
| | | Суурь үнэлгээ, сая төгрөгөөр | Нийт суурь үнэлгээнд эзлэх хувь | Суурь үнэлгээ, сая төгрөгөөр | Нийт суурь үнэлгээнд эзлэх хувь |
| 1 | БНХАУ | 197 616.95 | 68.8% | 233 915.20 | 65.8% |
| 2 | БНСУ | 20 892.80 | 7.3% | 25 202.12 | 7.1% |
| 3 | ОХУ | 15 471.89 | 5.4% | 24 315.22 | 6.8% |
| 4 | АНУ | 6 355.02 | 2.2% | 8 234.69 | 2.3% |
| 5 | Австрали | 5 100.84 | 1.8% | 7 326.88 | 2.1% |
| 6 | ХБНГУ | 5 973.14 | 2.1% | 6 215.76 | 1.7% |
| 7 | Итали | 3 760.89 | 1.3% | 4 542.97 | 1.3% |
| 8 | Япон | 3 406.96 | 1.2% | 4 100.68 | 1.2% |
| 9 | Швейцар | 153.98 | 0.1% | 3 264.17 | 0.9% |
| 10 | Малайз | 3 955.67 | 1.4% | 3 074.88 | 0.9% |
| | Бусад улс | 24 526.45 | 8.5% | 35 246.74 | 9.9% |
| **Нийт** | | **287 214.58** | **100.0%** | **355 439.33** | **100.0%** |

***Өгөгдлийн эх сурвалж:*** *Гаалийн ерөнхий газар*

“Барааг тодорхойлох, кодлох уялдуулах систем” (БТКУС)-ийн 39 дүгээр бүлгийн хуванцар бараа, материалын төрлөөр 2019 онд 3601 аж ахуйн нэгж, хувь хүн бараа, материал бүртгүүлж, импортолсон байна. Тэдгээрээс 2019 онд хамгийн их мөнгөн дүнгээр импортолсон 75 аж ахуйн нэгж, хувь хүний мэдээллийг Хүснэгт 9-д нэгтгэж үзүүлэв.

*Хүснэгт 11. Импортоор хуванцар бараа, материал оруулдаг ТОП компаниуд, 2019 он*

| № | Нэр | Суурь үнэлгээ, сая төгрөгөөр | Эзлэх хувь | № | Нэр | Суурь үнэлгээ, сая төгрөгөөр | Эзлэх хувь | № | Нэр | Суурь үнэлгээ, сая төгрөгөөр | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эйч Эм Эн Эйч ХХК ГХО | 30234 | 8.5% | 26 | Скай хайпермаркет ХХК | 2612 | 0.7% | 51 | ХКҮ ХХК | 1171 | 0.3% |
| 2 | АПУ ХК | 10962 | 3.1% | 27 | Фенстер монгол ХХК | 2200 | 0.6% | 52 | Петрочайна Дачин Тамсаг ХХК | 1168 | 0.3% |
| 3 | Витафит-Инвест ХХК | 10343 | 2.9% | 28 | Ондилт ХХК | 2198 | 0.6% | 53 | Хөгжилтрейд ХХК | 1164 | 0.3% |
| 4 | МСМ групп ХХК | 6407 | 1.8% | 29 | АПУ дэйри ХХК | 2190 | 0.6% | 54 | Доечевэллэ ХХК | 1163 | 0.3% |
| 5 | Обпластик ХХК | 6112 | 1.7% | 30 | Энхтэд ХХК | 2148 | 0.6% | 55 | Номин Мишээл ХХК | 1154 | 0.3% |
| 6 | Дулаанхөөс ХХК ГХО | 6002 | 1.7% | 31 | Номин трейдинг ХХК | 2122 | 0.6% | 56 | Пирамид индастри ХХК | 1143 | 0.3% |
| 7 | Цонжай ХХК ГХО | 5933 | 1.7% | 32 | Айвико-Интернэшнл ХХК | 2113 | 0.6% | 57 | Авидын Эрдэнэ ХХК | 1127 | 0.3% |
| 8 | Оюутолгой ХХК | 5610 | 1.6% | 33 | Монголнью пластик ХХК | 2100 | 0.6% | 58 | Итгэлтбуухиа ХХК | 1118 | 0.3% |
| 9 | МСМ групп ХХК ГХО | 4883 | 1.4% | 34 | Мултипак ХХК | 2097 | 0.6% | 59 | Батжинатрейд ХХК | 1117 | 0.3% |
| 10 | Кемекс ХХК | 4869 | 1.4% | 35 | Нягтхөөс ХХК | 2096 | 0.6% | 60 | МИАТ ХК | 1087 | 0.3% |
| 11 | Спирт Бал Бурам ХХК | 4795 | 1.3% | 36 | Сүү ХК | 2071 | 0.6% | 61 | Митсжапан ХХК | 1068 | 0.3% |
| 12 | Монголын алт МАК ХХК | 4711 | 1.3% | 37 | Мэйжордриллинг монгол ХХК ГХО | 2026 | 0.6% | 62 | Өнгөттөмөр ХХК | 1059 | 0.3% |
| 13 | М Си Эс кокакола ХХК | 4040 | 1.1% | 38 | Хөн Тай индастри ХХК | 1949 | 0.5% | 63 | Ус сувгийн удирдах газар Орон нутгийн өмчит ААТҮГ | 1056 | 0.3% |
| 14 | Бродерс индастри ХХК ГХО | 3910 | 1.1% | 39 | Сүнцайтианма ХХК ГХО | 1875 | 0.5% | 64 | Эн Өү Ти Эс ХХК | 1041 | 0.3% |
| 15 | Цэцзам пласт ХХК | 3812 | 1.1% | 40 | Жиэнбевережис ХХК | 1646 | 0.5% | 65 | МСМ групп ГХОХХК | 1015 | 0.3% |
| 16 | Ти Эм Эл ГХО ХХК | 3695 | 1.0% | 41 | Тавинлан ХХК | 1598 | 0.4% | 66 | Грийн интернэшнл ХХК | 984 | 0.3% |
| 17 | Домог-Интернэшнл ХХК | 3564 | 1.0% | 42 | Энхийн шүүдэр ХХК | 1436 | 0.4% | 67 | Электриком ХХК | 976 | 0.3% |
| 18 | Монпактрейд ХХК | 3309 | 0.9% | 43 | Сүү ХК | 1382 | 0.4% | 68 | Нарантуул трейд ХХК | 967 | 0.3% |
| 19 | Клаймакс-Интернэшнл ХХК | 3182 | 0.9% | 44 | Жем-Интернэшнл ХХК | 1380 | 0.4% | 69 | ЦБОН ХХК | 947 | 0.3% |
| 20 | Росторг ХХК ГХО | 3166 | 0.9% | 45 | Говьхангай буйдан ХХК | 1372 | 0.4% | 70 | Би Би Ай Ай ХХК | 931 | 0.3% |
| 21 | Пирамид-Индастри ХХК | 3136 | 0.9% | 46 | Шүняада ХХК | 1249 | 0.4% | 71 | Витафит милк ХХК | 927 | 0.3% |
| 22 | Сүлдшонхор ХХК | 3094 | 0.9% | 47 | Үлэмж ХХК | 1230 | 0.3% | 72 | Өгөөж чихэр боов ХХК | 901 | 0.3% |
| 23 | Эм пластик ХХК ГХО | 3050 | 0.9% | 48 | Моноскосметик ХХК | 1221 | 0.3% | 73 | Монинжбар ХК | 891 | 0.3% |
| 24 | Хувь хүн | 2773 | 0.8% | 49 | Вагнер ази тоног төхөөрөмж ХХК ГХО | 1191 | 0.3% | 74 | Термигас импианти технологи ХХК ГХО | 884 | 0.2% |
| 25 | М Си Эс Проперти ХХК | 2736 | 0.8% | 50 | Бестбуйдан ХХК | 1176 | 0.3% | 75 | Атар-Өргөө ХК | 843 | 0.2% |

***Өгөгдлийн эх сурвалж:** Гаалийн ерөнхий газар*

Эхний 10 компани нийт суурь дүнгийн ¼ хэсэгтэй тэнцэх бараа, материал импортолсон байна. Жагсаалтыг Эйч Эм Эн Эйч ХХК тэргүүлж, АПУ, Витафит-Инвест, МСМ групп, Обпластик, Дулаанхөөс, Цонжай, Оюутолгой, гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-тай МСМ групп, Кемекс компаниуд дараалсан байна.

Эйч Эм Эн Эйч ХХК нь гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-тай компани бөгөөд 2019 онд зөвхөн 39076100 кодтой цагаан өнгийн, цилиндр хэлбэрийн шахмал үрэл хэлбэртэй ундааны савны түүхий эд импортолжээ.

АПУ ХХК нь 2019 онд 40 нэр төрлийн 10962.2 сая төгрөгийн хуванцар бараа, материал импортолсны 65.8%-ыг архины бөглөө, 12.9%-ыг хуванцар хальсан шошго, 5.5%-ыг хуванцар авдар, 5.3%-ыг шар айргийн хуванцар бөглөө эзэлсэн байна. (Хүснэгт 10)

*Хүснэгт 12. АПУ ХХК-ын импортолсон гол бараа, материалын нэр төрөл, хэмжээ, 2019 он*

| № | Бараа, материал | Суурь үнэлгээ, сая төгрөгөөр | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Архины бөглөө | 7211.1 | 65.8% |
| 2 | Хальсан шошго | 1416.0 | 12.9% |
| 3 | Авдар | 598.7 | 5.5% |
| 4 | Шар айргийн бөглөө | 585.2 | 5.3% |
| 5 | Тавцан | 217.0 | 2.0% |
| 6 | Шар айргийн тогтворжуулагч | 200.3 | 1.8% |
| 7 | Поддон, хуванцар | 177.5 | 1.6% |
| 8 | Бөглөө, хуванцар | 160.9 | 1.5% |
| 9 | Усны бөглөө | 130.3 | 1.2% |
| 10 | Бөглөөний лац | 97.9 | 0.9% |
| | Бусад | 167.4 | 1.5% |
| | **Нийт** | **10 962.2** | **100.0%** |

***Өгөгдлийн эх сурвалж:*** *Гаалийн ерөнхий газар*

Витафит-Инвест ХХК нь 2019 онд 35 нэр төрлийн 10342.7 сая төгрөгийн хуванцар бараа, материал импортолсны 56.3%-ыг полиэтилен терефталат, 16.3%-ыг жүүсний шошго, 7.8%-ыг хуванцар бөглөө, 4.7%-ыг хуванцар шошго, 4.1%-ыг Полимерийн хальс эзэлсэн байна. (Хүснэгт 11)

*Хүснэгт 13. Витафит-Инвест ХХК-ын импортолсон гол бараа, материалын нэр төрөл, хэмжээ, 2019 он*

| № | Бараа, материал | Суурь үнэлгээ, сая төгрөгөөр | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Полиэтилен терефталат | 5825.7 | 56.3% |
| 2 | Жүүсний шошго | 1688.1 | 16.3% |
| 3 | Бөглөө | 810.3 | 7.8% |
| 4 | Хуванцар шошго | 484.3 | 4.7% |
| 5 | Полимерийн хальс | 422.4 | 4.1% |
| 6 | Бэлдэц, усны савны | 302.4 | 2.9% |
| 7 | Баглаа боодлын хальс | 149.4 | 1.4% |
| 8 | Хуванцар бөглөө | 149.4 | 1.4% |
| 9 | Гялгар хальс | 130.5 | 1.3% |
| 10 | Хуйлмал хуванцар шошго | 82.5 | 0.8% |
| | Бусад | 380.3 | 3.7% |
| | **Нийт** | **10342.7** | **100%** |

***Өгөгдлийн эх сурвалж:*** *Гаалийн ерөнхий газар*

Дээрх мэдээллээс үзэхэд манай улсын хуванцар бараа, материал импортлогч томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд ус, ундааны савны бэлдэц, түүхий эд, бөглөө, шошго, лац, полиэтилен терефталат, гялгар хальс гэсэн нэр төрлийн бараа, материалыг хамгийн ихээр импортолсон байна.

Манай улс 2019 онд 7000 орчим нэр төрлийн хуванцар бараа, материал импортолсон байгаагаас хамгийн өндөр үнийн дүнтэй бараа, материал болон дотоодын үйлдвэрлэгчид цаашид үйлдвэрлэхээр төлөвлөж буй гол нэр төрлийн бүтээгдэхүүний жагсаалтыг Хүснэгт 14-д нэгтгэн үзүүлэв. Эдгээр 20 бараа, материалын суурь үнэлгээ нь 2019 онд импортолсон нийт бараа, материалын суурь үнэлгээний 83.68%-ийг бүрдүүлж байгаагаас гадна тэдний дийлэнх нь үйлдвэрлэлд ашиглагдах орц, түүхий эд, туслах материалууд байна.

*Хүснэгт 14. Импортын бараа, материалын нэр төрөл, хэмжээ, 2019 он*

| № | Бараа, материал | Хэмжээ, тонноор | Суурь үнэлгээ, сая төгрөгөөр | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Полиэтилен | 16260 | 55511.8 | 15.62% |
| 2 | Полистирол | 11164 | 35643.8 | 10.03% |
| 3 | **Төрөл бүрийн хоолой** | **6047** | **30597.2** | **8.61%** |
| 4 | **Төрөл бүрийн хуванцар бэлдэц** | **2600** | **22999.1** | **6.47%** |
| 5 | Бөглөө | 50 | 22427.7 | 6.31% |
| 6 | Хальс | 3476 | 22139.5 | 6.23% |
| 7 | Сав | 357 | 19862.4 | 5.59% |
| 8 | **Уут** | **666** | **16320.2** | **4.59%** |
| 9 | Хавтан | 1029 | 15102.0 | 4.25% |
| 10 | Цонх | 484 | 11285.4 | 3.18% |
| 11 | Хулдаас | 412 | 9651.7 | 2.72% |
| 12 | Полимер | 1808 | 9334.8 | 2.63% |
| 13 | **Шал** | **55** | **8383.3** | **2.36%** |
| 14 | Шошго | 374 | 7795.3 | 2.19% |
| 15 | Полиакриламид | 1045 | 5746.7 | 1.62% |
| 16 | Порлон | 500 | 4296.9 | 1.21% |
| 17 | **Бортого** | **8.2** | **327.7** | **0.09%** |
| 18 | **Хүрз** | **NA** | **8.8** | **0.002%** |
| 19 | **Хуванцар сандал** | **NA** | **8.6** | **0.002%** |
| 20 | **Хогны уут** | **NA** | **5.1** | **0.001%** |
| | Бусад бараа, материал | NA | 57991.5 | 16.32% |
| | **Нийт** | **47340** | **355439.3** | **100.00%** |

*Тайлбар: "Хэмжээ, тонноор" гэсэн баганад Гаалийн ерөнхий газрын мэдээллээс зөвхөн тонноор хэмжигдэх боломжтой утгын нийлбэрийг бичив. Ширхгээр, метрээр, метр квадратаа зэрэг өөр олон хэмжээст бүтээгдэхүүний хэмжээг энд оруулаагүй.*

***Өгөгдлийн эх сурвалж: Гаалийн ерөнхий газар***

Үйлдвэрлэгчдээс авсан асуумж судалгааны үр дүнгээс дотоодын хуванцар дахин боловсруулагч, үйлдвэрлэгчдийн цаашид үйлдвэрлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүний нэрийг Хүснэгт 14-д тодруулав. Уг хүснэгтийг Гаалийн ерөнхий газрын 2019 оны мэдээлэлд тулгуурлаж боловсруулсан. 2020 оны эхээр Ковид-19 цар тахал тархаж, манай улс төдийгүй ихэнх улсууд хилийн худалдааг зогсоосон. Энэ байдал өнөө хэр өмнөх хэвийн түвшинд очоогүй тул 2019 оны мэдээлэл хамгийн зөв мэдээлэл гэж үзэв. Мөн Гаалийн ерөнхий газарт бүртгэгдсэн бараа, материалын хэмжээ килограммаар, ширхгээр, метрээр, метр квадратаар зэрэг олон ялгаатай хэмжилттэй байна. Үйлдвэрлэгчдээс асуумж судалгаа авахдаа боловсруулсан дахивар, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг тонноор хэмжсэн тул уг хүснэгтийн "Хэмжээ, тонноор" гэсэн баганад зөвхөн хүндийн жингээр бичигдсэн бараа, материалын хэмжээг тонноор илэрхийлж нэгтгэв. Тодруулбал, 2019 оны байдлаар манай улсад хамгийн багадаа 47340 тонн хуванцар бүтээгдэхүүн импортлогдсон байна. Уртын хэмжилт, талбай, эзлэхүүний зэрэг бусад олон хэмжилтээр хэмжигдсэн хуванцрын хэмжээг тонн руу шилжүүлбэл үүнээс хэчнээн дахин их утга гарахыг таашгүй юм.

Өмнөх хэсгийн шинжилгээнд дотоодын үйлдвэрлэгчдийн түгээмэл үйлдвэрлэдэг эцсийн бүтээгдэхүүн нь хогны уут гэж тодорхойлогдсон. Хүснэгтээс харахад **хогны уут бол импортын суурь үнэлгээ багатай, нийт хуванцар бүтээгдэхүүний импортод 0.001% буюу маш бага хувь эзэлдэг бүтээгдэхүүн болох нь харагдаж байна.** Харин судалгаанд хамрагдсан **үйлдвэрлэгчид цаашид цахилгааны хамгаалалтын хоолой, цэвэр, бохир усны хоолой зэрэг төрөл бүрийн хоолой, төрөл бүрийн хуванцар бэлдэц үйлдвэрлэхээр төлөвлөсөн импортын өндөр үнэлгээтэй бүтээгдэхүүнийг орлох, зах зээлийн багтаамж ихтэй, эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүнүүд аж.** Түүнчлэн үйлдвэрлэгчид цаашид **байгууллагын логотой, логогүй, төрөл бүрийн өнгө үзэмж, хэлбэр дүрстэй уут, террас зэрэг гадна зориулалтын болон паркет зэрэг дотор зориулалтын шал үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа нь импортын суурь үнэлгээний хувьд дундаж, импортыг орлуулж, дотооддоо үйлдвэрлэвэл зах зээлийн багтаамжтай нь хүснэгтээс харагдаж байна.** Харин нийтлэг үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэхээр төлөвлөж буй бортого, хүрз, сандал, хогны уут зэрэг нь импортын суурь үнэлгээ харьцангуй бага байна. Суурь үнэлгээ бага байхын хэрээр үйлдвэрлэгчийн борлуулалтын орлогод оруулах хувь нэмэр бага.

### 3.7. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний зураглал

Тус ажлын хүрээнд хийгдсэн судалгаанууд, Монголын хог хаягдлын холбооны удирдлагуудтай уулзаж ярилцсаны үндсэн дээр Монгол улсын дахин боловсруулсан хуванцрын үнэ цэний сүлжээг ерөнхий байдлаар доорх зурагт гаргалаа.

**Түүхий эд бэлтгэгч:** Иргэд (жуулчид), айл өрх, албан байгууллагын хэрэглээнээс гарсан дахивар хуванцар нь дахин боловсруулах үйлдвэрийн үндсэн түүхий эд болдог.

**Түүхий эд цуглуулагч:** Үндсэн түүхий эдийг хог түүгч иргэд болон зарим орон сууцны СӨХ, дахивар нөөцийн цэгүүдийг сүлжээний энэ үе шатанд хамруулах бөгөөд цөөн үйлдвэр дахин боловсруулах түүхий эдээ бэлтгэх зорилгоор цуглуулах үйл ажиллагаа явуулдаг. Хаягдал хуванцрын ихэнх хэсгийг айл өрх, албан байгууллагын хаягдлаас бэлтгэж байна.

**Түүхий эд худалдан авагч:** Бохир хуванцрыг анхан шатны боловсруулах үйлдвэрт оруулахаас өмнөх үе шат бөгөөд цугласан дахивар түүхий эдийг дахин боловсруулах үйлдвэрүүд, дахивар нөөцийн зуучлан борлуулах том цэгүүд худалдан авалт хийж татан төвлөрүүлдэг. Түүхий эд худалдан авагчид нь анхан шатны болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрт нийлүүлдэг.

**Анхан шатны боловсруулах үйлдвэрлэл:** Түүхий эд цуглуулагчаар дамжин эсвэл шууд худалдан авагч нараас татан төвлөрүүлсэн дахивар түүхий эдийг анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрүүд зураглалд заасны дагуу үйлдвэрийн технологийн дарааллаар хагас боловсруулалтыг хийж гүйцэтгэнэ.

*Зураг 2. Монгол улсын хуванцар бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний замын зураглал*




**Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл:** Түүхий эд худалдан авагч болон анхан шатны боловсруулах үйлдвэрээс хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авдаг. Уг дахивар бүтээгдэхүүнийг ашиглан эцсийн бүтээгдэхүүнийг технологийн урсгалын дагуу үйлдвэрлэн зах зээлд нийлүүлнэ. Маш цөөхөн тохиолдолд хуванцраар хийсэн эцсийн бүтээгдэхүүнийг урьд хөрш рүү гаргаж байна. Мөн захиалагчийн хүсэлтээр тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний орц найрлагыг сайжруулах зорилгоор импортын түүхий эдийг үйлдвэрлэлдээ ашиглаж байна.

**Худалдааны байгууллага:** Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс гарсан дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, зуучлагчаар дамжин борлуулагдаж байна. Дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний нийлүүлэлт хангалттай биш учраас худалдааны байгууллагууд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирж худалдан борлуулах байдал давамгайлж байна. Эдгээр борлуулагчид дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сонирхол өндөр байдаг.

**Эцсийн хэрэглэгч:** Бэлэн болсон дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнүүдийг захиалагч ААНБ, үйлдвэр, иргэд болон худалдан авагч ААНБ-ууд худалдан авдаг.

Монголд өрхийн ахуйн хэрэглээнд ашиглагдах дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнээс илүү барилгын материалыг үйлдвэрлэдэг. Нөгөө талаас нийлүүлэлт хангалттай биш учраас эцсийн хэрэглэгчид шаардлагатай хуванцар бараа бүтээгдэхүүнийг импортолж хэрэглэж байна.

**Гадаад зах зээл:** Гадаадын зах зээл рүү зарим ААНБ бүтээгдэхүүнээ гаргаж байна. Тухайлбал, 2020 онд Өндөр Ахын Өргөө ХХК 2500 тонн хуванцрыг (PET, HDPE, LDPE, PP) утас хэлбэрээр хятад руу экспортолсон. Одоо тус үйлдвэрийн үйл ажиллагаа зогссон байна. 2021 оноос хойш хил гаалийн хорио цээр, тээвэрлэлтийн үнийн өсөлтөөс шалтгаалж экспортын үйл ажиллагаа зогссон байна.

**PET хуванцрын нэмүү өртгийн тооцоолол**

Монгол улсын хэмжээнд дахивар хуванцрын нэмүү өртгийн тооцооллыг өмнө хийж байгаагүй бөгөөд анх удаа хийгдэж байна. Үүнд дахивар хуванцрын хамгийн түгээмэл PET төрөл дээр бохир хуванцраас эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх завсрын хэрэглээ, нэмүү өртөг, үнийг доорх хүснэгтэд харууллаа. Тус тооцооллыг хийхдээ нарийвчилсан байдлаар шинжилгээ хийгээгүй, ерөнхий тойм үзүүлэлтээр авч үзсэн тул алдаа гарсан байхыг үгүйсгэхгүй.

2021 онд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны захиалгаар хийгдсэн дахивар нөөцийн цэгүүд болон дахин боловсруулах үйлдвэрүүдийн судалгааг Монголын Хог Хаягдлын Үндэсний Холбоо хийж гүйцэтгэсэн. Уг судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд гарч байгаа нийт хог хаягдлын (1.4 сая тонн) 8.9 хувь буюу 124 мянган тонн хог хаягдлыг дахивар нөөцийн цэгүүд, дахин боловсруулах үйлдвэрүүдэд дахивар түүхий эд болгон нийлүүлсэн байна. Үүний 8600 тонн зөвхөн PET төрлийн хуванцрыг дахин боловсруулах үйлдвэрүүд ашигласан байна. Үүний 60 хувь буюу 5160 тонн хуванцар хог нь албан байгууллагуудаас бүрдсэн ба үүнээс уул уурхайн олборлолтын компаниуд хамгийн их хувийг эзэлж байна. Нийт PET дахивар хуванцрын 30 хувь буюу 2580 тонн орчим нь айл өрхөөс, 10 хувь буюу 860 тонн иргэд болон жуулчдын хог хаягдлаас бүрдэж байна. Түүхий эд цуглуулагчийн хувьд авч үзвэл 70 орчим хувь нь дахивар нөөцийн цэгүүдээс, дахин боловсруулах үйлдвэрүүд 15 хувь, хог түүгчид 10 хувь, СӨХ 5 хувийг бүрдүүлдэг.

Зураг 3-аас харахад хуванцар цуглуулах үе шатнаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн болгож зах зээлд нийлүүлэгдэхэд хамгийн их нэмүү өртөг хүртэж байгаа нь зуучлагчид /худалдааны байгууллагууд байна. Нийт нэмүү өртгийг тооцохдоо экспортод гарсан хуванцар бүтээгдэхүүний нэмүү өртгийг оруулж тооцоогүй, зөвхөн дотоодын зах зээлд борлогдох үеийн нийт нэмүү өртгийг тооцов. Ингэж тооцоход дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээнд бий болж буй нэг кг PET-ийн нийт нэмүү өртөг нь 2,930 төгрөг болж байна. Үүний 54.6% нь зуучлагчдад очиж байна.

Нэмүү өртгийн үе шат болгоноор тооцсон бөгөөд 1 кг PET-ээс түүхий эд цуглуулагчдад 100 төгрөг, худалдан авагчдад 200 төгрөг, анхан шатны боловсруулах үйлдвэрүүдэд 330 төгрөг, эцсийн шатны боловсруулах үйлдвэрүүдэд 700 төгрөг, дотоодын зах зээлд борлуулснаар худалдааны байгууллагуудад 1600 төгрөгийн нэмүү өртгийг тус тус бий болгож байна. Дахивар хуванцрын нэмүү өртгийн сүлжээний тооцооллоос харахад эцсийн хэрэглэгчид хүргэх үед хамгийн их ашиг хүртэж байгаа бүлэг бол худалдааны байгууллага буюу бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид болон зуучлагчид байна. Энэ жишиг бусад салбарт ч адилхан ажиглагддаг.

*Зураг 3. 2021 оны нэг килограмм PET хуванцрын нэмүү өртөг, төгрөгөөр*




Нэг кг дахивар PET-ээр 40 ширхэг савлагааны бэлдэц үйлдвэрлэдэг ба нэг ширхэг бэлдцийн үнэ 90 төгрөг гэж тооцвол нэг кг хуруу шилний бэлдэц 3600 төгрөг болно.

## Хэсгийн дүгнэлт:

- ✓ Дэлхий нийтийн чиг хандлагыг дагаж, манай улсад ч хог хаягдлыг дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулдаг үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Гэвч дахивар авдаг цэгүүд болон дахивар боловсруулдаг үйлдвэрүүдийн дийлэнх нь нийслэл Улаанбаатар хот, түүний ойр орчим төвлөрч байршжээ. Ялангуяа хуванцар дахивар авах цэгүүд Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд төвлөрсөн байна. Энэ нь төвлөрөл багатай байршилд үйл ажиллагаа явуулж буй дахивар авах цэгүүд байршлын ялгаанаас үүдэлтэйгээр зах зээлд давуу байр суурьтай болох нөхцөл бүрдүүлжээ.
- ✓ Дахивар авах цэгүүд гол төлөв PET, HDPE, PE төрлийн хуванцар цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд өгдөг. 2021 онд тэд нэг килограмм PET хатуу хуванцрыг дунджаар 191 төгрөгөөр, нэг килограмм HDPE зөөлөн хуванцрыг дунджаар 457 төгрөгөөр, нэг килограмм PE гялгар уутыг дунджаар 578 төгрөгөөр тус тус худалдан авсан байна.
- ✓ Улаанбаатар хотын хэмжээнд 2021 оны байдлаар хуванцар дахивар боловсруулдаг 24 үйлдвэр бүртгэлтэйгээс 18 үйлдвэр тогтмол үйл ажиллагаа явуулж, жилд дунджаар 19.2 тэрбум төгрөгийн борлуулалтын нийт орлого олж байна. Тэд нийтдээ жилд 18500 тонн хуванцар бүтээгдэхүүн дахин боловсруулж үйлдвэрлэх хүчин чадалтайгаас 2021 оны байдлаар хүчин чадлынхаа 52.4%-ыг дунджаар ашиглажээ.
- ✓ Үйлдвэрлэгчид ихэвчлэн HDPE, LDPE, PE төрлийн хуванцрыг дахин боловсруулж, түүнийгээ үрлэн бэлдэц хэлбэрийн бүтээгдэхүүн болгон хувиргаж, үйлдвэрлэлийн хэрэглэгчдэд нийлүүлэх хандлага түгээмэл байна. Харин өрхийн хэрэглэгчид рүү

нийлүүлж буй хамгийн түгээмэл бүтээгдэхүүн нь хогны уут байна. Хамгийн түгээмэл боловсруулалт хийдэг HDPE үрлэн бүтээгдэхүүний импортын мэдээлэлд тулгуурлан шинжлэхэд манай улсын үйлдвэрлэгчид одоогийнхоос 3 дахин илүү хэмжээгээр үйлдвэрлэхэд импортыг орлох үрэл үйлдвэрлэх зах зээлийн багтаамжтай байна. Хогны уут, төрөл бүрийн хоолой, багцлагч зэрэг эцсийн бүтээгдэхүүний хувьд импортын бүтээгдэхүүний 0.5%-д ч хүрэхгүй хэмжээтэйг дахин боловсруулж байна. Цаашид үйлдвэрлэлээ өргөтгөж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зах зээлийн багтаамж хангалттай их байна.

- ✓ Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн ажилласан жил, ажилчдын тоо, жилийн нийт орлого, үйлдвэрлэлийн хүчин чадал зэргээс харахад уг зах зээлд янз бүрийн хүчин чадалтай, том, жижиг ялгаатай үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрүүд одоогийн хүчин чадлаа бүрэн дүүрэн ашигладаггүй, ашиглалтын түвшин хангалтгүй байна. Цаашид эдгээр үйлдвэрүүд тоног төхөөрөмж, хүчин чадлаа бүрэн ашиглавал хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэх бүрэн боломжтой байна.
- ✓ Үйлдвэрүүдийн 45% нь анхдагч түүхий эд импортоор авдаггүй, 55% нь импортоор анхдагч түүхий эд авдаг ба ихэвчлэн БНХАУ, БНСУ-аас түүхий эдээ импортолдог. БНХАУ-тай харьцуулахад БНСУ-аас харьцангуй цөөн үйлдвэрлэгч, харьцангуй их хэмжээгээр анхдагч түүхий эд импортолжээ.
- ✓ 2022 оны 7 сарын байдлаар үйлдвэрүүд хуванцар дахивар боловсруулж, ихэвчлэн барилгын материал, багаж, хэрэгсэл, хогийн уут, түмпэн сав, хайрцаг, ширээ сандал зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс гадна PP, HDPE, LDPE зэрэг хагас боловсруулсан үрэл, түүхий эд хийж байна. Тэд өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ сэтгэл хангалуун байдаг ба өрсөлдөгчийн ижил төстэй бүтээгдэхүүний чанар, өнгө, үзэмжийг өөрийнхөөсөө арай доогуур үнэлдэг нь судалгаагаар тогтоогдсон.
- ✓ Зах зээлийн эрэлт хэрэгцээ, дэлхийн чиг хандлага, байгальд ээлтэй эдийн засгийн бүтцийг үүсгэхэд хувь нэмэр оруулах, түүхий эдийн олдоц элбэг, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг шалтгаан нөхцөлийг харгалзан өөрийн үйлдвэрийн хүчин чадал, нөөц боломжид тулгуурлан үйлдвэрлэгчид ойрын таван жилийн дотор **бохирын дотоод шугам, бохирын худгийн өргөн хоолой зэрэг төрөл бүрийн хоолой, тэдгээрийг холбох хэрэгсэл, байшингийн дээвэр, барилгын хуванцар хавтан, цахилгааны хоолой холбогч, дотроо төмөртэй хоолой, разетканы хроп, өвсний уяа, хашааны шон, хүрз, өргөн хэрэглээний шуудай** зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээр бизнест төлөвлөгөөндөө тусгасан байна. Мөн үйлдвэрлэгчид үйлдвэрийн хүчин чадал, тоног төхөөрөмжөө сайжруулж чадвал **цахилгааны хамгаалалтын хоолой, бортого, логотой тор, бохирын хуванцар хоолой, ус зайлуулах шугамын хоолой, хүрз, түмпэн сав, хэв, малын усалгааны ванн, хуванцар болон модны дахиврын үртэс хоёрыг онцгой технологиор хольж, гадна террас шалнууд, гадна сеткан зөөлөвч хийх, цахилгаан хоолой холбогч, дотроо төмөртэй хоолой, унтраалгын разетканы хроп, өвсний уяа, цэвэр, бохир усны хоолой, өргөн хэрэглээний уут, шуудай, өөр олон төрлийн кабел, хуванцар хоолойн дагалдах хэрэгслүүд, агааржуулалтын хоолой, гүний худаг, барилгын хавтан, шат, байшингийн хуванцар дээвэр, хөдөө аж ахуйд хашааны шон** зэрэг олон бүтээгдэхүүнийг шинээр үйлдвэрлэх хүсэлтэй байна.

- ✓ Хуванцар боловсруулах үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ дийлэнх тохиолдолд үйлдвэрлэлийн хэрэглэгчдэд худалдаалдаг. Тал хувь нь бөөний борлуулагчдад бүтээгдэхүүнээ нийлүүлдэг, 27.8% нь ахуйн буюу өрхийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ (сандал, нүхэн жорлонгийн таг, багцлагч уут, бохирын хоолой гэсэн 4 бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байна) зарж, борлуулдаг. Төрийн байгууллагад шууд нийлүүлдэг, эсвэл экспортоор гаргадаг үйлдвэрлэгч тун ховор байна.
- ✓ Хэдийгээр дахин боловсруулах үйлдвэрүүд бүгд Улаанбаатар хотод байрладаг ч тэд Улаанбаатар хотоос гадна хөдөө, орон нутагт бүтээгдэхүүнээ борлуулдаг. Дийлэнх үйлдвэрлэгчид үйлдвэрийн байрнаасаа шууд борлуулалт хийдэг. Бараг бүгд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ бөөнөөр, шууд худалдан авах харилцагчидтайгаа хамтын ажиллагааны гэрээтэй. Үйлдвэрлэгчдийн тал хувь нь гэрээт борлуулагчаар дамжуулж борлуулалт хийдэг бол 1/3 хэсэг нь зах дээр очиж, бүтээгдэхүүнээ худалдаалдаг. Харин тэд сүлжээ супермаркет, супермаркет, 8 нэрийн дэлгүүр, миний маркет, онлайн дэлгүүр зэрэг борлуулалтын сувгийг ер ашигладаггүй байна.
- ✓ Үйлдвэрлэгчид өөрийн бүтээгдэхүүний үнээ тогтоохдоо бүтээгдэхүүний өртөгт тулгуурлах зарчмыг түлхүү баримталдаг ба ижил төрлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэгчийн тогтоосон үнэ, импортын үйлдвэрлэгчийн тогтоосон үнүүдийг харгалзан үздэг. Захиалгын гэрээгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэвэл гэрээнд тохирсон үнээр нийлүүлдэг.
- ✓ Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл, аюулгүй байдал, хүртээмжтэй байдал, тасралтгүй нийлүүлэлт, бүтээгдэхүүний төрөл, хямд үнэ гэсэн зүйлсийг чухалчилж, нийлүүлэлтээ хийдэг. Харин борлуулалтыг нэмэгдүүлэх маркетингийн ямар нэгэн урамшууллын арга, хэрэгсэл ашигладаггүй байна. Борлуулалтаа нэмэгдүүлэхийн тулд тэд тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, түүхий эдийн чанар, түүхий эдийн тогтвортой нийлүүлэлтийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний өнгө үзэмж, загварыг сайжруулах шаардлагатай байгаагаас гадна дахин боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжлэг хүсэж байна.
- ✓ Судалгаанд хамрагдсан 18 үйлдвэрлэгчийн 88.9% нь тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн импортын ижил бүтээгдэхүүнийг орлох, импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх бүрэн боломжтой гэж үзсэн. Гэтэл хуванцар бүтээгдэхүүн импортлогч, борлуулагч мөн 18 оролцогчийн 55% нь дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадваргүй байгаа гэж үнэлсэн бол 17% нь энэ талаар мэдлэг, мэдээлэлгүй байна гэж хариулжээ. Түүнчлэн дахивар боловсруулж, хуванцар бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлдэг үйлдвэрүүдийн хүчин чадал, нөөц боломжийн талаар хуванцар бүтээгдэхүүн импортлогч, борлуулагчдын ойлголт, мэдлэг тааруу байгаа нь судалгаагаар нотлогдсон. Тиймээс үйлдвэрлэгчид өөрийн бүтээгдэхүүний чанар, өрсөлдөх чадварыг олон нийтэд, ялангуяа энэ төрлийн бүтээгдэхүүний худалдагч, борлуулагчдад таниулах, сурталчлах, мэдээлэх шаардлагатай байна.
- ✓ Манай улсад орж ирж буй хуванцар бүтээгдэхүүний импортын нөхцөл байдалд шинжилгээ хийхэд 2019 оны байдлаар БНХАУ, БНСУ, ОХУ, АНУ, Австрали, ХБНГУ, Итали, Япон, Швейцар, Малайз гэсэн улсууд нийт хуванцар бүтээгдэхүүний импортын 90.1%-ыг нийлүүлсэн ба үүн дотроос БНХАУ дангаараа нийт хуванцрын импортын 65.8%-ыг хангасан байна.

- ✓ 2019 оны байдлаар 3601 аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн хуванцар бүтээгдэхүүн импортолсноос эхний 10 аж ахуйн нэгж нийт импортын ¼ хэсгийг хийсэн байна. Тэд ихэвчлэн ус, ундааны савны бэлдэц, түүхий эд, бөглөө, шошго, лац, полиэтилен терефталат, гялгар хальс гэсэн нэр төрлийн бараа, материалыг хамгийн ихээр импортолсон байна.
- ✓ Импортын бүтээгдэхүүнийг барааны нэр төрлөөр ангилбал 2019 онд манай улсад 7000 нэр төрлийн хуванцар бараа, материал импортоор орж ирсэн ба хамгийн их үнийн дүнтэй импортлогдсон 15 бүтээгдэхүүн нийт импортын суурь үнэлгээний ойролцоогоор ¾ хэсгийг бүрдүүлж байна. Эдгээр нь полистирол, полиэтилен, полимер, полиакриламид, хавтан, төрөл бүрийн барилгын материал, бэлдэц, хоолой, бөглөө, хальс, шошго зэрэг үйлдвэрийн орц, уут, хулдаас, сав, порлон зэрэг ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнүүдээс бүрдэж байв.
- ✓ PET дээр жишээ авсан нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдоос хамгийн их нэмүү өртөг зуучлагчид ноогдож байна.

# ДӨРӨВ. ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТИЙН СУДАЛГАА

Энэ дэд бүлэгт өрхийн болон байгууллагын хэрэглэгчийн хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ, хандлага, мэдлэг, ойлголтыг тодорхойлж, хэрэглээний өнөөгийн нөхцөл байдлыг судалж дүгнэнэ.

## 4.1. Өрхийн хэрэглэгчийн хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ, зан төлөв

### 4.1.1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

Судалгаанд Улаанбаатар хотын хотын 9 дүүргээс 343 хэрэглэгч, Булган аймгийн төв болон Хутаг-Өндөр сумаас 50 хэрэглэгч, нийт 393 хэрэглэгчийг санамсаргүй түүврийн аргаар сонгож хамруулсан. Эдгээр өрхийн 8 нь хуванцар бүтээгдэхүүн хэрэглэдэггүй тул судалгаанаас хасагдсан. Тиймээс цаашид үлдсэн судалгаанд хамрагдсан 385 өрхийн мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ. Судалгааг авахдаа хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргыг хэрэглэн утсаар мэдээллийг цуглуулсан. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн ерөнхий мэдээллийг нас, хүйс, ажил эрхлэлтийн байдал, боловсролын түвшин зэрэг үзүүлэлтээр гаргалаа. Оролцогчдын 34% эрэгтэй, 66% эмэгтэй, 63% нь 18-44 насныхан, үлдсэн 37% нь 45-аас дээш насныхан байна.

*График 18. Хүйс, хувиар*




*График 19. Нас, хувиар*




Боловсролын хувьд 47% дээд боловсролтой, 41% нь бүрэн дунд боловсролтой иргэд хамрагдсан.

*График 20. Боловсролын түвшин, хувиар*



Өрхийн сарын дундаж орлогын хувьд 14% нь 500,000 хүртэл, 53% 500,001-1,500,000, 46% 1,500,001-ээс дээш өрхийн орлоготой иргэд ээлж байна. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2022 оны нэгдүгээр улиралд нэг өрхийн сарын дундаж бодит орлогын хэмжээ 1.2 сая төгрөг болсон байна. Судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлого үндэсний өрхийн сарын дундаж орлоготой адил байна.

*График 21. Өрхийн сарын дундаж орлого, хувиар*




Бид бүхэн хэрэглэгчдийн амьдрах орчин, байршлаас хамаарч хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ өөр байна гэсэн таамаглалыг дэвшүүлсэн. Тиймээс судалгаанд оролцогчдыг байршлаар нь ангилсан ба 41% нь орон сууцанд, 56% нь гэр хороололд, 3% нь зуслангийн байшинд амьдардаг өрхийг хамруулав.

### 4.1.2. Хуванцар бүтээгдэхүүний талаарх ойлголт, хандлага

Өрхийн хэрэглэгчдээс хуванцар бүтээгдэхүүний талаарх мэдлэгийг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын **16.3%** сайн, маш сайн мэдлэгтэй, 55.1% дунд, үлдсэн 28.6% мэдлэгийн түвшин дундаас доогуур буюу мэдлэггүй байна.

*График 22. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг хэр сайн мэдэх, хувиар*




Оролцогчдын амьдарч буй байршил, хүйс, насны ангиллаар харьцуулан үзэхэд төдийлөн ялгаа байхгүй байна.

*Хүснэгт 15. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг хэр сайн мэдэх, үндсэн үзүүлэлтээр харьцуулсан, хувиар*

| | | Маш сайн мэднэ | Сайн мэднэ | Дунд зэрэг | Муу мэднэ | Огт мэдэхгүй |
|---|---|---|---|---|---|---|
| Сууцны төрөл | Орон сууц | 3.8% | 15.8% | 57.6% | 14.6% | 8.2% |
| | Гэр хороолол | 0.9% | 13.1% | 52.3% | 17.8% | 15.9% |
| | Зуслан | 7.7% | 7.7% | 69.2% | 7.7% | 7.7% |
| Байршил | Улаанбаатар | 2.7% | 14% | 54.9% | 16.1% | 12.2% |
| | Булган | 0.0% | 14% | 56% | 16% | 14% |
| Хүйс | Эрэгтэй | 1.5% | 11.5% | 57.7% | 17.7% | 11.5% |
| | Эмэгтэй | 2.7% | 15.3% | 53.7% | 15.3% | 12.9% |
| Насны ангилал | 18-29 | 3.6% | 12.6% | 57.7% | 18.9% | 7.2% |
| | 30-44 | 0.8% | 19.1% | 51.1% | 16.8% | 12.2% |
| | 45-59 | 2% | 12.1% | 55.6% | 14.1% | 16.2% |
| | 60+ | 4.5% | 6.8% | 59.1% | 11.4% | 18.2% |

Нийт өрхийн хэрэглэгчдийн 36.6% нь хуванцар бүтээгдэхүүнийг дахин ашигладаг бол, 52.2% нь хуванцар дахивар бүтээгдэхүүнийг ногоон шошготой хогийн саванд ялган ангилж байна.

*График 23. Хуванцар хог хаягдлыг дахин ашигладаг болон ангилан, ялгадаг эсэх, хувиар*




Хуванцар хог хаягдлыг дахин дахин ашигладаг болон ангилан, ялгадаг эсэхийг оролцогчдын амьдарч буй сууцны төрөл, байршил, хүйс, насны ангиллаар харьцуулан үзэхэд төдийлөн ялгаа байхгүй  байна.

*Хүснэгт 16. Хуванцар хог хаягдлыг дахин ашигладаг болон ангилан, ялгадаг эсэх, үндсэн үзүүлэлтээр харьцуулсан, хувиар*

| Харьцуулсан үзүүлэлт | | Хуванцар бүтээгдэхүүнийг дахин ашигладаг | | Хуванцар дахивар бүтээгдэхүүнийг ногоон шошготой хогийн саванд хийдэг | |
|---|---|---|---|---|---|
| | | **Тийм** | **Үгүй** | **Тийм** | **Үгүй** |
| Сууцны төрөл | Орон сууц | 40.5% | 59.5% | 62% | 38% |
| | Гэр хороолол | 34.1% | 65.9% | 44.4% | 55.6% |
| | Зуслан | 30.8% | 69.2% | 61.5% | 38.5% |
| Байршил | Улаанбаатар | 38.5% | 61.5% | 51.6% | 48.4% |
| | Булган | 24% | 76% | 56% | 44% |
| Хүйс | Эрэгтэй | 40% | 60% | 60.8% | 39.2% |
| | Эмэгтэй | 34.9% | 65.1% | 47.8% | 52.2% |
| Насны ангилал | 18-29 | 40.5% | 59.5% | 64% | 36% |
| | 30-44 | 38.2% | 61.8% | 50.4% | 49.6% |
| | 45-59 | 34.3% | 65.7% | 45.5% | 54.5% |
| | 60+ | 27.3% | 72.7% | 43.2% | 56.8% |

Иргэдийн хувьд давхардсан тоогоор 65.7% фейсбүүк, 59.2% телевиз, 22.3% ам дамжсан яриа, 14.3% гэр бүл найз нөхөд, 13% мэдээллийн веб сайтаас хуванцар бүтээгдэхүүний талаарх мэдээллийг авч байна. Ижил төрлийн судалгааны үр дүнтэй харьцуулахад иргэдийн хувьд бусад нийгмийн асуудлын талаарх мэдээллийн телевиз, сонин, веб сайт зэрэг албан ёсны мэдээллийн сувгаас авдаг бол хуванцар хог хаягдлыг дахин ашиглах болон ангилан ялгадаг талаарх мэдээллийг фейсбүүкээс авч байгаа төлөв ажиглагдаж байна.

*График 24. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний талаарх мэдээлэл авдаг суваг, хувиар*



Монгол улсад үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний талаарх хангалттай мэдээлэл бий эсэхийг тодруулахад иргэдийн 5.5% хангалттай мэдээлэлтэй, 33.2% бага зэрэг мэдээлэлтэй, 61.3% мэдээлэл маш хангалтгүй гэсэн хариултыг өгч байна. Үүнээс үзвэл иргэд дотоодод дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний талаар төдийлөн мэддэггүй, энэ талаарх мэдээлэл хангалтгүй байна.

*График 25. Дотоодын дахин боловсруулсан бүтээгдэхүүний талаарх мэдээлэл хангалттай эсэх, хувиар*




### 4.1.3. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний талаар мэдлэг, туршлага

Өрхийн хэрэглээн дэх хуванцар бүтээгдэхүүний хэрэглээний түвшинг авч үзэхэд энэ төрлийн бүтээгдэхүүнээс хогны уут, гялгар уут, гэр ахуйн зориулалтын хуванцар сав, хуванцар усны сав, хуванцар сандал, цэцгийн савны хэрэглээ өндөр байна.

*Хүснэгт 17. Хуванцар бүтээгдэхүүний өрхийн хэрэглээ, хувиар*

| № | Төрөл | Хэрэглэдэг өрх, хувиар | Нэг жилд хэрэглэдэг дундаж тоо | Байршил | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Орон сууцанд | Гэр хороололд | Зусланд |
| 1 | Хогны уут | **92.5%** | 404 | 39.7% | 49.9% | 2.9% |
| 2 | Тор, гялгар уут | **86.2%** | 282 | 36.1% | 47.3% | 2.9% |
| 3 | Гэр ахуйн зориулалтын хуванцар сав | **82.3%** | 5.3 | 33.8% | 45.5% | 3.1% |
| 4 | Усны сав /Канистр/ | **67.8%** | 11.4 | 14.5% | 50.6% | 2.6% |
| 5 | Хуванцар сандал | **64.2%** | 5.2 | 24.9% | 37.7% | 1.6% |
| 6 | Цэцгийн сав | **50.9%** | 7.8 | 25.7% | 23.6% | 1.6% |
| 7 | Хуванцар хоолны сав | 47% | 7 | 19.5% | 25.7% | 1.8% |
| 8 | Хуванцар тоглоом, сувенир | 44.2% | 28 | 18.4% | 23.6% | 0.5% |
| 9 | Хуванцар аяга | 20.8% | 9 | 9.1% | 10.9% | 0.8% |
| 10 | Хуванцар халбага, сэрээ | 11.9% | 12.8 | 5.2% | 6.2% | 0.5% |
| 11 | Бусад | 13.8% | 8.6 | 5.7% | 7.3% | 0.8% |

Нийт судалгаанд оролцогчдын 98% ямар нэг байдлаар хуванцар бүтээгдэхүүн хэрэглэдэг бол, 2% огт хуванцар бүтээгдэхүүн хэрэглэхгүй байна. 2021 оны байдлаар Улаанбаатар хотод 412,527 өрх байгаа, үүнээс 92.5% буюу 381,587 өрх хогны уут

хэрэглэж, нэг өрх жилд дунджаар 373 ширхэг уут хэрэглэдэг гэж үзвэл 142,332,128 ширхэг хогийн уутыг Улаанбаатар хотын хэмжээнд хэрэглэж байна. Хэрэглээний хэмжээг хогийн уутны дундаж үнэ болох 100 төгрөгөөр тооцож үзвэл нийт борлуулалтын хэмжээ **14,233,212,818** төгрөг байна.

*Хүснэгт 18. Хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн боломж, тоогоор*

| № | Төрөл | Хэрэглэдэг өрх, хувиар | Нэг жилд хэрэглэдэг дундаж тоо | Өрхийн тоо | Бүтээгдэхүүний тоо хэмжээ | Нэгжийн үнэ[11] | Мөнгөн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хогны уут | **92.5%** | 373 | 381,587 | 142,332,128 | 100 | 14,233,212,818 |
| 2 | Тор, гялгар уут | **86.20%** | 282 | 355,598 | 100,278,713 | 150 | 15,041,806,990 |
| 3 | Гэр ахуйн зориулалтын хуванцар сав | **82.30%** | 5.3 | 339,510 | 1,799,402 | 2,500 | 4,498,503,803 |
| 4 | Усны сав /Канистр/ | **67.80%** | 2 | 279,693 | 559,387 | 20,000 | 11,187,732,240 |
| 5 | Хуванцар сандал | **64.20%** | 5.2 | 264,842 | 1,377,180 | 15,000 | 20,657,702,052 |
| 6 | Цэцгийн сав | **50.90%** | 7.8 | 209,976 | 1,637,815 | 3,500 | 5,732,351,434 |
| 7 | Хуванцар хоолны сав | 47.00% | 7 | 193,888 | 1,357,214 | 350 | 475,024,841 |
| 8 | Хуванцар тоглоом, сувенир | 44.20% | 28 | 182,337 | 5,105,434 | 4,500 | 22,974,453,684 |
| 9 | Хуванцар аяга | 20.80% | 9 | 85,806 | 772,251 | 100 | 77,225,054 |
| 10 | Хуванцар халбага, сэрээ | 11.90% | 12.8 | 49,091 | 628,361 | 80 | 50,268,890 |
| 11 | Бусад | 13.80% | 8.6 | 56,929 | 489,587 | - | - |

Ирээдүйд хуванцар бүтээгдэхүүний хэрэглээгээ өөрчлөх эсэхийг тодруулахад 3.6% нь хэрэглээгээ нэмэгдүүлнэ, 21% хэвэндээ, 64.7% хэрэглээгээ багасгана, 10.6% огт хэрэглэхгүй гэж хариулсан.

[11] Дэлгүүрт зарагдаж буй дундаж үнээр тооцов.

*График 26. Цаашид хуванцар бүтээгдэхүүний хэрэглээгээ өөрчлөх эсэх, хувиар*




Цаашид хуванцар бүтээгдэхүүний хэрэглээгээ багасгахаар төлөвлөж байгаа тохиолдолд шалтгааныг тодруулахад 3.8% үнэтэй, 3.1% бүтээгдэхүүний төрөл, сонголт бага, 0.3% бүтээгдэхүүний загвар муу, 1.4% олдоц бага, 16.6% үнэртэй, 25.9% чанар, эдэлгээ муутай, 1% өнгөний сонголт бага, 28.3% органик бус бүтээгдэхүүн, 50.3% байгаль орчинд сөрөг, 84.1% эрүүл мэндэд хортой гэсэн шалтгаануудыг дурджээ.

Хэрэглэгдэж байгаа хуванцар бүтээгдэхүүнийг гарал үүслээр нь ангилбал, 60.5% нь Хятад, 28.1% Солонгос, 11.7% Орос, 6.2% Монгол, 6% бусад улс, 27.5% аль нь ч ялгаагүй худалдан авдаг байна. Үүнээс үзвэл хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэгч нь хэн байх нь төдийлөн чухал бус байна.

*График 27. Хаана үйлдвэрлэсэн хуванцар бүтээгдэхүүнийг ихэвчлэн худалдан авдаг болох, хувиар*




Хэрэглэгчдийн хувьд хуванцар бүтээгдэхүүнийг ахуйн хэрэгцээндээ хамгийн өргөн ашиглаж байна. Тухайлбал нийтийн хэрэгцээнд 15.6% байнга хэрэглэдэг бол, ахуйн хэрэгцээнд 33.2%, хоол хүнсэндээ 18.7% нь байнга хэрэглэж байна.

*График 28. Хуванцар бүтээгдэхүүнийг ямар хэрэгцээндээ ихэвчлэн хэрэглэдэг болох, хувиар*



Иргэд хуванцар бүтээгдэхүүнийг ямар тохиолдолд ихэвчлэн хэрэглэж байгааг тодруулахад 48.6% нь гэртээ, 42.3% аяллаар явахдаа, 15.1% ажлын байран дээр, 26% үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхдээ, 6.5% бусад нөхцөлд ашиглаж байна.

*График 29. Хуванцар бүтээгдэхүүнийг ихэвчлэн хаана хэрэглэдэг эсэх, хувиар*




Өрхийн хэрэглэгчдийн хувьд хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авахдаа чанар, эдэлгээ болон хэрэглэхэд хялбар байдал, үнэргүй байх, органик байх, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн байх гэсэн үзүүлэлтийг чухалчилдаг байна.

*График 30. Хуванцар бүтээгдэхүүн худалдан авахдаа чухалчилдаг зүйлс, хувиар*




Хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авах шийдвэр гаргахад нөлөөлдөг хүчин зүйлсийг тодруулахад 64.4% нь өөрийн хэрэгцээнд тулгуурлаж худалдан авалт хийдэг бол 15.6% гэр бүлийн гишүүдийн шийдвэр, 13.2% реклам сурталчилгаа, 10.9% бүтээгдэхүүний үнэ, 9.9% өрхийн орлогын боломжид үндэслэн худалдан авалт хийдэг ажээ.

*График 31. Хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авах шийдвэр гаргахад нөлөөлдөг хүчин зүйлс, хувиар*




Монголд үйлдвэрлэсэн, дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг импортын ижил төрлийн анхдагч түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүнээс илүү өндөр үнээр худалдах тохиолдолд авах эсэхийг тодруулахад хэрэглэгчдийн 42.1% нь худалдаж авна гэж хариулжээ. Харин тухайн бүтээгдэхүүнийг импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад хэдэн хувиар өндөр үнэтэй бол худалдан авах боломжтойг тодруулахад дунджаар 22.4%, хамгийн багадаа 1%, хамгийн ихдээ 100% боломжтой хэмээн үзэж байна.

*График 32. Нэмүү үнээр худалдан авах боломжтой эсэх, хувиар*




Хуванцар бүтээгдэхүүнийг хэрэглэх тохиолдолд ямар түүхий эдээр үйлдвэрлэснийг илүүд үзэхийг тодруулахад 34.3% анхдагч түүхий эд, 7.8% хоёрдогч түүхий эд, 5.7% холимог, 28.8% аль нь ялгаагүй, 23.4% мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн.

*График 33. Хуванцар бүтээгдэхүүнийг хэрэглэх тохиолдолд ямар түүхий эдээр үйлдвэрлэснийг илүүд үзэх вэ?, хувиар*




Өрхийн хэрэглэгчид хуванцар бүтээгдэхүүн болон сав баглаа боодлыг хэрэглэж дуусаад 60% шууд хогийн саванд бусад хогтой хамт хаядаг бол, 16.4% ажил, байрныхаа ангилдаг

хогийн саванд ангилж цуглуулаад дахивар хүлээн авах цэгт урамшуулалтай тушаадаг, 15.3%  нь өөрөө дахин ашиглах болон бусад хэрэгтэй хүнд үнэгүй өгдөг бол, 8.3% бусад арга замаар шийдвэрлэдэг байна.

*График 34. Хуванцар бүтээгдэхүүн болон сав баглаа боодлыг хэрэглэж дуусаад ямар арга хэмжээ авдаг эсэх, хувиар*




Өрхийн хэрэглэгчдийн хувьд хуванцар бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаадаа хэр сэтгэл хангалуун байгааг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 4.7%  маш их, их сэтгэл ханамжтай байгаа бол, 62.6% дунд, үлдсэн 32.7%  сэтгэл ханамжгүй байна

*График 35. Хуванцар бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаадаа хэр сэтгэл хангалуун болох, хувиар*




Цаашид дотоодын үйлдвэрүүдийн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэх хүсэл сонирхлыг тодруулахад 66.2% нь сонирхолтой байна. Дотоодод дахин боловсруулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэж байгаа хуванцар бүтээгдэхүүнийг сайжруулах боломжийг тодруулахад чанар, загвар, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, бүтээгдэхүүний үнийн сонголтыг нэмэх, хольцыг өөрчлөх, хүмүүст таниулах гэсэн саналуудыг онцолсон.

*График 36. Дотоодын дахин боловсруулах үйлдвэрүүд хуванцар бүтээгдэхүүний сайжруулах шаардлагууд, хувиар*




Монголд үйлдвэрлэсэн, дахин боловсруулсан ямар нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглээндээ хэрэглэх сонирхол тодруулахад хэрэглэгчдийн хувьд одоогийн ахуйн хэрэглээнд өргөн хэрэглэгдэж байгаа хуванцар бүтээгдэхүүнийг дотоодын бүтээгдэхүүнээр солих сонирхол өндөр байна. Тухайлбал усны сав, гэр ахуйн бараа, ширээ сандал гм хуванцар бүтээгдэхүүнийг солих сонирхол өндөр байна.

*График 37. Монголд үйлдвэрлэсэн хуванцар бүтээгдэхүүнийг хэрэглэх сонирхол, %*



Өрхийн хэрэглэгчид хуванцар бүтээгдэхүүнийг 56.6% зах, 1.6% үйлдвэрээс, 34.3% сүлжээ супермаркет, 42.6 супермаркет, 23.1% 8 нэрийн дэлгүүр, 14 мини маркет, 12.5% онлайн шопоор үйлчлүүлж авдаг бол, 21% бусад борлуулалтын сувгуудаас худалдан авалт хийж байна.

*График 38. Хуванцар бүтээгдэхүүнийг хаанаас ихэвчлэн худалдан авдаг болох, хувиар*




Өрхийн хэрэглэгчдийн хувьд хуванцар бүтээгдэхүүнийг хоол хүнс, ахуйн болон нийтийн хэрэгцээндээ олон төрөл, хэлбэрээр өргөн ашиглаж байна. Хуванцар бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэхдээ чанар эдэлгээ, өнгө, загварын нэр төрөл болон үнийн чухалчлан үзэж байна. Хуванцар бүтээгдэхүүнийг зах, сүлжээ дэлгүүр, супер маркет зэрэг олон төрлийн борлуулалтын цэгүүдээс худалдан авч байгаа өрхийн хэрэглээний түвшинд хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ өндөр байгааг харуулж байна.

### 4.2. Байгууллагын хэрэглэгчийн хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ, зан төлөв

Тайлангийн энэ хэсэгт аж ахуй нэгж байгууллагын дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ, хэрэглээний цаашдын чиг хандлагын талаарх судалгааны үр дүнг тусгалаа. Байгууллагын судалгаанд бөөний болон жижиглэн худалдаа, барилга, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нэр бүхий 21 байгууллагыг[12] хамруулсан. Энэхүү судалгаанд ААНБ-ийн удирдлага, шийдвэр гаргах түвшний мэргэжилтнүүдийг хамруулсан болно. Судалгаанд хамрагдсан ААНБ-уудын үйл ажиллагаа явуулсан хугацааг авч үзвэл дунджаар 13 жил, хамгийн багадаа 3 жил, хамгийн ихдээ 30 жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байгууллагууд хамрагдсан. Мөн ажилчдын дундаж тоо нь 211 байгаа бол, хамгийн багадаа 4, хамгийн ихдээ 2000 ажилчинтай байгууллагыг хамруулав.

#### 4.2.1. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний талаарх ойлголт, хандлага

Судалгаанд хамрагдсан ААНБ-уудын хувьд хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ өндөр байна. Тухайлбал ААНБ-уудын хувьд үйл ажиллагааны чиглэлээс хамааран хамгийн олон бүтээгдэхүүн хэрэглэдэг байгууллага нь 6-аас олон нэр төрлийн хуванцар бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. Тухайлбал:

[12] Централ Экспрэсс Си Ви Эс /CU/, Шөлөндөө ХХК, Эрүүлмаа ХХК, Тэсо ХХК, All Engineering Service LLC, B&B Construction, Грийн Ресурс Констракшн ХХК, Бадрах өргөө Девелопмент ХХК, LCB LLC, Хөтөл Тэлмэн Констракшн ХХК, Хурд групп ХХК, Хэт хүлэг ХХК, Баганат Өргөө ХХК, Өлзийтийн Хийморь Өөдөө ХХК, Мөнх Эзлэн ХХК, Мөнх Хур ХХК, Овоо хийц ХХК, Хийрэв ХХК, Ойм ногоон урлан ХХК, Сэлбэ плаза ХХК, Сэнтий зочид буудал ХХК

- Бөөний болон жижиглэн худалдаа, нийтийн хоолны салбарын төлөөлөл болох Централ Экспрэсс Си Ви Эс /CU/, Шөлөндөө ХХК, Эрүүлмаа ХХК хувьд нэг удаагийн савлагааны уут, сав, баглаа боодол, бээлий, хогийн уут, нэг удаагийн хоолны сав, нэг удаагийн халбага, сэрээ, кофены хуванцар таг, хогийн уут, хүнсний скоч, хүнсний бээлийг түгээмэл хэрэглэж байна.
- Боловсруулах үйлдвэрлэлийн төлөөлөл болох Тесо ХХК-ийн хувьд Зөв аарцны ундааны (500 гр) савлагаандаа болон савлагааны таглаа, шошгодоо хуванцар бүтээгдэхүүнийг түлхүү ашиглаж байна.
- Барилгын компаниудын хувьд Цэвэр усны шугам /PPR/, Бохир усны шугам /PVC/, Халаалтын шугам /PVC/, Дулаалгын гадуурх хамгаалалтын хуванцар хоолой, Вакум цонхны бэлдцүүд, Арматурын хөндийрүүлэгч, Цахилгааны хамгаалалтын хар хоолой, Цонхны хүрээ, Бариул, Даравч, Амлагаа Резин зэрэгт голлон ашиглаж байна.
- Хүлэмж, газар тариалангийн салбарын төлөөлөл болох Ойм ногоон урлан ХХК-ийн хувьд хуванцар цэцгийн савнууд жижгээс том хэмжээтэй, хүлэмжийн гаднах пластик уут, усалгааны шланк, үрслэгээний сав /бортого/ зэрэгт ашиглаж байна.

ААНБ-уудын хувьд "Бөөний худалдааны төвөөс, гадаадад үйлдвэрлэсэн хуванцар бүтээгдэхүүн"-ийг худалдан авч үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Байгууллагын хэрэглэгчдийн 20% дотоодын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үйлдвэрээс болон бөөний төвүүдээс авч байгаа бол, 80% нь гадаадад үйлдвэрлэсэн импортын бүтээгдэхүүнийг авч байна. Байгууллагын хэрэглэгчдээс цаашид хаана үйлдвэрлэсэн хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авах төлөвлөгөөтэй байгааг тодруулахад 33% дотоод үйлдвэрлэсэн, 38% гадаад үйлдвэрлэсэн импортын бүтээгдэхүүн, 29% аль нь ч ялгаагүй хэмээн үзэж байна.

- **Дотоод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой байгаа хэрэглэгчдийн шалтгааныг тодруулахад:** Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн авч хэрэглэх сонирхол өндөр байна. Гэвч эдгээр хэрэглэгчдийн хувьд дотоод үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдлэг дутмаг, бүтээгдэхүүн үйлчилгээ нь чанарын шаардлага хангасан эсэх нь тодорхой бус, үнийн хувьд импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц биш үнэтэй байдаг гэсэн шалтгаануудыг дурдсан. Мөн байгууллагын хэрэглэгчдийн хувьд дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг авах нь хил гаалийн хорио цээрийн асуудалд орохгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.
- **Гадаадад үйлдвэрлэсэн импортын бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой байгаа хэрэглэгчдийн шалтгааныг тодруулахад:** Хүнсний бүтээгдэхүүний нэг удаагийн сав баглаа боодлын чанар, стандартыг хангасан, олон төрлийг гаргах чадавх сайн, орчин үеийн барилга байгууламжид гадаадын брэндийн бүтээгдэхүүн хэрэглэх тухайн байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, нэр хүндийн баталгаа болж байгаа, дотоодын үйлдвэрлэлүүдийн хувьд бага хэмжээний үйлдвэрлэл явуулж зах зээлээ хангаж чадахгүй хүрэлцээ муу байгаа зэрэг шалтгааныг нэрлэж байна.
- **Аль нь ч ялгаагүй хэмээн үзэж байгаа хэрэглэгчдийн шалтгааныг тодруулахад:** Дотоодын үйлдвэрлэл чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн тохиолдолд авч хэрэглэхэд бэлэн байгааг тэмдэглэсэн. Гэвч дотоодын бүтээгдэхүүн импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад үнийн хувьд өрсөлдөж чадахгүй, зарим тохиолдолд үнэтэй байгааг онцолсон.

*Хүснэгт 19. Хуванцар бүтээгдэхүүн татан авалтын мэдээлэл, хувиар*

| № | ААНБ-ын нэр | Үйлдвэрээс | Бөөний худалдааны төвөөс, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн авдаг | Бөөний худалдааны төвөөс, гадаадад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн авдаг | Өөрөө импортоор оруулж ирдэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Централ Экспрэсс Си Ви Эс /CU/ | | 10% | 80% | 10% |
| 2 | Шөлөндөө ХХК | | 10% | | 90% |
| 3 | Эрүүлмаа ХХК | | 5% | | 95% |
| 4 | Тэсо ХХК | 30% | | | 70% |
| 5 | All Engineering Service LLC | | | 100% | |
| 6 | B&B Construction | | | | 100% |
| 7 | Грийн Ресурс Констракшн ХХК | | | 100% | |
| 8 | Бадрах өргөө Девелопмент ХХК | | | 50% | 50% |
| 9 | LCB LLC | | 50% | 50% | |
| 10 | Хөтөл Тэлмэн Констракшн ХХК | | | 100% | |
| 11 | Хурд групп ХХК | | Туслан гүйцэтгэгч компаниуд | | |
| 12 | Хэт хүлэг ХХК | | | 100% | |
| 13 | Баганат Өргөө ХХК | 10% | | | 90% |
| 14 | Өлзийтийн Хийморь Өөдөө ХХК | | | 100% | |
| 15 | Мөнх Эзлэн ХХК | | | 80% | 20% |
| 16 | Мөнх Хур ХХК | 10% | | 90% | |
| 17 | Овоо хийц ХХК | | | 100% | |
| 18 | Хийрэв ХХК | 100% | | | |
| 19 | Ойм ногоон урлан ХХК | | | 20-13% | 80-87% |
| 20 | Сэлбэ плаза ХХК | 20% | | 80% | |
| 21 | Сэнтий зочид буудал ХХК | 20% | | 80% | |

Байгууллагын хэрэглэгчдийн хувьд импортын бүтээгдэхүүний хил гааль, тээвэр логистик, валютын ханшийн зөрүү, гаалийн татварын асуудал хүндрэлтэй байгаа бол, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувьд чанар, стандартын шаардлага хангасан байдал, хүрэлцээ хангамжийн асуудал хамгийн их бэрхшээлийг дагуулж байна.

*Хүснэгт 20. Байгууллагын хэрэглэгчдийн хэрэглэж буй бүтээгдэхүүний давуу болон сул талууд*

| ***Байршил*** | **Давуу тал** | **Сул тал** |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| **Гадаад** | • Импортын бүтээгдэхүүний давуу тал бол чанар, стандарт маш сайн<br>• Импортын сав нь шингэн хүнс авч явахад асгардаггүй<br>• Олон улсын нэрд гарсан чанартай сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүдтэй хамтран ажилладаг<br>• Олон улсын чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэхэд эргэлзээ бага байдаг | • Хил гаалийн асуудал байна<br>• Тээврийн зардал нэмэгдсэн үнээр худалдаж авч байгаа<br>• Валютын ханшийн зөрүү<br>• Гаалийн татвар |
| **Дотоод** | • Дотоодын үйлдвэрийн вакум цонхны бэлдэц хэрэглэж үзэхэд үнийн хувьд боломжийн, олдоцтой байсан<br>• Дотоодын үйлдвэрээс бүтээгдэхүүн авбал цаг хугацаа хэмнэнэ | • Монголд хүнсний сав баглаа боодлыг үйлдвэрлэх стандарт байгаа эсэхийг мэдэхгүй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үнэртэй хэрэглэхэд тохиромжгүй байдаг<br>• Дотоодын бүтээгдэхүүнүүд чанар, стандарт хангадаггүй тул цаг хугацаа, хөрөнгө санхүүгээр хохирох тохиолдол байсан<br>• Чанар муутай, өнгө хувирах тохиолдол байсан<br>• Дотоодын үйлдвэрийн нөөц, хүрэлцээ муу, бохирын хоолойн дээр байнга хомсдол үүсдэг |

Байгууллагын хэрэглэгчдийн хувьд өнөөдрийн байдлаар өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа хуванцар бүтээгдэхүүнүүдийг дотооддоо үйлдвэрлэх, импортыг орлох бүрэн боломжтой хэмээн үзэж байна.

*Хүснэгт 21. Байгууллагын хэрэглэгчдэд шаардлагатай дотоодын үйлдвэрүүдийн үйлдвэрлэх боломжит импортыг орлох бүтээгдэхүүний жагсаалт*

| № | ААНБ-ын нэр | Импортыг орлох хуванцар бүтээгдэхүүний төрөл |
|---|---|---|
| 1 | Централ Экспресс Си Ви Эс /CU/ | Нэг удаагийн сав баглаа боодол, уут, хогийн уут, кофе болон бусад манайхаас гарч байгаа уух зүйлсийн хуванцар таг гэх мэт |
| 2 | Шөлөндөө ХХК | Нэг удаагийн сав баглаа боодол, Гадна зогсоолын талбайд ашиглах боржуур |
| 3 | Эрүүлмаа ХХК | Сав баглаа боодол |
| 4 | Тэсо ХХК | 500 граммын хуванцар сав /PET/ |
| 5 | All Engineering Service LLC | PPR, PVC,PVC plastma хоолой дотроо хөнгөн цагаантай. |
| 6 | B&B Construction ХХК | Цэвэр бохир усны хоолой, төрөл бүрийн цахилгааны разетканууд, унтраалга |
| 7 | Грийн Ресурс Констракшн ХХК | Барилгад ашиглагдах хуванцраар хийдэг бүтээгдэхүүнүүд |
| 8 | Бадрах өргөө Девелопмент ХХК | Цахилгааны хамгаалалтын хар хоолой, Вакум цонхны бэлдэц |
| 9 | LCB LLC | PPR, PVC - цэвэр усны цагаан хоолойнууд, мөн бохирын хоолой, разетка, унтраалга |
| 10 | Хөтөл Тэлмэн Констракшн ХХК | Усалгааны системийн шланк<br>Цахилгааны хамгаалалтын хар хоолой |

| | | |
|---|---|---|
| 11 | Хэт хүлэг ХХК | Цахилгааны хуванцар хоолой, Цутгалтад хэрэглэдэг том хар разетка |
| 12 | Баганат Өргөө ХХК | Барилгад хэрэглэгдэж байгаа хуванцраар хийж болох бүх л бүтээгдэхүүн, Цахилгааны хамгаалалтын хар хоолой, Арматурын 1, 2-р үеийн хөндийрүүлэгч |
| 13 | Өлзийтийн Хийморь Өөдөө ХХК | Барилгад хэрэглэгдэж байгаа хуванцраар хийж болох бүх л бүтээгдэхүүн |
| 14 | Мөнх Эзлэн ХХК | Цонхны бэлдэц, Цонхны хуванцар тавцан, Цонхны тавцанг 15-60 см хүртэл өргөнтэй |
| 15 | Мөнх Хур ХХК | Вакум цонхны хэрэглэгдэхүүн |
| 16 | Овоо хийц ХХК | Вакум цонхны гаднах хүрээ |
| 17 | Хийрэв ХХК | HDPE, PPR |
| 18 | Ойм ногоон урлан ХХК | Цэцгийн хуванцар савнууд |
| 19 | Сэлбэ плаза ХХК | Өглөөний цайнд хэрэглэгддэг нэг удаагийн маслоны жижиг сав<br>Нэг удаагийн халбага, сэрээ, соруул |

ААНБ-ын хэрэглэгчдийг дотоодын хуванцар дахин боловсруулах үйлдвэрүүдтэй хамтын ажиллагааны гэрээтэй эсэхийг тодруулахад 17.6% буюу 3 байгууллага гэрээтэй байна. Энэ 3 байгууллага нь барилгын болон нийтийн хоолны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд байна. Дээрх байгууллагын хувьд хамтын ажиллагааны гэрээ байгуулахын давуу талыг 2 тал харилцан үүрэг хүлээж, амлалтаа цаг тухайд биелүүлэх болон өөрсдийн хэрэгцээт бүтээгдэхүүнийг шаардлагатай загвар, хэмжээгээр захиалж хийлгэх, ингэснээр үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрөл чанаржих, урьдчилгаа төлбөрийг шилжүүлэх замаар захиалгаар бүтээгдэхүүнээ үйлдвэрлүүлэх боломжтой байгааг онцолж байна.

Дотоодын үйлдвэрүүд хуванцар бүтээгдэхүүн худалдан авахад урамшуулал, хөнгөлөлт үзүүлдэг эсэхийг тодруулахад 16.7% буюу 3 байгууллага урамшуулал хөнгөлөлт авсан байна. Урамшуулал, хөнгөлөлт авч байгаа 3 байгууллагын тухайд (i) төлбөрийн нөхцөл, үнийг харилцан тохиролцох, бартер хийх боломжтой бол, (ii) гэрээний нөхцөлөөр дамжуулан шаардлагатай заалтыг оруулах, (iii) урьдчилгаа төлбөр бага хэмжээгээр шилжүүлэн бүтээгдэхүүнээ захиалах, авах боломжуудыг ашиглаж байна. Харин дотоодын үйлдвэрлэгчдээ танай байгууллагад ямар төрлийн хөнгөлөлт урамшууллыг санал болговол тохиромжтой байгааг тодруулахад:

- Байгууллагын онцлогоос шалтгаалан нэг дор их хэмжээний худалдан авалт хийдэг тул үнийн хөнгөлөлт, урамшуулал санал болгох
- Урамшуулал, хөнгөлөлт санал болгохоос илүүтэй үнийн хөөрөгдөлгүй, тасралтгүй, найдвартай нийлүүлэлт санал болгох
- Байнгын үйлчлүүлэгчийн хямдрал, урамшуулал санал болгох. Мөн олон тоогоор, их хэмжээгээр худалдан авсан тохиолдолд мөн адил хямд үнэ санал болгох
- Үнийн хувьд дотоодын үйлдвэрлэгчид импортын бүтээгдэхүүнээс багаар тогтоох шаардлагатай
- Байнгын харилцагч нартаа үнийн тодорхой хувийн хөнгөлөлт санал болгох гэх мэт саналыг оролцогчдоос гарсан байна.

*ААНБ-ын хэрэглэгчдийн хувьд дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг таван үзүүлэлтээр 1-5 оноогоор (1 бол муу, 5 бол сайн) үнэлүүлэхэд дунджаар 3 оноог авсан.*

*Үүнээс үнэ (2.5 оноо), хүртээмжтэй, тасралтгүй байдал (2.5 оноо) хамгийн бага оноог авсан. Энэ хоёр үзүүлэлт гол сул тал болж байгааг харуулж байна. Харин чанар 3.6 оноо, эрүүл аюулгүй байдал 3.5 оноо, сонголтын төрөл 3.1 оноо авсан нь дунджаас дээш үзүүлэлттэй байна.*

*График 39. Дотоод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний үнэлгээ, Дундаж (1 бага, муу; 5 их, сайн)*




Хэрэглэгчдийн хувьд дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авахдаа 71.4% чанар, эдэлгээ, 61.9% үнэ, 19% эрүүл ахуй, чанарын стандарт хангасан байдал, 19% бүтээгдэхүүний загвар, төрөл, сонголт болон 14.3% орц, найрлага бүхий үзүүлэлтийг голлон анхаардаг байна.

*График 40. Дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авахдаа гол анхаардаг зүйлс, хувиар*




### 4.2.2. Хэрэглэгчийн сэтгэл ханамж, худалдан авах хүсэл сонирхол, хүлээлт

Одоогийн хэрэглэж байгаа дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний хэрэглээндээ сэтгэл ханамжтай байдлыг тодруулахад 27.8% сэтгэл ханамж өндөр, 61.1% дунд зэрэг, 11.1% огт сэтгэл ханамжгүй байна.

*График 41. Дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний хэрэглээний сэтгэл ханамжийн түвшин, хувиар*




Байгууллагын хэрэглэгчдийн 85% нь цаашид дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэх сонирхол байна. Байгууллагын хэрэглэгчдийн хувьд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих сонирхол өндөр байгааг харж болно.

*График 42. Цаашид дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн худалдан авч хэрэглэх хүсэл сонирхол байгаа эсэх, хувиар*




Байгууллагын хэрэглэгчдийн хувьд дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг сайжруулах арга замыг дараах байдлаар тодорхойлж байна. Тухайлбал 50% загварыг сайжруулах, 45% үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, 35% чанарыг сайжруулах, 15% хэрэглэгчдэд таниулах гэсэн тэргүүлэх хүчин зүйлсийг нэрлэсэн.

*График 43. Дотоодод үйлдвэрлэсэн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний сайжруулах шаардлагатай зүйлс, хувиар*




Байгууллагын хэрэглэгчдийн хувьд дотоодын хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нартай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх сонирхлыг тодруулахад 42.9% өөрсдөө дахивраа боловсруулах шинэ үйлдвэр байгуулах төлөвлөгөөтэй байгаа бол, 85.7% нь дахивар бүтээгдэхүүнээ тогтмол нийлүүлэх, 85.7% шинэ бүтээгдэхүүний захиалга өгөх,

28.6%  үйлдвэрт хамтарсан хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байна. Үүнээс үзвэл дотоодын хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд байгууллагын хэрэглэгч нартай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх өргөн боломж байгааг илтгэж байна.

*График 44. Дотоодын хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нартай дараах чиглэлд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх сонирхол байгаа эсэх, хувиар*




Байгууллагын хэрэглэгчдийн 52.4% хог хаягдлаа ангилан ялгаж хаядаг бол, 28.6% хог хаягдлаа дахивар боловсруулах үйлдвэрт нийлүүлдэг, 20% импортын болон үйлдвэрлэгчээс хийх худалдан авалтын гэрээнд бүтээгдэхүүний хуванцар сав баглаа боодлын хог хаягдлыг цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах зардал тусгасан, 4.8% байгууллагын үйл ажиллагааны хүрээнд худалдан авах ажиллагааны журамд дахин боловсруулах боломжтой сав баглаа боодолтой бүтээгдэхүүнийг худалдан авах талаарх заалтыг оруулж өгсөн байна. Харин  байгууллагын худалдан авах ажиллагааны журамдаа дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг тусгасан заалттай байгууллага байхгүй байна.

*График 45. Хог хаягдлаа ангилж, боловсруулж буй байдал болон журам, төсөвт тусгагдсан эсэх, хувиар*




Хуванцар бүтээгдэхүүнийг худалдан, борлуулж байгаа 18 борлуулагч, импортлогчдын судалгаанд хамруулсан. Борлуулагчдын хувьд импортыг орлох хуванцар бүтээгдэхүүний боломжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Сүүлийн жилүүдэд зуслангийн байшинд амьдрах иргэдийн тоо нэмэгдэж байгаатай холбоотой том хэмжээтэй усны нөөцийн сав
- Орон сууцны барилгад зориулсан сэнс, сантехникийн шугам, утасны хамгаалалт, бохирын хоолой, цонхны хаалт, агааржуулалтын хоолой, усны хоолой, салхивчны хаалт гэх мэт БНХАУ-аас нийлүүлж байгаа бүхий л төрлийн хуванцар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой
- Зөөврийн 20, 60 литрийн савыг стандартын шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэж зах зээлд дахин нийлүүлэх
- Мөн өдөр тутмын хэрэглээний хогийн сав, хувин, тор гэх мэт.

Борлуулагчдын хувьд хуванцар бүтээгдэхүүний борлуулалт сайн, эрэлттэй байгааг онцолж байсан. Борлуулагчдаас хэрэглэгчид гадаад, дотоод хуванцар бүтээгдэхүүний алийг нь түлхүү худалдан авч байгааг тодруулахад импортын бүтээгдэхүүнийг ихэвчлэн сонгож байгааг хэлсэн. Үүний шалтгааныг үнэ, нэр төрлийн сонголтод байдал хэмээн борлуулагчид харж байна. Тухайлбал гадаадад үйлдвэрлэсэн усны сав 10,000 төгрөг, Монголд үйлдвэрлэсэн сав 30,000 төгрөгөөр зарагддаг байна. Хамгийн өндөр борлуулалттай сантехникийн хоолой дотоодод үйлдвэрлэсэн нь тохирохгүй, сонгосон загвар байхгүй байх зэрэгтэй холбоотойгоор импортын бүтээгдэхүүнийг сонгодог байна. Өөрөөр хэлбэл борлуулагчид импортын бүтээгдэхүүнийг загвар, хийц, өнгө, үнийн хувьд дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс илүү хэмээн үзэж байна. Хэрэглэгчдийн хувьд

импортын бүтээгдэхүүнээс Солонгос, Орос бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхол өндөр, чанартай хэмээн үзэх хандлага давамгайлдаг. Борлуулагчдын хувьд дотоодын хуванцрын үйлдвэрлэгчид эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрэлт хэрэгцээ, зах зээлийн боломж байгааг онцолж байсан. Мөн хэрэглэгчдийн дунд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих хандлага нэмэгдэж байгааг онцолж байв.

# НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Монгол улсад хуванцар хог хаягдлыг дахин боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах нөхцөл байдалд шинжилгээ хийн, дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн өсөлтөд тулгарч буй сорилт, бэрхшээлийг тодорхойлохын сацуу хуванцар бүтээгдэхүүний эрэлт, түүнд нөлөөлөх өрхийн болон байгууллагын хэрэглэгчдийн зан төлөвийг судалж, цаашид шинээр хөгжүүлэх боломжтой бүтээгдэхүүний нэр төрөл, зах зээлийн багтаамжийг тодорхойллоо.

Ингэхдээ дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээний талаар олон улсын туршлага, чиг хандлагыг судалж, манай улсад энэ төрлийн үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн орчин хэр бүрдсэнийг баримт бичгийн шинжилгээнд тулгуурлан үнэлэв. Түүнчлэн Улаанбаатар хотод байршилтай хуванцар дахивар цуглуулдаг цэгүүд, түүнийг дахин боловсруулдаг үйлдвэрүүд, хуванцар бараа, материал импортлогч, борлуулагчдаас цуглуулсан анхдагч тоон мэдээлэл болон Гаалийн ерөнхий газраас гардаг импортын мэдээлэлд тулгуурлан нийлүүлэлтийн талын шинжилгээг хийв. Харин эрэлтийн талын шинжилгээг хийхдээ Улаанбаатар хотын 9 дүүргээс гадна Булган аймгийн хэрэглэгчдээс асуумж судалгаа авч, анхдагч мэдээлэл цуглуулан, шинжиллээ. Тоон мэдээлэлд тулгуурласан шинжилгээний үр дүнг холбогдох төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүдээс авсан чанарын мэдээллээр баталгаажуулж, дараах нэгдсэн дүгнэлтэд хүрэв.

Дэлхийн хүн амын өсөлт, аж үйлдвэржилтийн хувьсал, хурдац зэргээс шалтгаалж, хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ сүүлийн жилүүдэд хурдтай өссөн ба цаашид ч тасралтгүй өсөх хандлагатай байна. Энэ хэрээр дэлхий нийтэд хог хаягдлын хэмжээ нэмэгдэж, хаягдлыг бууруулах, ангилан, дахин боловсруулж, байгаль орчинд ээлтэй, ногоон эдийн засгийн бүтцийг бий болгохын төлөөх оролдлого эрчимжиж байна. Үйлдвэрлэлийн орцод дахин боловсруулсан түүхий эдийн эзлэх хувь нэмэгдэж, дахивар ашиглах сайн туршлагууд олон улсад нэвтэрч байна.

Хог хаягдал боловсруулах бизнесийн гол тоглогч БНХАУ 2018 оноос эхлэн хаягдал импортлохоо зогсоосноос хойш дэлхийн улс орнууд хаягдлаа хэрхэх талаар сорилттой тулгарсан. Манай улсын хувьд ч энэ асуудалтай нүүр тулж, хуванцар дахиврыг дотооддоо дахин боловсруулах хэрэгцээ, шаардлага илүү ихээр үүсчээ. 2016 оны байдлаар Монгол улс нэг хүнд ноогдох хуванцар хаягдлын хэмжээгээр дэлхийн ТОП 10 улсын 9-д жагссан нь хог хаягдлын менежментийг сайжруулж, хаягдлыг бууруулах, дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай тулгарсны нэг илрэл юм.

Манай улсын хэмжээнд хуванцар дахивар боловсруулдаг 24 үйлдвэрлэгч МХХДБҮХ-д бүртгэлтэй байгаагаас 18 нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Тэднээс авсан асуумж судалгаанаас харахад дахин боловсруулах үйлдвэрүүд 2021 оны байдлаар нийт 19.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллажээ. Зах зээлийн борлуулалтын нийт орлогын 31.3% нь ганц үйлдвэрлэгчид хуваарилагддаг бол 47.4% нь дундаж арван үйлдвэрлэгчдэд, үлдсэн 21.3% нь жижиг долоон үйлдвэрлэгчдэд ноогдож байна.

Үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдийн мэдээлэлд тулгуурлавал манай улс 2022 оны 7 сарын байдлаар нийт 18,500 тонн хуванцар дахин боловсруулах хүчин чадалтай

хэдий ч хүчин чадлынхаа 52.4%-ыг л ашигласан байна. Өөрөөр хэлбэл, тэд нийлээд ойролцоогоор 10,000 тонн дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

Манай улсад дахивар боловсруулж буй үйлдвэрүүд харьцангуй шинэ бөгөөд жижиг үйлдвэрүүд байна. Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүд дунджаар 18 ажилчинтай, гурван үйлдвэр тутмын хоёр нь арав болон түүнээс цөөн жил үйл ажиллагаа явуулж байна.

Үйлдвэрүүд дахивар, түүхий эдээ цуглуулах онцгой тогтсон арга зам, хэв маяг байхгүй. Дахивар цуглуулдаг цэгүүдээс, гэрээт байгууллагуудаас, хувиараа хог хаягдал ангилж, ялгадаг хүмүүсээс, эсвэл өөрсдөө явж дэлгүүрүүдээс цуглуулах зэрэг бүх төрлийн арга замаар түүхий эдээ цуглуулахыг оролддог. Хог хаягдлыг ангилж, ялган, дахин боловсруулах талаар хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүйгээс дахин боловсруулах үйлдвэрүүд хоёрдогч түүхий эдээ цуглуулахад бэрхшээл, хүндрэл үүсдэг байна. Тэд ихэвчлэн HDPE, LDPE, PE төрлийн дахивар авдаг ба 2022 оны 7 сарын байдлаар тэдний цуглуулсан хуванцар дахиврын хэмжээ жилд нийтдээ 8737.2 тоннд хүрчээ. Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн 45% нь химийн нэмэлт бодис, цэвэр хуванцар үрэл зэрэг анхдагч түүхий эдийг ихэвчлэн БНХАУ, БНСУ-уудаас импортолдог бол үлдсэн 55% нь түүхий эд импортолдоггүй, дотоодоосоо хэрэгцээгээ хангадаг ажээ.

Дахивар боловсруулдаг үйлдвэрүүд HDPE, LDPE төрлийн үрэл, хогны уут түлхүү үйлдвэрлэдэг. Цахилгааны хамгаалалтын хоолой, цэвэр, бохир усны хоолой, хуванцар сандал, багцлагч уут зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгддэг хэдий ч үйлдвэрлэгчийн тоо цөөн байна. Тэдний дийлэнх нь эцсийн бүтээгдэхүүнээ үйлдвэрийн газраасаа үйлдвэрлэлийн хэрэглэгчдэд, өртөгт тулгуурласан үнэ тогтоох зарчмаар зарж, борлуулдаг. 18 үйлдвэрээс ганц нь л экспортоор үрэл гаргадаг. Бусад нь Улаанбаатар хот болон хөдөө, орон нутагт бүтээгдэхүүнээ борлуулдаг. Бараг бүх хэлцэл хамтын ажиллагааны гэрээгээр хийгддэг учраас зарим борлуулагчид, өрхийн хэрэглэгчид дахин боловсруулсан бүтээгдэхүүний талаар мэдээлэл муутай байна. Үйлдвэрлэгчид цаашид борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх, зах зээлд бүтээгдэхүүнээ таниулах зорилгоор маркетинг, зар сурталчилгаа хийх, сошиал контент хөгжүүлэх мэдлэг, чадвараа дээшлүүлэх шаардлагатай.

Хуванцар импортлогч, борлуулагчид бүтээгдэхүүний чанар, өнгө, үзэмж, загвар, үнэ зэрэг шалгуурт үндэслэн дахин боловсруулсан бүтээгдэхүүний импортын бүтээгдэхүүнийг орлох, өрсөлдөх чадварыг үнэлж, харьцангуй муу үнэлгээ өгсөн. Өдөр бүр хэрэглэгчидтэй нүүр тулж, бүтээгдэхүүн борлуулдаг борлуулагчдын үзэж байгаагаар корона вируст халдвараас шалтгаалж, хилээр бараа, материал чөлөөтэй орж, гарахгүй энэ үед дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, зах зээлд танигдах, байр сууриа бэхжүүлэх боломж дотоодын үйлдвэрлэгчдэд нээгдэж байна. Гэвч зарим бүтээгдэхүүнийг стандартын дагуу үйлдвэрлэдэггүй, гологдол гардаг. Дотоодын үйлдвэрлэгчдийн хүчин чадал муугаас шалтгаалж, оргил ачааллын үед захиалга авч үйлдвэрлэж чаддаггүй. Заримдаа захиалга авсан хэрнээ хугацаа хоцроодог. Их хэмжээгээр захиалга авах хүчин чадал байдаггүй. Бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд сурталчилж, таниулаагүй байдгаас хэрэглэгчид худалдан авалт хийдэггүй. Үйлдвэрлэгчид борлуулагчдыг урамшуулдаггүй, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэггүй зэрэг хэд хэдэн асуудлыг шийдвэрлэж, сайжруулах шаардлага гэж борлуулагчид үзэж байна.

Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчид цаашид цахилгааны хамгаалалтын хоолой, бортого, логотой тор, бохирын хуванцар хоолой, ус зайлуулах шугамын хоолой, хүрз, түмпэн сав, хэв, малын усалгааны ванн, террасны шал, гадна сеткан зөөлөвч, цахилгаан хоолой холбогч, дотроо төмөртэй хоолой, унтраалгын разетканы хроп, өвсний уяа, цэвэр, бохир усны хоолой, өргөн хэрэглээний уут, шуудай, өөр олон төрлийн кабел, хуванцар хоолойн дагалдах хэрэгслүүд, агааржуулалтын хоолой, гүний худаг, барилгын хавтан, шат, байшингийн хуванцар дээвэр, хөдөө аж ахуйд хашааны шон зэргийг нэмж үйлдвэрлэн бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэх хүсэлтэй байна. Үүний тулд тоног төхөөрөмжөө шинэчилж, үйлдвэрлэлийн хүчин чадлаа сайжруулах шаардлагатай бөгөөд санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудалтай тулгарч байна гэж судалгаанд оролцсон 18 үйлдвэрийн 38.9% нь үзсэн. Мөн тэдний 22.2% дахивар боловсруулах үйлдвэрлэлийн нийлүүлэлтийг тогтвортой явуулахын тулд дахиврын буюу түүхий эдийн чанар, тасралтгүй бэлэн байдал чухал гэж үзжээ.

2020 оны эхээс дэлхий дахинд Ковид-19 цар тахал тархаж, экспорт, импортын урсгал хязгаарлагдсан. Тиймээс энэ судалгаанд Гаалийн ерөнхий газрын 2019 оны хуванцар бараа, материалын импортын мэдээллийг ашиглан, үйлдвэрлэгчид импортын ямар нэр төрлийн бүтээгдэхүүнийг орлуулж, дотооддоо үйлдвэрлэх боломжтой талаар судлан, зах зээлийн багтаамжийг тодорхойлохыг оролдлоо.

2019 оны байдлаар манай улсад нийт 355.4 тэрбум төгрөгийн хуванцар бараа, материал импортоор орж ирсэн байна. Нийт импортын 2/3 хэсэг нь БНХАУ-аас, үлдсэн нь БНСУ, ОХУ, АНУ, Австрали, ХБНГУ зэрэг 80 гаруй улсаас гарал, үүсэлтэй байна. Нийт 3601 аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн бараа, материал импортолсныг Эйч Эм Эн Эйч ХХК тэргүүлж, АПУ, Витафит-Инвест, МСМ групп, Обпластик, Дулаанхөөс, Цонжай, Оюутолгой, гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-тай МСМ групп, Кемекс компаниуд удаалсан байна. Эдгээр хуванцар бүтээгдэхүүн импортлогч томоохон компаниуд ус, ундааны савны бэлдэц, түүхий эд, бөглөө, шошго, лац, полиэтилен терефталат, гялгар хальс зэргийг хамгийн их мөнгөн дүнтэйгээр импортолсон байна. Гэтэл дотоодын дахин боловсруулагч үйлдвэрүүд эдгээр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх төлөвлөгөө байхгүй, үйлдвэрлэх талаар бараг ярихгүй байгаа нь ажиглагдлаа.

Импортын нийт мөнгөн дүнгээр авч үзвэл полиэтилен, полистрол, төрөл бүрийн хоолой, хуванцар бэлдэц, бөглөө, хальс, сав, уут, хавтан, хулдаас, полимер, хуванцар шал, шошго, полиакриламид, порлон гэсэн бүтээгдэхүүнүүд хамгийн их суурь үнэлгээтэй байна. Эдгээр бараа, материалаас төрөл бүрийн хоолой, хуванцар бэлдэц, уут, хуванцар шалыг дотоодын үйлдвэрлэгчид үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байна. 2019 оны байдлаар 30.6 тэрбум төгрөгийн төрөл бүрийн хоолой, 30.0 тэрбум төгрөгийн бэлдэц, 16.3 тэрбум төгрөгийн уут, 8.4 тэрбум төгрөгийн хуванцар шал импортлогдсон. Үүнийг хуванцар дахин боловсруулах дотоодын зах зээлийн борлуулалтын нийт хэмжээ болох 19.2 тэрбум төгрөгтэй харьцуулснаар дотоодын үйлдвэрлэгчид эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэвэл импортыг орлох, борлуулалтын орлогоо нэмэгдүүлэх, зах зээлээ тэлэх потенциал боломж их байгааг харж болно.

Өнөөгийн байдлаар дахин боловсруулах үйлдвэрүүдийн түгээмэл үйлдвэрлэж буй эцсийн бүтээгдэхүүн нь хогны уут бөгөөд 2019 онд 5.1 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний хогны уут импортолжээ. Энэ нь нийт импортын 0.001%-тай тэнцэж байна. Мөн судалгаанд хамрагдсан үйлдвэрүүд бортого, хүрз, хуванцар сандал зэргийг нэмж үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлсэн ба эдгээр нь нийлээд 2019 оны нийт импортын 1%-д ч хүрэхгүй бага хэмжээтэй байна. Өөрөөр хэлбэл, одоогийн

үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэхээр төлөвлөсөн бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээ, импортод эзлэх хувь маш бага байна. Энэ хэрээр зах зээлийн багтаамж бага байхыг үгүйсгэхгүй.

### Өрхийн хэрэглэгчийн эрэлтийн судалгааны дүгнэлт

Өрхийн хэрэглэгчдийн хуванцар бүтээгдэхүүний талаарх мэдлэг дутмаг байна. Улаанбаатар хот, Булган аймгийн өрхийн хэрэглэгчдэд зориулсан хуванцар бүтээгдэхүүний талаарх хангалттай мэдээлэл хангалтгүй байна. Мөн иргэдийн 61.3% нь хуванцар бүтээгдэхүүний талаар мэдээлэл огт авахгүй байна. Хэрэглэгчдийн дийлэнх хуванцар бүтээгдэхүүний талаарх мэдээллийг фейсбүүк болон телевизээс авч байна. Хэрэглэгчдийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд төслийн зүгээс үйлдвэрлэгч байгууллагууд хэрэглэгчдэд чиглэсэн таниулах үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэхэд хамтран ажиллах. Тухайлбал үйлдвэрлэгчдийн зүгээс хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл өгөх танхим, хаягдал хүлээн авах цэг, боловсруулах үйлдвэрлэлийн процессыг харах цонх, өрөө гэх мэт байгуулах. Сүүлийн жилүүдэд байгаль цаг уурын өөрчлөлт, хог хаягдлыг дахин боловсруулах, зохистой зөв хэрэглээг өрхийн түвшинд бий болгохтой холбоотойгоор хогоо ангилан ялгах, дахивар хүлээн авах цэгт хүүхдүүд биечлэн дахивраа тушаах үйл ажиллагаа иргэдийн санаачилгатай хийгдэж байгаа нь ихээхэн үр дүнтэй байгаа. Үүнийг дараагийн шат болох үйлдвэрлэлийн үйл ажиллагааг таниулах, сурталчлах болон бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процессыг харуулснаар бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжих боломж бүрдэнэ. Мөн иргэдийн хувьд үйлдвэрийн нэрийн дэлгүүрээс авсан бүтээгдэхүүний эдэлгээ дууссаны дараа үйлдвэрт буцаан тушаах, түүнээсээ хөнгөлөлт авах зэрэг зах зээлийн болон маркетингийн аргачлалыг нэвтрүүлэх боломжууд бүрдэнэ.

Өрхийн хэрэглэгчдийн дунд хуванцар бүтээгдэхүүнийг ангилан, ялгах болон дахин ашиглах зан үйл бүрэлдэж байна. Учир нь өрхийн хэрэглэгчдийн 36.6% нь хуванцар бүтээгдэхүүнийг дахин ашиглах, 52.2% нь хуванцар дахивар бүтээгдэхүүнийг ногоон шошготой хогийн саванд ялган ангилж байна. Хэрэглэгчдийн хувьд ангилан, ялгах хандлага нэмэгдэж байгаа боловч ачих, тээвэрлэх үедээ ялгахгүй байгаа иргэдийн дунд бий болж байгаа энэхүү эерэг хандлагыг удаашруулж байна. Үйлдвэрлэгчдийн хувьд орон сууцны СӨХ-тэй хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар иргэдийн ангилсан дахиврыг худалдан авах боломж байна. Ингэснээр дахивар буюу хоёрдогч түүхий эдийн цэгээ нэмэгдүүлнэ. Нөгөө талаас хоёрдогч түүхий эдийн хомсдолоос үүдэлтэй өрсөлдөөн, үнийн өсөлтийг хязгаарлах боломж байна.

Өрхийн хэрэглэгчийн хувьд цаашид хуванцар бүтээгдэхүүний хэрэглээгээ 75.4% багасгах болон бууруулах төлөвлөгөөтэй байна. Өрхийн хэрэглээний хогны уут, гялгар уут, гэр ахуйн зориулалтын хуванцар сав, хуванцар усны сав, хуванцар сандал, цэцгийн сав зэрэг бүтээгдэхүүнүүд өндөр хэрэглээтэй байна. Мөн өрхийн хэрэглэгчдийн хувьд дотоод үйлдвэрлэсэн дээрх бүтээгдэхүүнийг худалдан авахад бэлэн байна. Өөрөөр хэлбэл эдгээр төрлийн импортын бүтээгдэхүүнийг дотоод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр солиход бэлэн байна. Хэрэглэгчдийн хэрэглээ өндөр байгаа дээрх бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх, эцсийн бүтээгдэхүүнийг борлуулалтыг сувгуудаар дамжуулан борлуулах хэрэгцээ, боломж байна.

Өрхийн хэрэглэгчдийн хувьд хуванцар бүтээгдэхүүнийг худалдан авахдаа чанар, эдэлгээ болон хэрэглэхэд хялбар байдал, үнэргүй байх, органик байх, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн гэсэн үзүүлэлтүүдийг чухалчилж байна.

Монголд үйлдвэрлэсэн, дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүнийг 42.1% нь импортын бүтээгдэхүүнээс өндөр үнээр худалдан авах сонирхолтой байгаа бол, тухайн бүтээгдэхүүнийг импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад дунджаар 22.4%-аар өндөр үнээр авах сонирхол байна. Өрхийн хэрэглэгчдийн хувьд дотоодын үйлдвэрлэгчдийг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн тохиолдолд худалдан авалт хийхэд бэлэн байна.

